

**“СУРАЛЦАГЧДЫН СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ХӨГЖИЛ”  
БСШУЯ, ЖАЙКА-ИЙН ХАМТАРСАН ТӨСӨЛ**

**БАГА БОЛОВСРОЛЫН БАЙГАЛИЙН УХААНЫ  
ДИДАКТИКИЙН ТӨВ**

**Э.Мөнгөнтулга, Г.Нэргүй, Г.Пунсалпаамуу, А.Бямба,  
Б.Баярчимэг, Ч.Оюунгэрэл, Б.Нарангэрэл**

**ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНГ  
ТОГЛООМЫН ЯВЦАД ТАНИУЛАХ  
АРГА ЗҮЙ**

**Боловсролын түвшин: Бага  
Хичээл: Хүн-Орчин  
Бүлэг сэдэв: «Миний гэр, сургуулийн орчин»**

**ЗӨВЛӨМЖ - III**

Зохиогчийн эрхийг Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага эдэлнэ. Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэх, олшруулахыг хориглоно.

**Улаанбаатар хот  
2009 он**

**DDC**

372,357'07

X - 846

**Зохиогчид:**

Эрдэнэчуулууны Мөнгөнтулга	МУБИС-ийн БУС-ийн багш, докторант
Гүрдагвуын Нэргүй	МУБИС-ийн БС-ийн багш, магистр
Гаадангийн Пунсалпамаауу	МУБИС-ийн БУС-ийн захирал, проф., доктор (Ph.)
Аюушийн Бямба	МУБИС-ийн БУС-ийн багш, дээд проф., доктор (Ph.)
Баатарын Баярчимэг	МУБИС-ийн БС-ийн багш, докторант
Чойсүрэнжавын Оюунгэрэл	УБ хотын 97-р сургуулийн сургалтын менежер, магистр
Баяннамарын Нарангэрэл	Сэлэнгэ аймгийн ЕБ-ын 4-р сургуулийн сургалтын менежер

**Зөвлөхүүд:**

Аkitэry Фүкүчи	Токио Гакүгэй Их сургуулийн профессор
Масахиро Камата	Токио Гакүгэй Их сургуулийн профессор

**Шинжээч:**

Д.Улам-Оргих	МУИС, ФЭС-ийн сургалтын албаны эрхлэгч, доктор
--------------	--

**Туршигч багш нар:**

Ц.Дуламрагчаа	Улаанбаатар хот, 97-р сургууль
Л.Янжинлхам	Улаанбаатар хот, 45-р сургууль
О.Нарангэрэл	Улаанбаатар хот, «Сэтгэмж» цогцолбор сургууль
П.Нармандах	Сэлэнгэ, Хушаат сумын сургууль
М.Эрдэнэбилэг	Сэлэнгэ, 1-р сургууль
О.Буянжаргал	Сэлэнгэ, 4-р сургууль
А.Мядагмаа	Дорнод, 5-р сургууль
Н.Энхбаатар	Дорнод, Хан-Уул цогцолбор сургууль
Д.Наранцэцэг	Дорнод, Матад сумын сургууль

**ISBN 978-99929-0-900-5**

## ГАРЧИГ

<b>Өмнөтгөл</b> .....	4
<b>Төслийн 3 жилийн хугацаанд боловсруулсан зөвлөмжийн онцлогууд</b> .....	9
<b>«Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийг заах арга зүйн зөвлөмжийн зорилго</b> .....	12
<b>Зөвлөмжийн бүтэц, дизайн, ашиглах заавар</b> .....	13
<b>I БҮЛЭГ. ЗУРГААН НАСТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ОНЦЛОГ</b>	
1.1. Хүүхдийн хөгжлийн талаарх үзэл баримтлалын тойм .....	20
1.2. Зургаан настай хүүхэд гэж хэн бэ? .....	28
1.3. Зургаан настай хүүхдийн бие бялдарын хөгжлийн онцлог .....	30
1.4. Зургаан настай хүүхдийн оюун ухаан, танин мэдэхүйн онцлог.....	33
<b>II БҮЛЭГ. «МИНИЙ ГЭР, СУРГУУЛИЙН ОРЧИН» БҮЛЭГ СЭДВИЙН АРГА ЗҮЙ</b>	
2.1. «Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийн киррикюли.....	39
2.2. «Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийн нэгж хичээлийн киррикюли:	
Хичээл 1. Миний эргэн тойронд юу байдаг вэ? 2 цаг .....	44
Хичээл 2. Гэрээс сургууль хүрэх замд 1 цаг .....	52
Хичээл 3. Соёл үйлчилгээний газартай танилцъя 2 цаг.....	56
Хичээл 4. Дүгнэлт хичээл 1 цаг .....	59
2.3. Сурагчдын бие дааж хийх ажил.....	61
<b>III БҮЛЭГ. АРГА ЗҮЙН ТУРШИЛТ БОЛОН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА</b>	
3.1. Туршилт хичээлийн явц, үр дүн .....	90
3.2. Японы хичээлийн туршлага .....	94
3.2.1. Японы бага боловсролын Байгалийн ухааны хичээлийн онцлогоос.....	94
3.2.2. Японы сурах бичгийн онцлог .....	101
3.3. Хичээлийн судалгаа (Жюгё кэнкю-Jyugyo kenkyu) .....	104
<b>Хавсралт</b> .....	109
<b>Ашигласан материал</b> .....	128



## БСШУЯ-НЫ ӨМНӨТГӨЛ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны  
Дэд сайд Ч.Куланда

**Зулын гэрэл тосноос**  
**Шавийн эрдэм багшаас**  
(Монгол ардын зүйр цэцэн үг)

Монгол Улс ерөнхий боловсролын салбарт цогц чадамжид сууринсан бага дунд боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэх (2004), ерөнхий боловсролын сургуулийг 11 жил (2006) ба 12 жил (2008)-ийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх зэрэгцсэн, цогц шинэчлэл хийж байгаа билээ.

Боловсролын дээрх шинэчлэлийн хэрэгжилтийн хувь заяа нь анги танхимд сургалт явуулж байгаа багш нарын мэргэжил, арга зүйн хөгжлийн түвшнээс шууд хамаарна. Шинэ стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд багш нартаа тэдгээрийг хэрэгжүүлэх шинэ арга зүйг эзэмшижүүлэх зайлшгүй шаардлагатай. Хэдийгээр Монголын багш нар итгэл үнэмшил, идэвхи оролдлого сайтай боловч тэр шинэ арга зүй нь өнөөдөр анги болгоны хичээл бүрээр боловсорч бэлэн болоогүй байна. Тэгээд ч шинжлэх ухааны судлагдахууныг боловсролын агуулга биш, харин мэдээлэл-материал болгон ашиглаж тогтвортой ажиллаж, амьдрах арга ухааныг боловсролын агуулга болгох болсон өнөө үед суралцагч энэхүү арга ухаанд өөрийн үйл ажиллагаагаараа суралцах тэрхүү шинэ арга зүйг бүтээнэ гэдэг нэг жилийн, нэг багшийн хийх ажил биш болох нь хэнд ч ойлгомжтой билээ.

Суралцагчдын суралцах арга, багшийн багшлах арга зүйд ихээхэн өөрчлөлт хийж, анги танхимын бодит нөхцөлд явагдаж байгаа хичээлүүдэд хэрэглэгдэж, үр өгөөжөө өгөх шинэ арга, арга зүйг бүтээх шаардлагын дагуу Монгол Улсын БСШУЯ нь Японы ЖАЙКА байгууллагатай хамтран 2006 оноос эхлэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” сэдэвт 3 жилийн хугацаатай төслийг хэрэгжүүлэн дуусаж байна.

Бага, дунд боловсролын шинэ стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын шинэ арга зүйг МУИС, МУБИС-ийн сургалт, судалгааны 4 төвийн 70 орчим судлаачид (профессор, доктор, магиструуд)-ын боловсруулж, Токиогийн Гакүгэй их сургуулийн профессор багш нар зөвлөн тусалж, Улаанбаатар хот, Дорнод, Сэлэнгэ аймгийн нийт 9 сургуулийн багш нартай хамтран туршиж сайжруулсан юм.

Төсөл хэрэгжих 3 жилийн хугацаанд арга зүйн чиглэлээр багш нарт зориулсан нийт 400 хэвлэлийн хуудас бүхий 27 зөвлөмж ном, 8 VCD-ийг бэлтгэн гаргаж, хот, хөдөөгийн бүх сургууль, багш нар эдгээр арга зүйн зөвлөмжийг судлан хичээлдээ турших боломж олгохоор нийт 32400 хувь хэвлэж, Монголын бүх сургуулиуд, холбогдох боловсролын байгууллагуудад хүргүүлсэн билээ. Энэ тоон үзүүлэлтийн цаана олон хүний маш их хүч хөдөлмөр, оюун ухаан шингэсэн болохыг онцлон тэмдэглэхийг хүсч байна. Төслийн явцад багш нар хамтран хичээлдээ бэлтгэх, хичээлд сууж, хичээлийн судалгаа хийх, сургалтын хөтөлбөрөө боловсронгуй болгох, хичээлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шинэ арга зүй, менежментэд суралцсан явдал төслийн үр дүнг тодорхойлох чанарын чухал үзүүлэлт төдийгүй багшийн хөгжлийг тодорхойлох шим шүүс нь юм.

Төслийн үр дүнг нийтийн хүртээл болгох, сургалтын технологид шинэ соёл нэвтрүүлэхэд БСШУЯ цаашид онцгой анхаарал тавих бөгөөд Монголын бүх сургуулийн багш нарын суралцах ёстой зүйлийн нэг нь энэ төслийн үр дүнд боловсорсон “хичээлийн шинэ соёл” байх болно.

“Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийг амжилттай хэрэгжижэд хувь нэмэр оруулсан Монгол Улсын болон Япон Улсын бүх байгууллага, эрдэмтэн, профессор, багш, мэргэжилтэн Та бүхэнд гүн талархал илэрхийлж, эрүүл энх, эрч хүч, амжилт бүтээл хүсэн өрөөе.

## «ЖАЙКА»-ИЙН МОНГОЛ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ӨМНӨТГӨЛ

Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага  
“ЖАЙКА”-ийн Монгол дахь Төлөөлөгчийн Газрын  
Дарга Юкио Ишида

Юуны өмнө “ЖАЙКА”-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хамtran ажилладаг Та бүхэндээ чин сэтгэлийн гүн талархал илэрхийлье. Мөн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн З дахь жилийн зөвлөмжийг боловсруулан хэвлүүлж, Та бүхэнд хүргүүлж байгаадаа туйлын их баяртай байна.

Багш нарт зориулсан энэ зөвлөмжид “Практикт туршин боловсруулсан хүүхдийн чөлөөт сэтгэлгээ, бүтээлч чадварыг хөгжүүлэх” хичээлийн арга зүйг оруулсан юм. Мөн энэ зөвлөмжийн дагуу 8 төрлийн хичээлээр Улаанбаатар хот, Дорнод, Сэлэнгэ аймгийн загвар сургуулиудийн багш нараар туршилт хичээл явуулан, боловсрогдсон арга зүйг туршин, олон дахин засвар оруулж сайжруулсаны үндсэн дээр бий болсон билээ. Мөн З дахь жилийн зөвлөмжийг боловсруулахдаа багш нарын санал бодлыг бүрэн дүүрэн тусгасан юм.

Улс орны хөгжлийн зайлшгүй чухал хүчин зүйлийн нэг нь иргэдийн боловсролын түвшин юм. Тэр тусмаа ирээдүйг авч явах хүүхдүүдийн боловсрол нь аль ч улсын тэргүүлэх ач холбогдолтой асуудал болсоор байна. Тийм ч учраас Монгол улс 2004–2005 оны хичээлийн жилээс “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын шинэ стандарт”-ыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ЖАЙКА болон БСШУЯ хамtran 2006 оны 4 дүгээр сараас “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийг хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд боловсруулсан шинэ арга зүйг нэвтрүүлснээрээ хүүхдүүд “Бие даан өөрөө сурх чадвар”-ыг эзэмших юм. Энэ “Бие даан өөрөө сурх чадвар”-ыг эзэмших нь зөвхөн хүүхэд насны бус насан туршийн үнэт зүйл болох чадварын нэг нь гэж хэлж болох бизээ. Ирээдүйн нийтэд амьдрахад хэрэг болох энэ чадварыг хүүхдүүдэд эзэмшүүлж байгаа нь жинхэнэ “Боловсрол”-ыг олгож байгаа хэрэг гэж би боддог. Ийм чадварыг хүүхдүүд эзэмшихдэд багш нараас их зүйл хамаарна.

Зөвлөмжийг хэрэглэх гэж буй багш нартаа хандан хэлэхэд хичээл бүртээ энэхүү шинэ арга зүйг нэвтрүүлэн хэрэглээсэй гэж хүсэж байна. Багшийн хувьд болон сурагчийн хувьд ч гэсэн суралцах баяр баяслаар бялхсан хичээл болох байх гэж бодож байна. Мөн та бүхнийг хүүхдүүдийн сурх хүсэл эрмэлзлээр дүүрэн байгаа тэр л хүсэл эрмэлзэл сэтгэлийг өдөөж, тэднийг дэмжиж ажиллаасай гэж хүсч байна.

Энэхүү зөвлөмжийн зорьж буй “Хүүхдүүд өөрөө бие даан суралцах чадварыг нээн хөгжүүлэх хичээл” нь нэг өдрийн ч өмнө болтугай аль болох хурдан Монголд мөрдөх стандарт болохыг чин сэтгэлээсээ хүсэхийн ялдамд Та бүхний цаашдын ажил амьдралд өндөр амжилт хүсье.

## ЯПОНЫ ЗӨВЛӨХ БАГШИЙН ӨМНӨТГӨЛ

Токио Гакүгэй Их Сургуулийн  
профессор Акитеру Фүкүчи

### З дахь жилийн зөвлөмжийн хэвлэлтэд зориулав

Хүүхэд тоглонгоо суралцдаг. Хүүхэд тоглоно гэдэг бол зөвхөн өөрийгөө баясгаж байгаа бус орчиндоо байгаа юмын байгаа байдлыг нэг нэгээр нь мэдэж бататгаж байгаа үйл юм. «Бага ангийн байгалийн ухаан» ажлын хэсэг үүнийг сурах үйлд хэрэглээ гэж санаачлан ажиллалаа. «Хүүхдийн хөгжлийг дэмжих»-ийг бодит болгоно гэдэг бол мэдлэгийг хэлж өгөх бус хүүхдийг өөрөөр нь бие даан хийлгэх үйл ба төрөл бүрийн гарын доорх материал ашиглан ямар нэгэн зүйл бүтээлгэх замаар таньж мэдэх үйлийг хялбар дөхөм болгож туслахыг хэлнэ. Тиймээс ийм сурах үйлийн орчинг бий болгох нь хичээлийг удирдах гол үндэс болдог.

Хэрэглэгдэх материал ба сурах орчныг бий болгох, явагдах үйлийн зорилгыг бодон үзэж хичээлийг төлөвлөхөд сургууль болон хүүхдүүдийн өдөр тутмын амьдралын орчин, түүний онцлогийг тусгах нь хэрэгтэй юм.

«Бага ангийн байгалийн ухааны»-ийн ажлын хэсэг төслийн З дахь жилдээ, 2008 оны 9 сараас эхэлсэн 6 настай хүүхэд сургуульд орох болсон өөрчлөлтийг шууд мэдрэн, сургуулийн өмнөх боловсролыг үргэлжлүүлэн үнэхээр л «хүүхдийн хөгжил» гэсэн тэр зүйлийг хичээлийн агуулгад тусгах шаардлагатай тулгарсан юм. Ажлын хэсэг хүүхдийн хөгжлийн алдартай сэтгэл судлаач Выгодскийн сургаалийг баримтлагчийн нэг Элькоини сурган хүмүүжүүлэх онолыг суурь болгон, ойр орчиндоо байгаа байгаль болон нийгэмд (хүн болон мэдээллийг оруулан) байгаа материалыг сурах үйлийг чиглүүлэхэд хэрэглэх, хичээл дэх хөгжил дэвшлийн арга барил ба хичээлийн хэрэглэгдэхүүнийг зохион бүтээх сайжруулахыг нэг цикл болгон хичээл удирдах аргыг зоригтойгоор боловсрууллаа. Тэр сайхан зүтгэлийг биширч байгаагаа илэрхийлье. Хүний орчин бол хүмүүсийн амьдралыг дэмжигч бөгөөд өөрчлөгдөж байдаг зүйл билээ. Үүнтэй зэрэгцэн бодит байдлыг нь шууд тусган авах бус хүүхдийн өөрсдийнх ирээдүйд хүсэж байгаа орчинг зураглуулан, байгаль болон нийгмийг бүхэлд нь ойлгож авахын эхлэл нь нэгдүгээр анги юм.

Японы «Амьдрах ухаан» хичээл нь 1992 онд анх бий болгосон хичээл юм. Орчны өөрчлөлттэй зэрэгцэн байгалийн унаган төрх алдагдан алга болж, мөн гэр бүлийн орчин өөрчлөгдсөнөөр хүүхдийн соёлын дэвшил хүндхэн байдалд орсон аюулыг мэдэрсэн нь энэ өөрчлөлтийн шалтгаан юм. Тиймээс ч гэр бүл, сургууль, орон нутгийн хамтын зүтгэлээр, тухайн орон нутагт зориулсан «хичээл төлөвлөлт»-ийг эрчимтэйгээр хийсэн.

Энэ төслийн туршилт хичээл явуулсан сургууль, багш нарын зүтгэлээр орон нутаг болгонд өөр өөрөөр амьдруулсан хичээлийг харлаа. Цаашдаа «жюгё кэнрю»-г үргэлжлүүлэн өөрийн онцлогтой хичээлийг ихээр бий болгохыг хүсэж байна.

## БАГА БОЛОВСРОЛЫН БАЙГАЛИЙН УХААНЫ АЖЛЫН ХЭСГИЙН ӨМНӨХ ҮГ

Бага боловсролын байгалийн ухааны баг энэ удаа Та бүхэнд зургаан настай нэгдүгээр ангийн «Хүн – Орчин» хичээлийн «Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийг заах арга зүйн зөвлөмжийг хүргэж байна. Энэхүү зөвлөмжийн зорилго нь цэцэрлэгээс анх сургуульд элсэн орж байгаа зургаан настай сурагчдад хэрхэн хялбар аргаар хүрээлэн буй орчинг таниулах, танъж мэдсэн зүйлийг нь хэрхэн биеэр хийж гүйцэтгэх, бүтээх, өөрийн үгээр бусдад тайлбарлах замаар мэдлэг бүтээлгэх явдал юм.

Манай орны хувьд 2008-2009 оны хичээлийн жилээс зургаан настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургаж эхэлсэн нь манай багийн хувьд онцлог үйл явдал болсон. Учир нь, зургаан настай хүүхдүүд 1-р ангид анх шинээр элсэж байгаа, багш нар нь анх бэлтгэгдэж байгаа, ном сурх бичиг, гарын авлага, сурх орчин зэрэг бүгд шинээр эхэлж байгаа нь бидний зөвлөмж боловсруулах, турших үйл явцад нэлээд хүндрэлтэй асуудал болж байлаа. Гэсэн хэдий ч бид эрдэмтэн, багш, арга зүйч нарынхаа тус дэмжлэгтэйгээр зөвлөмжийн анхны хувилбараа боловсруулж туршилт хичээлээ амжилттай явуулаад сайжруулан боловсруулсан зөвлөмжөө хүргэж байна.

Энэхүү зөвлөмжийг бичсэн, туршсан, туршилтад орсон зэрэг бүх оролцогчид маань шинэ учраас алдаа дутагдалтай зүйл байгааг та бүхэн учлан үзэж санал бодлоо бидэнд ирүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Зөвлөмж боловсруулахад үнэтэй санал, хувь нэмрээ оруулсан загвар сургуулиудын багш, арга зүйч, сургалтын менежер, шинжээчдийн баг болон япон зөвлөх багш нартаа талархсанаа илэрхийлье.

Сайн үйлс бүхэн өргөжин дэлгэрэх болтугай.

## ТӨСЛИЙН З ЖИЛИЙН ХУГАЦААНД БОЛОВСРУУЛСАН ЗӨВЛӨМЖИЙН ОНЦЛОГУУД

«Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил» төслийн хүрээнд МУБИС-ийн Багшийн сургуулийн Бага боловсролын байгалийн ухааны дидактикийн төв, БУС-ийн багш нар хамтарсан «Бага боловсролын байгалийн ухааны баг» нь З жилийн хугацаанд ЕБС-ийн 1-3 дугаар ангид үзэх «Хүн-Орчин» хичээлийн тодорхой бүлэг сэдвүүдийг (Хүснэгт 1) заах арга зүйн зөвлөмжийг боловсрууллаа.

Байгалийн ухааны хичээлийн онцлог нь амьд байгалийн үзэгдэл, зүй тогтлыг ажиглах, танин мэдэх, харьцуулан жишиг, турших зэрэг арга зүйд үндэслэн явагддаг. «Хүн-Орчин» хичээл нь суурь боловсролын байгалийн ухааны хичээлийн эхлэл болох тул сурагчдыг багаас нь ажиглаж сургах, ажигласнаа тэмдэглэх, зурах, гарын доорх материал ашиглан бодит зүйлийг хийж бүтээх зэрэг ур чадварыг эзэмшүүлэхийн зэрэгцээ байгалиа хайлтрах, хамгаалах үзлийг төлөвшүүлж эхэнэ.

Бид Та бүхэнд төслийн З жилийн явцад боловсруулсан зөвлөмжүүдийн онцлогийг тус бүрээр товчхон танилцуулж байна. Үүнд:

### **Зөвлөмж -1. Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй**

Энэ зөвлөмжид 2-р ангийн Хүн-Орчин хичээлийн «Ургамал бидний орчин» бүлэг сэдвийг заах арга зүйг оруулсан. Амьд биеийн хөгжлийн ерөнхий зүй тогтлыг хүүхдэд ойр байдаг ургамлын жишээн дээр таниулах зорилготой.

Энэхүү зөвлөмжид жишээ болгон авсан бүлэг сэдэв нь хүүхдүүд ажиглаж тэмдэглэх, судалгааны энгийн аргыг хэрэглэх, хялбар туршилт хийх замаар хүрээлэн буй орчинд байгаа ургамлаа таньж нэрлэх, юунд хэрхэн хэрэглэдэг, ямар ач тустай, хэрхэн өсч хөгждөг, ямар бүтэцтэй болохыг амьд биеийн хөгжлийн жишээ болгон танин мэдэх онцлогтой. Зөвлөмжийг ашиглахын өмнө танилцсан байх зааврыг дараах байдлаар оруулсан. Үүнд:

- Хичээлийг багаар зохион байгуулж багийн үйл ажиллагааны явцыг нарийвчлан ойлгуулна. Тухайлбал, багийн ахлагч болон бусад гишүүн бүрийн үйл ажиллагааг сайтар боловсруулсан аргачлалаар зохион байгуулах, үнэлгээний шалгуур, хэлбэрийг оновчтой сонгох. Багийн гишүүн бүр асуултанд хариулах, зураг, бүдүүвч, өгөгдсөн мэдээлэлтэй бие даан танилцан, бодож ухааран, томъёолж, дүгнэлт гаргахад цаг хугацааны болон материаллаг орчны нөхцлийг бүрдүүлэх. Баг дотроо багийн гишүүн бүр мэдсэн зүйлээ бусдадаа ярих, бусдын яриаг сонсох, харилцан санал бодлоо солилцох боломжийг олгох үе шаттай үйл ажиллагааг анхаарах.
- Шинэ хичээлийг сэдэлжүүлэх, хичээлийн бататгал, дүгнэлтийг хийхдээ олон янзын арга зүйг хэрэглэн орчин нөхцөл зургаар, бүдүүвчээр, асуултаар, хүрээлэн буй орчны бодит жишээ болон тоглоомын хэлбэрээр хийж болно.
- Сурагчдыг үйл ажиллагаанд татан оролцуулах замаар мэдлэг, чадвар, чадамжуудыг эзэмшүүлэхдээ багш болон таны сурагчид хэрхэн хөгжиж буй давуу талыг нь өмнөх түвшинтэй харьцуулан ажиглаж судлаарай.
- «Ургамал– бидний орчин» бүлэг сэдвийн нэгж хичээлийн сэдвүүдийг сурагчдад энгийн, ойлгомжтой үгээр арга зүйдээ тохируулан нэрлэхийг хичээлээ. Харин зөвлөмжийн багшид зориулсан мэдээлэлд шинжлэх ухааны нэр томъёогоор оруулж өгсөн болно.

- Бүлэг сэдвийн доторх нэгж хичээлийн хөтөлбөрийг нарийвчлан хийж оруулсан бөгөөд багш та бүхэн орон нутгийнхаа онцлог, материаллаг нөхцөлдөө зохицуулан арга зүй, хичээлийн хэрэглэгдэхүүнийг уян хатан байдлаар сонгон хэрэглэхийг зөвлөж байна.

### **Зөвлөмж – 2. Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй**

Энэ зөвлөмж нь Хүн – Орчин хичээлийн 3-р ангийн «Манай орны байгаль» бүлэг сэдвийг хэрхэн заах арга зүйн тухай болно. Зөвлөмжийн зорилго нь «Хээр тал»-ын жишээн дээр суралцагчдад Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгмийн ялгаатай байдал, тэдгээрийн онцлог болон харилцан шүтэлцээг орон нутгийн байгалийн онцлогт тулгуурлан таниулах явдал юм.

«Манай орны байгаль» бүлэг сэдвийн хүрээнд эзэмшүүлэх мэдлэгийг багш шууд тайлбарлах болон мэдээлэл дамжуулах бус гарын доорх материалыг ашиглан ажиглалт, туршилт явуулах, харилцан ярилцах замаар сурагчид өөрсдийн бүтээлч үйл ажиллагаагаар бие даан мэдлэг бүтээж байгалийн тухай танин мэдэхүйн оюуны болон үйлийн аргатай танилцаж зохих түвшинд эзэмших болно.

Энэхүү бүлэг сэдвээр дамжуулан эзэмшүүлж байгаа хүрээлэн буй орчны тухай мэдлэг нь хувь хүн болон байгаль, нийгэм, эрүүл мэндэд ямар ач холбогдолтой болохыг ойлгуулж улмаар байгаль орчноо болон өөрийгөө, бусдыг хайлрадаг, хамгаалдаг, улмаар нийгмийн амьдралд идэвхтэй, хариуцлагатай оролцдог иргэнийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

### **Зөвлөмж – 3. «Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй»**

Энэхүү зөвлөмжийн зорилго нь анх удаа 6 настай 1-р ангид элсэн суралцаж буй бяцхан сурагчдад биднийг хүрээлэн буй орчинг хэрхэн энгийн хялбар аргаар таниулах явдал юм. Энэ насны сурагчид нь дөнгөж цэцэрлэгийн наснаас сургуулийн орчинд орж ирж байгаа бөгөөд тэдний насны онцлог нь тоглох, дуурайх, хийсвэрлэн сэтгэх зэрэг оюуны үйлийн хамгийн энгийн шатанд байгаа. Иймээс бид энэхүү зөвлөмжөө «Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй» хэмээн нэрлэсэн.

Энэ удаагийн зөвлөмжийн арга зүйн онцлог нь бага насны сурагчдад хэрхэн тоглоомын явцад мэдлэг бүтээлгэх явдал юм. Суралцагчид тоглонгоо суралцах, суралцангаа тоглох гэсэн ерөнхий арга зүйгээр нэгж хичээл бүрийн арга зүйг боловсруулсан. Энэ бүлэг сэдвийг заахын тулд зөвлөмж ашиглах заавартай сайтар танилцаарай (Хуудас 13)

## Хүснэгт 1

Бага боловсролын байгалийн ухааны багийн 3 жилийн хугацаанд  
боловсруулсан зөвлөмжийн бүтэц, агуулга

№	ОН	Зөвлөмжийн нэр	Анги	Цаг	Бүлэг сэдвийн нэр	Нэгж хичээлийн сэдвийн нэр
1	2007	Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй	2-р анги	8	Ургамал бидний орчин	1. Ургамал бидний амьдралд 1.1. Ургамлыг юунд хэрэглэдэг вэ? 1.2. Таримал ургамал 2. Ургамал ургахад юу хэрэгтэй вэ? 2.1. Тасалгааны цэцгийн ургах нөхцлийг тодорхойлох нь 2.2. Ургамал ургахад юу хэрэгтэй вэ? 3. Ургамлын өсөлт, бүтэц ба хэлбэр 3.1. Ургамал өсөж том болох нь 3.2. Ургамал юунаас бүтдэг вэ? 3.3. Модлог, сөөглөг, өвслөг ургамал 4. Ургамал – амьд бие 4.1. Ургамал амьд бие болох нь
2	2008	Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй	3-р анги	12	Манай орны байгаль	1. Орчноо ажиглацаа 1.1. Бидний эргэн тойрны газрын гадаргын хэлбэр 1.2. Манай орны гол мөрөн 1.3. Өнөөдөр гадаа ямар байна вэ? 1.4. Одоо ямар улирал болж байгаа вэ? 2. Манай орны байгаль олон янз 2.1. Манай орны ой тайга, хээр тал, говь цөл 2.2. Бидний мэдэх амьтан 2.3. Бидний мэдэх ургамал 2.4. Хүмүүсийн эрхлэх ажил хөдөлмөр
3	2009	Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй	1-р анги	8	«Миний гэр-сургуулийн орчин»	5. Миний эргэн тойронд юу байдаг вэ? 6. Гэрээс сургууль хүрэх замд 7. Соёл үйлчилгээний газартай танилцъя 8. Дүгнэлт хичээл

## «МИНИЙ ГЭР, СУРГУУЛИЙН ОРЧИН» БҮЛЭГ СЭДВИЙГ ЗААХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖИЙН ЗОРИЛГО

Энэхүү зөвлөмжийн зорилго нь анх удаа сургуульд элсэн суралцаж буй бяцхан сурагчдад биднийг хүрээлэн буй орчинг хэрхэн энгийн хялбар аргаар таниулах явдал юм. Энэ насын сурагчид нь дөнгөж цэцэрлэгийн наснаас сургуулийн орчинд орж ирж байгаа бөгөөд тэдний насын онцлог нь (20-р хуудаснаас үзээрэй) тоглох, дуурайх, хийсвэрлэн сэтгэх зэрэг оюуны үйлийн хамгийн энгийн шатанд байгаа. Иймээс бид энэхүү зөвлөмжөө «Хүрээлэн буй орчинг **тоглоомын явцад** таниулах арга зүй» хэмээн нэрлэлээ.

Тоглоом – олон янз. Хөгжих тоглоом, дуурайх тоглоом, зугацах тоглоом гэх мэт. Энэ зөвлөмжид өгүүлэх тоглоом нь хүүхдийн сурч хөгжихөд чиглэгдсэн тодорхой зорилго чиглэлтэй тоглоом юм.

1 дүгээр ангийн сурагчдын нэгэн онцлог нь аливаа зүйлийг минийх, миний юм гэж хэлэх дуртай байдаг учир бид сонгон авсан бүлэг сэдвээ «**Миний гэр, сургуулийн орчин**» хэмээн хүүхдэд ойрхон байдлаар нэрлэсэн. Энэ бүлэг сэдэв нь дараах хичээлүүдийг багтаах бөгөөд мөн хүүхдэд ойрхон дотно хялбар байхаар бодож нэгж хичээлүүдээ нэрлэсэн. Үүнд:

1. Миний эргэн тойронд юу байдаг вэ? – 2 цаг
2. Гэрээс сургууль хүрэх замд – 1 цаг
3. Соёл үйлчилгээний газартай танилцуяа – 2 цаг
4. Дүгнэлт хичээл – 1 цаг

Энэ бүлэг сэдвийг үзэх **хэрэгцээ** шаардлагыг бид дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд: 6 настай хүүхдүүд аливаа зүйлийг таньж мэдэх гэсэн сониуч зантай, яагаад, ямар учраас гэдэг асуултыг эцэс төгсгөлгүй ихээр асуудаг бөгөөд өөрсдөө сургуулийн өмнөх боловсрол буюу цэцэрлэгт байхдаа болон гэр бүлийн орчноос, аав ээжээсээ олж авсан өмнөх мэдлэг төсөөлөлтэй байдаг. Энэ өмнөх мэдлэг нь тулгуурлан хүрээлэн буй орчинтой нь илүү ойрхон танилцуулах, тэнд юу байдаг, юу гэж нэрлэдэг, ямар олон янз байдаг болохыг өөрсдийнх нь сониуч зан, ихийг мэдэх гэсэн хүсэл эрмэлзэлтэй нь уялдуулан мэдлэг бүтээлгэх явдал юм.

**Агуулгыг** сонгохдоо Хүн – Орчин хичээлийн интеграци (Байгаль, Нийгэм, Эрүүл мэнд) байдлыг харгалзахын зэрэгцээ монгол орны байгаль, нийгмийн ялгаатай байдлыг тусгахыг хичээсэн. Жишээ нь, Миний эргэн тойронд юу байдаг вэ? сэдэвт хичээлийн арга зүйг боловсруулахдаа хот, хөдөө орон нутагт хaa хаана нь элбэг тохиолддог зүйлсийг (байшин, барилга, хашаа, шувуу, мод, чулуу, нохой, үхэр, мал гэх мэт) оруулсан. Хүүхдүүд гадаа талбайд орчноо ажиглахдаа анги хамт олноороо, эсвэл багаар, хосоороо ярилцаж өөрсдийн харсан зүйлээ нэрлэнэ. Гадаа талбайд гарахдаа цаг агаарын байдалд тохируулан зөв хувцаслах бөгөөд гаднаас орж ирэнгүүт гарсаа сайтар угааж, цэвэрлэх талаар зөвлөмжилж оруулсан (Хичээл 1-ийг харна уу).

## ЗӨВЛӨМЖИЙН БҮТЭЦ, ДИЗАЙН, АШИГЛАХ ЗААВАР

Зөвлөмжийг дараах бүтэцтэйгээр боловсрууллаа. Үүнд:

- Өмнөх үг
- Зөвлөмжийн зорилго
- I бүлэг. Зургаан настай хүүхдийн хөгжлийн ерөнхий онцлог
- II бүлэг. «Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийн арга зүй
- III бүлэг. Арга зүйн туршилт болон хичээлийн судалгаа
- Хавсралт
- Нэр томъёоны тайлбар
- Ном зүй

**I бүлэгт** зургаан настай хүүхдийн хөгжлийн ерөнхий онцлогийг оруулсан. Үүнд: бие бялдрын, оюун ухаан болон танин мэдэхүйн онцлогийг тус бүр онол, бодит жишээнд тулгуурлан бичлээ (хуудас 14 – 38).

Аливаа хичээлийг удирдан явуулж буй багш тухайн ангийн хүүхдүүдийнхээ нас, сэтгэхүйн онцлогийг харгалзан хичээлийн агуулга, арга зүйгээ сайн боловсруулах нь хичээлийн явц, үр дүнд чухал хувь нэмэр болох нь гарцаагүй юм. Ялангуяа манай орны хувьд анх удаа сургуульд элсэн орж буй 6 настны хөгжлийн онцлогийг мэдэх явдал чухал. ЕБ-ын 12 жилийн сургалтад шилжсэнтэй холбогдож БСШУЯНЫ дэргэд байгуулагдсан багууд хичээл бүрийн Үндэсний хөтөлбөр хийж байгаа бөгөөд цаашид үүнийг ашиглах багш нар өөрийн сургалтын хөтөлбөртөө энэхүү нас, сэтгэхүйн хөгжлийн ерөнхий онцлогийг үргэлж харгалзах хэрэгтэй.

**II бүлэгт** «Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийн киррикюлим болон нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөрийг оруулсан. Бүлэг сэдвийн киррикюлинийг дараах бүтэцтэй гаргасан. Үүнд:

- |   |   |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> <li>- Хамрах хүрээ</li> <li>- Хэрэгцээ</li> <li>- Зорилго</li> <li>- Зорилт</li> <li>- Агуулга (судлагдахуун, ур ухаан)</li> <li>- Арга зүй</li> <li>- Хэрэглэгдэхүүн</li> <li>- Хичээлийн явц</li> <li>- Үнэлгээ</li> </ul> | <div style="display: flex; justify-content: space-between; align-items: flex-end;"> <div style="flex-grow: 1;"> <div style="display: flex; justify-content: space-between; align-items: flex-end;"> <div style="flex-grow: 1;"> <span style="font-size: 1.5em;">}</span> </div> <div style="font-size: 1.5em; margin-top: -10px;">Ерөнхий</div> </div> <br/> <div style="display: flex; justify-content: space-between; align-items: flex-end;"> <div style="flex-grow: 1;"> <div style="display: flex; justify-content: space-between; align-items: flex-end;"> <div style="flex-grow: 1;"> <span style="font-size: 1.5em;">}</span> </div> <div style="font-size: 1.5em; margin-top: -10px;">Нэгж хичээл бүрээр</div> </div> </div> </div> </div></div> |
|---|---|

Нэгж хичээлийн хөтөлбөр тус бүр дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Хичээлийн сэдэв
- Зорилго
- Зорилт
- Агуулга
- Арга зүй

- Хэрэглэгдэхүүн
- Хичээлийн явц

Хичээлийн **зорилгыг** тодорхойлоходоо тухайн сэдвийн дор суралцагчдын эзэмшвэл зохих цогц чадамжид оруулах хувь нэмэр байдлаар тодорхойлно. Аливаа төлөвлөлтөд үйлийн зорилго нь шийдвэрлэх ёстой асуудлын шалтгаан – үр дагаврын нэгдлийг хангах чиглэлд хийх өөрчлөлтийн гол үзэл санааг нэг өгүүлбэрээр томъёолсон байна. Харин зорилтууд нь энэ зорилго – үзэл санаандаа хүрэх алхам, арга замуудыг нарийвчлан задалсан хэд хэдэн өгүүлбэрээр тодорхойлогдсон байна.

Үйлийн зорилтууд нь хэмжигдэж, үнэлэгдэх бололцоотой байхаар тодорхойлогдож, харин бүх зорилтуудын хэрэгжилтээр тухайн үйлийн зорилго нь биелэгдсэн эсэх нь үнэлэгддэг байна [11].

Нээлттэй киррикюлиний бодлого нь сургууль, багш нарт сургалтын **агуулгыг** өөрийн сургуулийн болон орон нутгийн онцлогт тохируулан сонгон хэрэгжүүлэх боломжийг олгож байна. 21-р зуунд шинжлэх ухааны мэдлэгийг хэрэглэх арга ухаан, суралцагчдад төлөвших ур чадварт түлхүү анхаарах болсон нь урьдын шинжлэх ухааны бүтэц, ололт амжилтыг шууд хуулбарлан тусгаж ирсэн уламжлалт хэлбэрээс ялгаатай болсон. Иймээс сурагчдын мэдлэг бүтээх үйл нь сургалтын цөм агуулга юм. Хэрвээ сургалтын агуулга нь суралцагчийн боловсрол эзэмших үйл нь юм бол сургалтын агуулгаа боловсруулахдаа аливаа үйлд тавигдах үндсэн шаардлагыг хангасан байх ёстай. Иймд аливаа үйл нь заавал тодорхой зүйлтэй, тодорхой аргаар харьцаж гүйцэтгэгддэг учраас сурагчийн үйлийн суралцах зүйл ерөнхий утгаар нь сургалтын агуулгын судлагдахууны тал болно. Харин энэхүү судлагдахуунтай харьцаж түүнийг судлах, өөрчлөн хувиргах арга ухаан нь сургалтын агуулгын ур ухааны тал болно [11]. Тухайлбал, суралцагчдыг орчин тойронтой нь танилцуулья гэвэл, энэ сургалтын агуулга нь нэг талаас, хүрээлэн буй орчин, эргэн тойронд байгаа эд, юмс, түүний бүтэц, хэлбэр дүрс, дуу, өнгө зэрэг нь судлагдахуун, нөгөө талаас орчноо ажиглах, тайлбарлах, нэрлэх, зурах, бүтээх зэрэг нь ур ухааны асуудал болно.

Сургалтын киррикюлиний **арга зүйг** төлөвлөхдөө хичээлийн хэлбэр, арга, хэрэглэгдэхүүнийг сонгох, боловсруулах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Сургалтын арга хэлбэрээр дамжин багш сурагчийн хамтын ажиллагаа хэрэгждэг. Аль шатанд ямар арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх вэ гэдэг нь зөвхөн багшийн ур чадвартай холбоотой. Сүүлийн үед «идэвхтэй сургалтын арга», «бүтээлч сэтгэлгээний арга» гэх зэрэг ерөнхий нэрийн дор орчин үеийн суралцахуйн сэтгэл судлал, арга судлал, социологи, дидактикийн үндсэн дээр боловсруулсан тодорхой аргыг амжилттай хэрэглэж байна. Хэрэв эдгээр аргын мөн чанар, суралцахуйн сэтгэл судлалын үндсийг ойлгохгүйгээр механикаар хуулбарлан дуурайж хэрэглэвэл бодит үр дүнд хүрэхгүй, зөвхөн хэлбэрдэлт болох талтай [11].

Сургалтын арга хэлбэрт тохируулан **хичээлийн хэрэглэгдэхүүнийг** сонгоно. Үүнд, самбар, шохой, үзэг, хаандаа, цаас гэх мэт хичээлийн үндсэн хэрэглэлээс гадна тухайн хичээлээр ашиглагдах үзүүлэн, бодит үзүүлэн, тарааж өгөх материал, дүрс бичлэг, аудио, видео хуурцаг, компьютер, проектор гэх мэт туслах хэрэгслийд орно. Мөн түүнчлэн тухайн хичээлийн онцлогоос хамаарч сурагчдын хийсэн бүтээл, байгалийн бодит материал, тоглоом зэрэг шаардлагатай бүх хэрэгслийг оруулна. Сүүлийн үед сургалтын хэрэглэгдэхүүнийг гарын доорх материал ашиглан сурагчдаар өөрсдөөр нь бүтээлгэх нь илүү бодитой, үр дүнтэй, хүртээмжтэй байгаа

нь япон улсын туршлагаас харагдаж байна. Ялангуяа, байгалийн ухааны хичээлд хэрэглэхэд хялбар байгаа бөгөөд бид үүнийг туршиж үзэн амжилттай хэрэгжүүлэх алхам хийгдэж эхлээд байна. Жишээлбэл, мод, чулуу, навч, боргоцой ашиглан сурагчид өөрсдийн ажигласан, таньж мэдсэн зүйлсээ хийж бүтээн, түүнийгээ хичээлдээ хэрэглэх, олж авсан мэдлэгээ бататгах хэлбэрээр ашиглаж байна (III бүлэг. Туршилт хичээлийн явц үр, дүнгээс үзнэ үү).

**Хичээлийн явцыг** дараах бүтцээр оруулсан.

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл
Сэргээн санах Сэдэлжүүлэх Бүтээх Алжаал тайлах Бататгах Үнэлгээ Дүгнэлт Гэрийн даалгавар			

Хичээл тус бүр дээрх үе шаттайгаар явагдана. Үе шат бүрт багш, сурагчийн үйл ажиллагааг дэлгэрэнгүй оруулж өгсөн. Багшийн үйл ажиллагааны хэсэгт тухайн үе шатанд багшийн хэлэх үг, асуух асуулт, нэмэлт тайлбар зэргийг дэлгэрэнгүй оруулж өгсөн бөгөөд зарим анхаарвал зохих чухал хэсгийг өнгөөр ялгаж тодруулж өгсөн.

Сурагчийн үйл ажиллагааны хэсэгт тухайн үе шат бүрт багшийн асуусан асуултад сурагчдын хариулж болох боломжит хариултуудыг оруулсан бөгөөд хэрвээ багшийн хүссэн хариулт гарагчийг байх тохиолдолд хэрхэх талаар багшийн анхаарах зүйлийн хэсэгт оруулж өгсөн. Мөн энэ хэсэгт тухайн хичээлээр багшийн анхаарах зарим зүйлийг тодруулж оруулсан.

Бидний энэхүү арга зүйн зөвлөмж нь «Хүн - Орчин» хичээлийн зөвхөн нэг бүлэг сэдвийг заах арга зүйн нэгэн хувилбар бөгөөд багш үүнийг өөрийн нөхцөл бололцоо, ур чадвар, сурагчдынхаа нас, сэтгэхүйн онцлог болон өөрийн амьдарч буй орон нутагтаа тохируулан хэрэглэх бүрэн боломжтой. Бид зарим хичээлүүдийг (Тухайлбал, Гэрээс сургууль хүрэх замд) хувилбартайгаар оруулж өгсөн нь багш танд өөрт тохирох хувилбараа сонгон хэрэглэх боломжийг олгоно (зөвлөмж I, II-ыг мөн адил ийм загвараар бичсэн тул та заавал үзэж, хичээлдээ ашиглахыг санал болгож байна).

Хичээлийг явуулахдаа багшийн гол анхаарах хэсэг бол сэдэлжүүлэх болон бүтээх үе шат юм. Зургаан настай хүүхдүүдийн сэдлийг төрүүлэх нь нэлээд хүнд ярвигтай асуудлын нэг яах аргагүй мөн. Иймээс та энэ насны хүүхдийн нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг зайлшгүй судалж мэдсэн байх ёстой. Та бүхэнд хялбар болгох үүднээс б настны зарим онцлогийг тусгай бүлэг болгон оруулсан бөгөөд энэ тухай I бүлгээс уншиж судлаарай.


Сурагчдыг хэр сайн сэдэлжүүлж, хүүхдийн хүсэл сонирхлыг төрүүлж чадсанаас таны хичээлийн явц, үр дүн хамаарна. Энэ нь хичээлдээ хэр сайн бэлтгэсэн, таны

онолын мэдлэг хэр зэрэг байгаатай холбоотой. Ер нь аливаа хичээлийг үр дүнтэй явуулахын тулд хичээлийн бэлтгэл буюу хичээлийн бэлтгэл судалгаа (кёзай кэнкю)-г хийх явдал юм. Хичээлийн бэлтгэл судалгаа гэдэг нь дараах 5 судалгааны цогц юм.

1. Судлагдахууны агуулгын судалгаа
2. Мэдлэг эзэмшилтийн явцын судалгаа
3. Заах арга барилын судалгаа
4. Үнэлгээний судалгаа
5. Хэрэглэгдэхүүний судалгаа

Эдгээр судалгааны талаар та өмнөх жилийн зөвлөмжүүдээс мэднэ.

Япон зөвлөх багш нар хичээлийг мөсөн уултай зүйрлэж байна. Мөсөн уулын 90% нь усны доор, 10% нь ил харагдаж байдагчлан хичээлийн бэлтгэл (агуулга, хэрэглэгдэх материал, хүүхдийн өмнөх мэдлэг, төсөөлөл зэрэг) үйл ажиллагааг далд байдаг 90%-тай адилтгаж үзнэ. Харин 10% нь ангид явагдах 35-40 минутын үйл явц юм.



Тухайн өдрийн хичээл хэр сайн болох нь тэр хичээлийн бэлтгэл ямар байснаас шууд хамаардаг.

**III бүлэгт** Арга зүйн туршилт болон хичээлийн судалгааг (жюгё кэнкю) хэрхэн хийх талаар оруулсан. Энэ бүлэг 2 хэсгээс бүрдэх бөгөөд нэгдүгээр хэсэгт, туршилт хичээлийн явц, үр дүнгийн талаар бодит жишээн дээр тулгуурлан оруулсан ба хоёрдугаар хэсэгт, Японы бага боловсролын байгалийн ухааны хичээлийн туршлагаас оруулсан.

**Хавсралтад** хичээл тус бүр дээр ашиглах боломжтой зарим зураг, бүдүүвч зэргийг оруулсан ба мөн сурагчдын хийсэн бүтээлүүдээс оруулж өгсөн. Та хичээлдээ эдгээр зургуудаас шууд авч ашиглаж болох ба үүнтэй ойролцоо зургуудыг эрж олон ашиглаарай.

**Ашигласан материалын** жагсаалтад тухайн бүлэг сэдвийн зөвлөмжийг боловсруулахад ашигласан ном, сурх бичиг, эх сурвалжуудыг оруулсан ба мөн зарим хичээлүүдэд ашиглах боломжтой эх материалыудыг орууллаа.

## Арга зүйн зөвлөмжийг хэрхэн ашиглах вэ?

Энэхүү зөвлөмжийг ашиглан хичээл явуулахдаа анхаарах зүйлийг сэдэв тус бүрээр товч авч үзлээ. Үүнд:

### Хичээл 1. «Миний эргэн тойронд юу байдал вэ?» 2 цаг

Энэ хичээлээр суралцагчдад өөрийнх нь эргэн тойронд юу юу байдгийг таниулах, нэрлүүлэх, ажигласан зүйлийг нь яриулах, тэмдэглүүлж сургах, бүтээлгэх зэрэг танин мэдэхүйн үйлийн зэрэгцээ эрүүл аж төрөх, аюулгүй амьдрах энгийн ойлголтыг эзэмшүүлнэ. Эхний цагийн хичээлийг экскурс хэлбэрээр явуулах ба гадаа тоглоомын талбайд байгаа янз бүрийн тоглоом, хашаа, байшин, мод, цэцэг зэргийг сайтар ажиглуулна. Гадаа гаражын өмнө сурагчдад унаж бэртэхээс сэргийлэх, аюулгүй ажиллагааны талаар урьдчилан танилцуулж зааварчилгаа өгсөн байх хэрэгтэй.

2 дугаар цагт ангид орж ирэн – Бидний эргэн тойронд тоглоомын талбайн баруун, зүүн, хойд, урд талд юу байна вэ? гэж асуун суралцагчдын ажигласан зүйлийг ангиараа харилцан ярилцаж, санал бодлоо солилцно. Энэ үед сурагчид ажиглалтын явцад юу юу харснаа хэлж, ярилцах ба үүний дараа мод, чулуу, навч, боргоцой зэрэг байгалийн бэлэн материал болон баримлын шавар, хайч, цавуу зэрэг хичээлийн туслах хэрэгслүүдийн тусламжтайгаар багаар юмуу хосоор хамтарч бүтээлээ хийнэ. Бүтээлээ хийж байх явцад багш сурагчдаа стандарт бус үнэлгээгээр үнэлж тэднийг урамшуулна.

### Хичээл 2. «Гэрээс сургууль хүрэх замд» 1 цаг

Өмнөх хичээлийн дараа багш сурагчдад өөр өөрсдийн гэрээсээ сургууль хүрэх замд нь юу юу тааралдсаныг ажиглаж, тэмдэглэх даалгавар өгсөн байна. Тэгээд энэ хичээлийг эхлэхэд багш сурагчдаас тэдний гэрээс сургууль хүрэх замд юу, юу байдал, ямар зүйл тааралдсан талаар асууж ярилцан хичээлийг сэдэлжүүлнэ.

Барилга байгууламж, соёл үйлчилгээний газар нь орон нутаг, аймаг, нийслэлд ялгаатай байдгийг харгалзан сурагчиддаа тавих асуултаа багш урьдчилан бэлдсэн байх хэрэгтэй. Асуулт дэвшүүлж ярилцсаны дараа багш сурагчдаас гэрээс сургууль хүрэх замд тааралдсан зүйлсийг баримал, зураг, наамал, байгалийн материал зэргийг ашиглан бүтээх даалгавар өгнө.

Гэрээс сургуульд ирэхдээ машин тэрэг, муур, нохой, гэрийн тэжээмэл амьтан, ухаж орхисон нүх, суваг шуудууг тойрч явах, ил задгай цахилгааны утсанд хүрэхгүй байх, зам хөндлөн гарахдаа явган хүний гарцаар гарах зэрэг санамжийг зайлшгүй өгөх нь чухал.

### Хичээл 3. «Соёл үйлчилгээний газартай танилцъя» 2 цаг

Энэ хичээлийг мөн 2 цагаар оруулахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс илүү цагаар орж болно. Уг сэдвийг заахын өмнө багш соёл үйлчилгээний газрууд болох музей, дэлгүүр, эмнэлэг, кино театр, номын сангийн удирдах ажилтантай уулзаж «Хүн-Орчин» хичээлээр б настай сурагчдад соёл үйлчилгээний газруудыг танилцуулах тухай хэлж, дэмжиж өгөхийг хүссэн албан бичгийг явуулах ба хичээлийн цагаа урьдчилан тохирсон байх шаардлагатай.

Музей үзүүлэхээр төлөвлөсөн бол музейн үзмэрийг бүхэлд нь үзэх боломж,

цаг багтахгүй байж магадгүй тул музейн аль хэсгийг үзүүлэх вэ гэдгийг урьдчилан судалсан байна.

Соёл үйлчилгээний газартай танилцуулахаар явахдаа аюулгүй байдлыг хангах үүднээс эцэг эхийн төлөөллийг авч яваарай. Сурагчдыг хоёр хоёроороо өгнээгээ барин бусдаасаа хоцрохгүй явах, үйлчилгээний газрын ах, эгч нарын тайлбарыг анхааралтай сонсож, асуух зүйл байвал гарaa өргөж, өөрийн сонирхсон зүйлээ мэдэж аваарай гэдгийг сурагчиддаа сануулна.

2 дугаар цагийн хичээлийг ангид ирж үргэлжлүүлэх ба өөрсдийн нь үзэж харсан зүйлийг бүтээлгэх даалгавар өгнө. Аяллаар явсан тухайгаа сурагчдын бүтээлийг тэдний сонголтоор хийлгүүлэх нь зүйтэй болов уу.

#### Хичээл 4. «Дүгнэлт хичээл» 1 цаг

Энэхүү «Дүгнэлт хичээл»-ээр сурагчид үзэж, ажигласан, таньсан, мэдэж авсан, харьцуулсан, хийж бүтээсэн бүтээлүүдээ нэгтгэн дүгнэнэ. Дүгнэлт хичээлд багш үзэсгэлэнгийн аргыг (галерейн арга) хэрэглэх нь тохиромжтой. Мөн тоглоомын арга болон дүрд тоглох аргыг оновчтой хэрэглэж болно.

Тухайн хичээлд багш, сурагчдаас гадна эцэг эхчүүдийг урин оролцуулж, хүүхдийнх нь сурч мэдсэн, хийж бүтээсэн бүтээлүүд болон бусад зүйлстэй танилцуулна. Үүгээр өөрийн хүүхдийнхээ бие бялдар, сэтгэхүй, танин мэдэхүй, нийгэмшихүйн онцлог түүний өсөлт, хөгжил зэргийг харж ажиглах боломжтой. Тухайн «Хүн-Орчин» хичээлээр сурагчдын байгалийг танин мэдэх хэрэгцээг судлан багшийн хичээлийн өмнөх бэлтгэл хангалтаар хийгдсэн ажлуудыг эцэг эхчүүд мэдэх болно. Мөн энэхүү дүгнэлт хичээл нь багш, эцэг эх, сурагчдын гурвалсан холбоог улам илүү бэхжүүлэх ач холбогдолтой.

### **Хичээлийн үнэлгээг хэрхэн хийх вэ?**

Сургалтын үнэлгээний бүх хэлбэр нь сурахуйд «юуг үнэлж цэгнэдэг»-ийг мэдээлдэг.

Энэ мэдээлэл нь сурагчид юу мэдэж, хийж чадаж байгаа, ирээдүйд юу хийх чадвартай байгааг илэрхийлдэг.

#### **Үнэлгээг хэрхэн сайжруулах вэ?**

- Үнэлгээ нь бодитой байхын тулд тоон үзүүлэлтэд бус, чанарт хандсан байх,
- Хүүхдийн өөрийгөө үнэлэх боломжийг бүрдүүлсэн байх,
- Сурагчдын мэдлэгийг бус чадварыг үнэлэх аргазүйд багш суралцах,
- Зөвхөн багш үнэлдэг аргаас татгалзаж суралцагч, эцэг эх, бусдын үнэлгээний оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй.

Сурагчдын сурах үйлийн идэвхийг өрнүүлэхийн тулд урамшуулах, дэмжих аргыг боломжоор нь хэрэглэх нь зүйтэй.

Чадварыг голчилсон үнэлгээний хувьд сургалтын агуулга, судлах цагийг голчилдог байсан хандлагаас «Сурагчид нь ..... чадвартай болно» гэж илэрхийлэх хандлагад шилжиж байна. Дараах загварыг харна уу.

	Үнэлгээний шалгуур	Сайн	Жаахан	Үүнээс хойш хичээе
	Эрт босож чадна			
	Мэндэлж чадна			
	Бусдад тусалдаг			
	Даалгавраа өөрөө хийдэг			
	Найзуудтайгаа эвтэй тоглож чадна			
	Өөрөө олж мэдээд, хийж бүтээж чадна			
	Баярлалаа, учлаарай гэж хэлж чадна			
	Хамтарч хичээлээ хийж чадна.			
	Найзынхаа сайн чаддаг зүйлийг хэлж чадна			
	Өөрийнхөө чаддаг зүйлийг нэрлэж чадна			

## I БҮЛЭГ. ЗУРГААН НАСТАЙ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ОНЦЛОГ

### 1.1. Хүүхдийн хөгжлийн талаарх үзэл баримтлалын тойм

Хүний насан туршийн хөгжлийг эрдэмтэд янз бүрийн үе шат болгон ангилсан байдаг. Эхийн хэвлэй дэх үе, нярай, нялх гэх зэргээр хөгжлийг үе шат болгон авч үздэг. Ангиллыг хийхдээ зарим эрдэмтэд хувь хүний насан туршийн хөгжлийн явцыг бүхэлд нь баримжаалах буюу эсвэл зөвхөн аль нэг насты үечлэлийг тусгайлан авч үзсэн байдаг.

Нас гэдэг нь цаг хугацааны хувьд харьцангуй хязгаарлагдсан сэтгэцийн хөгжлийн тодорхой үе шат юм. Насны үечлэл нь хөгжлийн процесийн мөн чанарт тулгуурлаж байдаг. Хөгжлийн нэг үе шатнаас дараагийн үе шатанд шилжих шилжилтийн үеийг хямралын үе гэх бөгөөд энэ нь хоёр шатны зааг дээр үүсэж, хөгжлийн нэг шат нөгөөгөөр солигдож байгааг тодорхойлно.

Зургаан насыг наaszүйн сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс авч үзвэл «сургуулийн өмнөх нас», «хүүхэд насты эхэн үе», «сургуулийн бага насты эхэн үе» гэх зэргээр ангилан үзжээ. Ийнхүү ангилан үзэхдээ зөвхөн зургаан насыг товоилгон авч дангаар судалсан судалгаа ховор байдаг.

Хүүхдийн хөгжлийн энэхүү өвөрмөц үеийн онцлогийг тодорхойлохын тулд 5-6 насты үе ба 6-7 насты аль алийг, түүгээр ч барахгүй сургуулийн өмнөх ба сургуулийн бага насыг зэрэг харьцуулан судлах замаар «зургаан настай хүүхэд гэж хэн бэ?» гэсэн асуултад хариулахад дөхөм болж болох юм. Гэхдээ зургаан настай хүүхдийн сэтгэц-физиологийн хөгжлийн онцлогийг тодорхойлох боломжгүй гэж хараахан үзэж болохгүй. Харин энэ насты онцлогийг тодорхойлохын тулд онол-практикийн хувьд нэлээн нухацтай, нарийн шинжлэн судлах, хандах шаардлагатай.

Манай орны хувьд зургаан настай хүүхдийн хөгжлийн онцлогийг дангаар судалсан судалгаа болон онол, арга зүйн шинжтэй бүтээл, туурвил цөөн байна. 2007 оны 11-р сард БСШУ-ны сайдын тушаал гарч «Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх графикийг 2008-2009 оны хичээлийн жилээс эхлүүлэн хэрэгжүүлэх ба зургаан настай хүүхдийг сургуульд нийтээр нь элсүүлэн сургах бэлтгэлийг хангах» болсноор энэ чиглэлийн судалгааны ажил эрчимжиж эхэлсэн. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд зургаан настай хүүхдийн хөгжлийн онцлогийг танин мэдэх, боловсролын байгууллагын мэргэжилтнүүдэд болон насанд хүрэгчдэд энэхүү хүүхдийн өвөрмөц үеийн талаар зохих ойлголт өгөх шаардлага гарч байгаа юм.

Хүүхдийн хөгжлийн талаарх онол, үзэл баримтлалуудаас зөвхөн зургаан насты онцлогийг хэрхэн тайлбарласныг дэлхий дахинд болон манай орны хувьд онол, практикийн хувьд нэлээн ашиглагддаг З.Фрейдын «Сэтгэц задлан шинжлэлийн онол», Э.Эриксоны «Сэтгэц нийгмийн хөгжлийн онол», Д.Эльконины «Суралцахуйн онол», Ж.Пиажегийн «Оюун ухаан, танин мэдэхүйн онол», Л.С.Выготскийн

«Сэтгэцийн хөгжлийн онол» зэрэг эрдэмтдийн онол үзэл баримтлал дээр авч үзлээ.

### 1. 3.Фрейд «Сэтгэц задлан шинжлэлийн онол»

Энэхүү онолын үүднээс 3-6 нас бол хүйсийн ялгаагаа мэдрэх үе гэж үздэг. Хүүхэд өөрсдийн хүйсийн онцлогоо ухаарч «Би хаанаас төрсөн бэ?», «Би яагаад боовтой, дүү яагаад боовгүй байгаа юм бэ?» гэх зэргээр асууж сонирхож эхэлдэг. Ингэж өөрсдийн бие эрхтний онцлогийг таних явцдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн онцлогийг эх эцгээсээ үлгэр аван харж ажиглаж эхэлдэг. Хүүхэд таван нас хүртлээ эрэгтэй, эмэгтэй хүний дүр төрхийг хэрхэн зэмшихээ хүүхэд төдий л сайн ойлгодоггүй. Харин зургаа орчим наснаасаа эхлээд хөвгүүд ааваа дуурайх, охид ээжийгээ дуурайх замаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дүр төрхийг эзэмшихийг эрмэлздэг. Энэ үед аав нь эрэгтэй хүүхэдтэй хатуу ширүүн харилцвал эрэгтэй хүүхдийн хөгжилд хямрал үүсэх ба эрэгтэй хүнээс сүрдэж эмээх мэдрэмж гүнзгий төрвэл хүүхдийн цаашдын хөгжилд сөрөг нөлөөтэй гэж үздэг. Охидын хувьд ч ялгаагүй ээж нь охиндоо эелдэг зөвлөн хандаж эх хүн, эмэгтэй хүн ямар байдгийг үлгэрлэн харуулж чадвал эмэгтэй хүний талаарх зөрөг дүр төрх үүсэхэд сайнаар нөлөөлдөг. Хүүхэд эх, эцгийнхээ байр байдлыг дуурайн хуулбарлах замаар хүйсийн ялгаатай холбоотой зан үйлийн хэм хэмжээг эзэмшиж эхэлснээр түүний хөгжил таатай явагдах нэг талын нөхцөл бүрэлдэнэ. Гэхдээ зургаан наснаас хойш хөгжил нь аажмаар жигд явагдаж эхлэнэ гэж сэтгэц задлан шинжлэлийн онолын үүднээс үздэг байна. Тухайлбал 6-12 насыг оюуны дасгал, биеийн тамир, үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцаа хөгжихөд нэн тохиромжтой үе гэж 3.Фрейд үзжээ. Үүнээс үзвэл хүйсийн ялгаа ба үүргийг нэг талаас сайн ойлгох чадвартай болох ба зургаан наснаас эхлэн хөгжлийн дараагийн шатанд шилжиж эхлэх бөгөөд энэ шат нь төрөл бүрийн чадвар дадал эзэмшихэд нэн тохиромжтой үе юм.

Иймээс эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид дараах зүйлд анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Хүүхдэд хүйсийн ялгаа ба үүргийг зөв таниулах, үүний тулд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн намба төрх, харилцааны хэм хэмжээний талаар ойлголт өгөх үйл ажиллагаануудыг зохиох, өөрсдөө зөв үлгэр дуурайлал үзүүлэх
- Эрэгтэй хүн харгис хатуу, эмэгтэй хүн олон үгтэй байдаг гэсэн буруу ойлголт төсөөллийг хүүхдэд багаас нь өгөхгүй байхыг анхаарах хэрэгтэй.

### 2. Э.Эриксоны «Сэтгэц нийгмийн хөгжлийн онол»

«Хүүхэд нас ба нийгэм» гэсэн бүтээлдээ Америкийн нээрт сэтгэл зүйч Эрик Эриксон хүний хөгжлийг найман үе шат болгон загварчилсан байдаг. Хөгжлийн үе шат бүрт өвөрмөц маягийн зөрчил үүсэх нөхцөл бүрэлддэг бөгөөд уг зөрчлийг хэрхэн шийдвэрлэснээс тухайн шатны эцсийн үр дүн эерэг байх уу, эсвэл сөрөг байх уу гэдэг нь шалтгаална гэж Э.Эриксон үзжээ. Өөрөөр хэлбэл хүүхдийн хөгжлийн өмнөх суурь яаж явагдснаас дараагийн шатны хөгжил шалтгаална гэжээ. Эриксон өөрийнхөө онолд хувь хүний «Би»-гийн төлөвшлийг голлон анхаарсан байдаг. Хувь хүний биологийн хөгжлийг нийгмийн орчинд дасан зохицох үйл явцтай хослуулан авч үзсэн учраас түүний тодорхойлсон хүний хөгжлийн онолыг психосоциал буюу сэтгэц-нийгмийн хөгжлийн онол загвар гэж нэрлэдэг байна.

Хүний хөгжлийг нийгэм-сэтгэл зүйн талаас нь авч үзэхдээ «Би» үзэл баримтлалыг голлодог учраас «Би-онол» буюу «Эго-онол» гэж алдаршсан юм. (его-би гэсэн утгатай үг).

Э.Эриксон хүний хөгжлийн онцлогийг насын үечлэлээр ангилан үзсэн. Ангиллыг дараах байдлаар хийжээ. Үүнд:

- Нялх нас 0-1
- Балчир нас 1-3
- **Тоглоомын нас 4-6**
- **Сургуулийн нас 6-12**
- Залуу нас 12-20
- Идэр насын эхэн үе 20-25
- Идэр нас 26-64
- Өтөл нас 64-өөс дээш

Энэ онолын үүднээс зургаан настай хүүхдийн хөгжлийг тайлбарлахын тулд 4-6 нас ба 6-12 насын үеүдийг харьцуулан авч үзэх хэрэгтэй. 4-6 насыг Эриксон **тоглоомын нас** гэж нэрлэжээ. 4-5 настай хүүхдүүд өөрөөсөө бусад зүйлийг идэвхтэйгээр сонирхон судалж эхэлдэг. Ертөнцийн юмс үзэгдлийн шинж байдлыг таньж орчинтойгоо хэрхэн харилцан үйлчлэлцэхээ тэд мэдэж авдаг. Орчлон ертөнц гэдэг бол тэдний хувьд бодит зүйл төдийгүй өөрсдийнх нь зохион дүрсэлсэн хүмүүс, юмс үзэгдлийг ч агуулдаг байна. Орчноо таних гэсэн тэдний энэхүү судлан шинжлэх үйл ажиллагаа нь үр дүнтэй байвал тэд эд юмс, хүмүүстэй зөв харилцаж сурдаг ба санаачилга сайтай болон төлөвшиж хүмүүждэг байна. Харин юмыг танин мэдэх гэсэн хүүхдийн эрмэлзлийг үл ойшоон түүнийг байнга шүүмжилж шийтгэвэл хийсэн бүхнийхээ төлөө өөрийгөө буруутган гэмших сэтгэл төрнө.

Эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид 4-6 насынханд анхаарах зүйл бол:

- Энэ шатанд хүүхдийн хөгжил зөв явагдвал санаачилга сайтай болох ба хөгжлийн нөхцөл зохисгүй байвал гэмших, өөрийгөө буруутгах хандлагатай болдог.

Зургаан наснаас хойшхи 6-12 насын үеийн хүүхдүүд маш олон төрлийн чадвар, дадал эзэмших ба энэ үеийг Эриксон **«хөдөлмөрлөх дур сонирхол ба дутуу дулимагийн мэдрэмж хоёрын хоорондын зөрчлийн үе»** гэж үзжээ. Энэ насын үед хүүхдүүд маш олон тооны чадвар дадал эзэмшдэг ба хүүхдийн нэр хүнд нөлөөлөл төрөл бүрийн орчинд бодитой өссөний улмаас өөрийн «Би»- гээ мэдрэх мэдрэмж өсдөг гэж үздэг. Эерэг хэвийн орчинд хүүхэдтэй зөв харилцаж өөрийн байр сууриа олоход нь тусалж чадвал тэд хөдөлмөрлөх дур сонирхол сайтай болдог ба би юунд суралцсан бэ гэдгээр өөрийн хөдөлмөрлөх дур сонирхлоо хэмжих нь олонтой. Хүүхдэд төрөл бүрийн чадвар дадал төлөвшихэд сургууль, гэр бүл, үе тэнгийнхэн маш чухал нөлөөтэй юм. Сургалт системтэй, зөв, орчных нь хүмүүсийн үлгэр дуурайлал сайн, хүүхдийн бие даасан эрхэмсэг чанарыг хүндэтгэн харилцаж, байр сууриа зөв олоход туслаж байгаа нөхцөлд хүүхэд хөдөлмөрлөх дур сонирхол сайтай болдог Харин өөрийгөө бусадтай харьцуулан чамлаж эхэлбэл энэ үеийн хөгжилд багагүй саад учирдаг, дутуу дулимагийн мэдрэмж давамгайлан үлдэх магадлал өндөр байдаг.

6-12 насныханд анхаарах зүйлүүд бол:

- Зургаан насны эхэн үед хүүхдийн тоглоом орчноо танихад чухал үүрэгтэйг анхаарч тоглоомын явцад өрнөж байгаа хүүхдийн бие даасан байдал, идэвхийг дэмжиж өгөх, хүүхэд юманд сониучхан, бүтээлч хандах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх
- Хүүхдийн идэвхи санаачилга ба бие даасан байдлыг ойлгоогүй, шийтгэж мохосны улмаас өөрийгөө буруутгаж, шоовдор өчүүхэн амьтан гэж үзэх мэдрэмж төрдөгийг анхаарч үүнээс сэргийлэх хэрэгтэй
- Зургаан насны төгсгөл үеэс эхлэн хүүхэд юмыг хийж сурх гэсэн хүсэл эрмэлзэл хүүхдэд хүчтэй төрж олон төрлийн чадвар дадал эзэмших тохиромжтой үе эхэлж байгааг анхаарах
- Хүүхдэд хандаж байгаа хандлага, түүний сурх хөдөлмөрийн зохион байгуулалтаас хүүхдийн сурх хүсэл эрмэлзэл-хөдөлмөрлөх дур сонирхол шалтгаалдагийг анхаарч, түүнд «чадваргүй, муу хүүхэд» гэсэн элдэв нэр хоч өгч өөрийгөө чамлах, голох, «Би бусдаас муу хүүхэд» гэсэн ойлголт төрүүлэхгүй байх ёстой.

### 3. Б.Д.Эльконины «Суралцахуйн онол»

Оросын сэтгэл зүйч **Б.Д.Эльконин** хүүхдийн сэтгэцийн хөгжлийг тодорхойлохдоо «Гол зонхилох үйл ажиллагаа», «Шинэ бүрдэлт» гэсэн өвөрмөц ухагдахуунуудтай холбон тайлбарласан байдаг. Хөгжлийн үе шат бүр өөр өөрийн гэсэн давтагдашгүй онцлогтой байдаг учраас зөвхөн тухайн насны үед илрэх ёстой чанарын өөрчлөлт, онцлог гэж байдаг. Энэхүү онцлогийг илэрч гарахад шийдвэрлэх нөлөө үзүүлж байгаа үйл ажиллагааг **гол зонхилох үйл ажиллагаа** гэнэ.

Б.Д.Эльконины онолыг 1990-ээд оноос өмнөх үеийн манай орны сэтгэл судлалын шинжлэх ухаанд хүүхдийн хөгжлийн насны онцлогийг тайлбарлах ба харгалзан үзэхэд голлон хэрэглэсээр ирсэн байдаг. Б.Д.Эльконины онолд хүүхдийн насыг дараах байдлаар үечлэн үзсэн байна.

- Нялх үе 0-1
- Балчир нас 1-3
- **Сургуулийн өмнөх нас 3-7**
- Сургуулийн бага нас 7-11
- Өсвөр нас 11-15
- Сургуулийн ахлах нас 15-17

Б.Д.Эльконины онолд 3-7 насыг сургуулийн өмнөх насны ангилалд багтаан үзээд тоглоом бол энэ насны хүүхдийн «Гол зонхилох үйл ажиллагаа» юм гэж үзжээ. Гол зонхилох үйл ажиллагаа нь дүрт тоглоом юм. Танин мэдэх үйлийн чиглэл нь бие хүний хэрэгцээ сэдлийн тал юм. Нийгмийн ач холбогдол бүхий орчны зүгээс үнэлэгдэх үйл ажиллагаа хийх эрэлт хэрэгцээ юм. Энэ үед тоглоомоороо дамжуулан хүмүүсийн хоорондын харилцааг танин мэдэхэд хүүхдийн хөгжил чиглэнэ гэжээ. Тоглоомын явцад хүүхдийн хэрэгцээ сэдэл төлөвших ба төрөл

бүрийн үйл ажиллагаа хийх эрэлт хэрэгцээ үүснэ. Энэ эрэлт хэрэгцээ бол хүүхдийн хөгжилд гарч ирж байгаа цоо шинэ зүйл. Өөрөөр хэлбэл, өмнөх насын үед байгаагүй, тухайн үед цоо шинээр гарч ирж байгаа зүйл юм. Үүнийг нүдний цөцгий мэт хамгаалах хэрэгтэй бөгөөд хэрэгцээгээ хангах боломжийг бүрдүүлэхэд насанд хүрэгчид онцгой анхаарах ёстай. Хүүхдийн хийх үйл ажиллагааг орчны хүмүүс үнэлж дүгнэж, ойшоон олж харах, нийгмийн үнэ цэнийг сайшааж, үнэлж дэмжиж байх нь чухал гэж үздэг. Сургуулийн өмнөх насын хүүхдийн тоглоомыг зөв зохион байгуулснаар түүний сэтгэцийн хөгжил эрчимтэй явагдах нөхцөл бүрддэг байна. Ерөнхийд нь авч үзвэл хөгжлийн чухал хүчин зүйлүүд болох үйл ажиллагаа ба харилцааг гол үзүүлэлт болгон авч үзсэн онол учраас хүүхдийн нийгэмшлийг тайлбарлахад чухал ач холбогдолтой юм.

Тоглоомын насыхан буюу сургуулийн өмнөх насыхантай ажиллахад юуг анхаарах вэ?

- Хүүхдийн хичээлийг хийлгэхдээ тоглоомын аргуудыг өргөн хэрэглэх
- Танин мэдэхүйн тоглоомуудын нөөцтэй болж үүнийгээ хүүхдэд зааж сургах
- Хүүхдийн тоглоомыг ажиглах замаар хүүхдийг судлах өргөн боломж байгааг ашиглах
- Үе тэнгийнхэнтэйгээ тоглох нөхцөл, боломжоор хүүхдийг хангах
- Нийгмийн ач холбогдол бүхий үйл ажиллагаа хийх эрэлт хэрэгцээ үүсч байгааг анхаарч энэ хэрэгцээгээ хангах нөхцлийг бүрдүүлэх, хүүхдийн хийж байгаа зүйлийн нийгмийн ач холбогдлыг зөв үнэлж дүгнэх, урамшуулах замаар нийгмийн туршлага хуримтлуулахад анхаарах хэрэгтэй.

#### 4. Ж.Пиажегийн «Оюун ухаан, танин мэдэхүйн онол»

Швейцарийн нэért сэтгэл зүйч Жан Пиаже хүүхдийн оюун ухааны хөгжлийг судалж өвөрмөц зүй тогтлуудыг нээсэн байдаг. Тэрээр хүүхдийн оюун ухааны хөгжлийн онцлогийг харуулсан олон туршилт бодлогуудыг боловсруулсан нь өнөө хир сургалтанд хэрэглэсээр байна. «Мэдлэг бол үйлдэл юм» гэж Пиаже үзээд үйлдлийн явцад схемүүд бий болно. Хүмүүс хөгжлийнхөө явцад мэдээллийг зохион байгуулах, гадны өртөнцийг ойлгохын тулд илүү нарийн схемүүдийг хэрэглэж сурдаг гэх зэргээр тайлбарлажээ. Пиаже хүүхдийн оюун ухааны хөгжлийг чанарын хувьд өөр хоорондоо ялгаа бүхий дөрвөн үе шат болгон ангилжээ.

- Хүртэх хөдөлгөөний үе шат: 0-2 нас
- **Үйлдэл төлөвшихөөс өмнөх шат: 2-7 нас**
- Тодорхой үйлдлийн шат: 7-12 нас
- Формаль үйлдлийн шат: 12- дээш нас

### Хүснэгт 1. Хүүхдийн оюун ухааны хөгжлийн үе шатууд (Ж.Пиаже)

Үе шатууд	Нас	Хүүхдийн танин мэдэх үйлийн онцлог
Хүртэх хөдөлгөөний үе шат	0-2 нас	Нялх хүүхдүүд орчноо зөвхөн төрөл бүрийн үйлдлийн тусламжтайгаар танин мэддэг. Харах, барих, хөхөх, хазах, зажлах гэх мэт.
Үйлдэл төлөвшихөөс өмнөх шат	2-7 нас	<b>Бага насын хүүхдүүд хэлд орж, орчныхоо хүмүүстэй ярих зэргээр дохиолол тэмдгүүд, ухагдахууныг эзэмшинэ. Ухагдахуун нь тэдний хувийн туршлага, өөр дээрээ юмыг төвлөрүүлэн сэтгэх үзэл зэргээр хязгаарлагддаг. Хөгжлийнхөө энэ шатан дээр хүүхэд үр дагаврын талаар маш хязгаарлагдмал, заримдаа үлгэрийн юм шиг төсөөлөлтэй байдгаараа онцлог юм. Үзэгдэл юмыг ангилахад ихээхэн төвөг, бэрхшээл учирдаг.</b>
Тодорхой үйлдлийн шат	7-11 нас	Хүүхдүүд юмыг логикоор сэтгэж эхлэх бөгөөд юмыг хэд хэдэн шинж тэмдгээр нь ангилна. Математик ухагдахуунуудыг тодорхой юмст хамруулан хэрэглэх чадвартай болно. Юмын дотоод шинж чанар гадаад хэлбэр хэмжээнээсээ үл хамааран тогтвортой хадгалагддаг гэдгийг ойлгож эхэлнэ.
Формаль үйлдлийн шат	12-оос дээш нас	Өсвөр насынхан нь тодорхой ба хийсвэр асуудлыг шийдвэрлэх, задлан шинжилгээ хийх чадвартай болсон байна. Тэд бүх боломжийг бодож үзэх, өнгөрснөө дурсан санаж, ирээдүйн төлөвлөгөө зохиож чадах ба адилтгал ба шилжүүлсэн утгад тулгуурлан эргэцүүлдэг.

Зургаан настай хүүхдийн оюун ухааны онцлогийг тодорхойлохын тулд Piажегийн энэхүү ангиллаас хоёр дах шатыг буюу «Үйлдэл төлөвшихөөс өмнөх» үеийн онцлогийг авч үзье. Хүүхэд хэлд орж тэмдэг, тэмдгийн системийг хэрэглэх болсноор энэ шат эхэлнэ. Хүүхэд өдөр тутмын туршлага дээрээ тулгуурлан тодорхой мэдлэг эзэмшдэг. Юмыг ангилж бүлэглэх, ерөнхийлөн дүгнэж чаддаггүй. Тийм ч учраас «Нохой олон байна уу, амьтан олон байна уу?» гэсэн асуултад зөв хариулж чаддаггүй байна (хуудас 32-ыг харна уу). Тэдэнд «амьтан» гэсэн ерөнхий ойлголт төлөвших болоогүй байгаа үе юм. Харин нохой ба муурын талаарх тодорхой ойлголт төсөөлөл байгаа учраас тэд тоог зөв хэлж чадаж байгаа юм. Хэл яриа эзмших болсонтой холбоотойгоор нэг зүйлийг нөгөөгөөр орлуулан сэтгэх чадвартай болно. Цаасыг бялуу, модны өөдсийг «авдар», хүүхэлдэйгээ «ээж» гэх зэргээр орлуулан төсөөлж тоглоомынхoo явцад тэр төсөөлөл дээрээ тулгуурлан үйл ажиллагаагаа зохицуулах чадвартай болдог. Гэхдээ хүүхэд үзэгдэл юмын хоорондын ерөнхий учир шалтгааныг ойлгож логикоор сэтгэх болоогүй гэж үздэг [6].

Үйлдэл төлөвших үе шатны үед анхаарах зүйлүүдэд:

- Хүүхдийн сэтгэхүй бодит, тодорхой шинжтэй, төсөөлөхөд хялбархан бодит зүйл дээр төвлөрөн сэтгэнэ.
- Үзэгдэл юмын хоорондын холбоо хамаарлыг өрөөсгөл нэг чиглэлд сэтгэнэ. Хоёр талын хамаарал ба уялдаа холбоог нарийн төсөөлж чаддаггүй.

- Хүүхэд ямар нэгэн зүйлийг хийх ба бодохдоо өөрийн үзэл бодлын үүднээс хийнэ. Юмыг өөр бусдын байр сууринаас бодож төлөвлөх нь энэ насны хүүхдэд их хэцүү байдаг.
- Юмын аль нэг шинж чанарыг голлон анхаарч үзэх хандлагатай. Өөрөөр хэлбэл аль нэг шинж чанар дээр төвлөрүүлэн сэтгэдэг. Үүнийг хүүхдийн сэтгэлгээний төвлөрөл гэнэ. Жишээ нь тэдэнд модоор хийсэн улаан ба шар өнгийн бөмбөгүүдийг харуулж аль өнгө нь олон байна вэ, гэж асуухад зөв хариулах боловч харин улаан нь олон байна уу, модоор хийсэн хийсэн нь олон байна уу, гэхэд энэ хоёр шинж тэмдгийг зэрэгцүүлэн зөв хариулж чаддаггүй байна.
- Тухайн үеийн зүйлийг «энд ба одоо» гэсэн зарчимд тулгуурлан сэтгэх ба үйл явдлын цаашдын өрнөлийг төдий л тооцоолж чаддаггүй.

Гэхдээ зургаан нас бол хүүхдийн сэтгэлгээний эдгээр онцлогоос дараагийн шатанд шилжих шилжилт ойртож байгаа үе гэдгийг анхаарах хэрэгтэй.

## 5. Л.С.Выготскийн «Сэтгэцийн хөгжлийн онол»

Оросын сэтгэл зүйч Л.С.Выготскийн үзэл баримтлал нь сургалт хүүхдийн оюун ухаан ба хөгжил хоёрын хоорондын харилцааг зөв тодорхойлоход ач холбогдолтой. Тэрээр хүүхдийн сэтгэцийн хөгжлийн талаар онол, арга зүйн шинжтэй олон чухал санаануудыг дэвшүүлэн тавьснааараа алдаршжээ. Тухайлбал, зориудын ой, анхаарал, хийсвэр сэтгэхүй зэрэг зорилго, чиглэлтэй явагддаг үйлүүд нь санамсаргүй явагдаж байдаг энгийн үйлдлүүдээсээ ялгаатай гэж үзээд эдгээрийг сэтгэцийн дээд үйлүүд гэж нэрлэжээ. Бага насанд нь сэтгэцийн энгийн үйлүүдийг, тухайлбал, зориудын бус ой, анхаарал, хүүхдийн шууд мэдрэн таних үйлүүдийг хөгжүүлэхгүй бол сэтгэцийн илүү нарийн, дээд үйлүүд хөгжих боломжгүй гэж тэрээр үзжээ. Өөрөөр хэлбэл, доод, энгийн үйлүүд нь дээд, нарийн үйлүүдийнхээ суурь болж өгдөг байна. Сэтгэцийн дээд үйлүүдийн хөгжлийг хангах эх сурвалжийн үүргийг орчин гүйцэтгэдэг гэж үзэхийн зэрэгцээ хүүхдийн дотоод онцлог нөөцийг харгалzan үзэхгүйгээр орчны нөлөөг хэтрүүлэн үнэлж болохгүй гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Сэтгэцийн дээд үйлүүдийн хуулийг доорх байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Эхлээд орчны хүмүүс нь хүүхдэд хандаж зохих нөлөө үзүүлнэ.
2. Дараагийн шатанд хүүхэд орчныхоо хүмүүстэй харилцан үйлчлэлцэж эхэлнэ.
3. Үүний дараагаар хүүхэд бусдад хандаж үйлчлэх чадвартай болно
4. Эцэст нь хүүхэд өөрөө өөртөө, өөрийн дотоод оюуны үйлд тулгуурлан хандах чадвартай болно.

Түүний энэ үзэл санааг хүүхдийн зориудын анхаарлын хөгжил дээр илүү харж болно. Энэ нь том хүмүүс эхлээд хүүхдийн анхаарлыг үг ярианы тусламжтайгаар орчны зүйлс дээр төвлөрүүлнэ. Энэ тохиолдолд үг бол хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэгч гол өдөөгч нь болж өгнө. Дараа нь хүүхэд хэлд орж ярьж сурна. Анхаарал төвлөрүүлэгч үг өдөөгчийг хүүхэд өөрөө ашиглаж сурч байна гэсэн үг юм. Цаашдаа хүүхэд өөрийнхөө үгийн тусламжтайгаар насанд хүрэгчдийн анхаарлыг сонирхсон зүйл рүүгээ хандуулж эхэлнэ. Эцэст нь гаднаас хараад ямар ч тулгуур хэрэгсэлгүйгээр анхаарлаа дотроо төвлөрүүлэх чадвартай болно. Сэтгэцийн дээд

үйлүүд нь хүүхдийг нийгмийн амьдралд сургах сургалтын явцад хөгжиж төлөвшдөг байна. Ийм учраас Л.С.Выготский **сэтгэцийн хөгжлийн хөдөлгөгч хүч нь сургалт юм** гэж үзжээ.

**Хүснэгт 2. Хүүхдийн оюун ухааны хөгжлийн түвшин ба сургалтын харилцан нөлөөлөл (Л.С.Выготский)**

Оюун ухааны хөгжлийн тухайн үеийн түвшин	Оюун ухааны хөгжлийн «ойрын бүс»
Хүүхэд хэний ч туслалцаагүй өөрөө бие даан хийж чадаж байгаа зүйлүүд Өнөөдөр хийж чадаж байгаа зүйл, хэрэглэж байгаа уг хэллэг зэргээр тодорхойлогдоно.	Хүүхэд хараахан бие даан хийж чадахгүй байгаа, насанд хүрэгчдийн ялимгүй туслалцаатайгаар маргааш хийж чадах зүйлүүд юм. Хариугүй боловсорч гүйцэх гэж байгаа жимстэй зүйрлэж болох юм. Ялимгүй усалж бордвол боловсорч гүйцэх гэж байгаа жимстэй адил зүйлүүд нь хүүхдийн хөгжлийн ойрын бүсэд багтдаг. Сургалтад үзүүлэх нөлөөлөл: Хүүхдийн оюун ухааны хөгжлийн «ойрын бүсэд» тулгуурласан сургалт нь түүнийг эрчимжүүлэх чухал нөхцөл болно.
Сургалтанд үзүүлэх нөлөөлөл: Мэдлэг чадварын түвшинг тодорхойлоход хэрэг болно. Энэ түвшин дээр баримжаалан сургалт, хүүхдэд аливааг танин мэдэх ажлыг зохион явуулвал хүүхдийн оюун ухааны хөгжил эрчимтэй явагдахгүй. Хүүхэд хичээлээс уйдаж залхах нэг шалтгаан болно.	Гэхдээ хэт хол түрүүлж болохгүй «Хараахан хийж чадахгүй байгаа, гэхдээ маргаашхийжчадах» зүйлүүдийг баримжаалан хүндрэлийн түвшингээ тодорхойлно. «Насанд хүрэгчдийн ялимгүй туслалцаа» гэсэн ойлголт нь хүүхдийн сэтгэлгээг өдөөж өгөх, санаа авхуулах зэрэг дэмжлэгүүдийг илтгэнэ.

Хүүхдийн оюун ухааны хөгжлийн эдгээр түвшинг практик дээр хэрхэн ялгаж тодорхойлох нь багшлах үйл ажиллагааны өдөр тутмын хэрэглэж байгаа аргуудаар тодорхойлогдоно. Зургаан настай хүүхдийн оюун ухааны хөгжлийн дээрх онцлогуудын зэрэгцээ тэдний танин мэдэх үйлийн онцлогийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд, хүүхдийн хүртэхүйн хөгжил, ой тогтоолтын хөгжил, анхаарал, сэтгэхүйн хөгжил, хүүхдийн суралцах чадвар зэргийг харгалзах шаардлагатай.

## 1.2. Зургаан настай хүүхэд гэж хэн бэ?

Хүний хөгжлийн явц, хурд, гадаад орчны нөлөөллийн үр дүн насны үе шат бүрт харилцан адилгүй байдаг. Нэгэн биеийн хөгжил буюу төрөхөөс эхлээд өөд болох хүртэлх хугацааны хөгжлийг онтогенетик хөгжил гэдэг. Өсч хөгжиж байгаа организм гадны орчноос үзүүлж байгаа нөлөөллийг сайн хүлээж авдаг үе гэж байдаг. Үүнийг нас зүйн сэтгэл судлалын шинжлэх ухаанд «хөгжлийн мэдрэмтгий үеүд» гэж нэрлэдэг. Зургаан нас бол бусад настай харьцуулахад ийм мэдрэмтгий үеүд ихтэй нас юм. Дөнгөж хөгжиж эхэлж байгаа сэтгэцийн үйлүүдэд сургалт, орчны нөлөө маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ хүүхдийн хувийн онцлогийг заавал харгалzan үзэх хэрэгтэй. Зарим хүүхдийн хөгжил эрт, эрчимтэй явагддаг байхад заримынх нь арай хожуу, удаан явагдаж байж болох юм. Гэхдээ хүүхдийн хөгжлийн дундаж онцлог, зүй тогтол гэж байдаг. Үүнийг тухайн насны хүүхдийн хөгжлийг тодорхойлох баримжаа болгодог. Тухайн үед эрчимтэй хөгжиж байгаа сэтгэцийн үйлүүдийг цаг тухайд хөгжих боломжоор хангах нь чухал юм. Сэтгэцийн эрчимтэй хөгжих өөр өөрийн гэсэн цаг мөчтэй байдаг гэж хэлж болно. Тэдгээрийг хөгжих ёстой цагт нь хөгжүүлэхэд эдгээр боломж чиглэгдэнэ.

### Хүснэгт 3. Хүүхдийн хөгжил эрчимтэй явагдах үеүд

Хүүхдийн нас	Сэтгэцийн үйлдлүүдийн эрчимтэй хөгжих боломж
1.5-3 нас	Хэл яриа
3-6 нас	Хүртэхүй, сэтгэхүй, зохион бодохуй
5-6 нас	Хөдөлгөөний эвсэл
5-6 нас	Унших чадвар эзэмших
6-7 нас	Суралцах дадал эзэмших

### Зургаан нас бол эрчимтэй хөгжлийн үе мөн

Зургаан насны үед тархины хөгжил том хүнийхтэй адил болох бөгөөд хэл яриа, сэрэл, хүртэхүй зэрэг сэтгэцийн олон үйлүүд эрчимтэй хөгжих, хөдөлгөөний дадлууд амжилттай төлөвших боломжтой гэж үздэг учраас хүүхдийг энэ наснаас эхлэн сургуульд сургахыг чухалчилдаг байна. Унших болон суралцах дадал эзэмшихэд зайлшгүй хэрэгтэй сэтгэцийн олон үйлүүдийн эрчимтэй хөгжлийн зангилаа үе болох нь илэрхий байна.

Сургуульд орж байгаа зургаан настай хүүхэд нь долоон настай хүүхдээс ихээхэн ялгаатай. Үүнд:

1. Хүүхдүүдийн хувийн ялгаа мэдэгдэхүйц илэрч байдаг. Энэ нь хүүхэд хэдий чинээ бага байх тусам яг л өөрийнхөөрөө байх хандлага хүчтэй илэрдэгтэй холбоотой.
2. Тоглох үйл ажиллагаанаасаа суралцах үйл ажиллагаанд шилжих шилжилт алгуур явагддаг. Учир нь энэ насны хүүхдийн сэтгэцийн хөгжилд тоглоом шийдвэрлэх үүрэгтэй хэвээр байдаг. Тоглоом чөлөөт шинжтэй бол сургалт илүү зорилго зохион байгуулалттай байдаг.
3. Хүүхдийн нийгэмд эзэлж байсан байр суурь өөрчлөгдөж эхэлдэг. Гэртээ буюу цэцэрлэгт хүмүүжиж байсан хүүхэд сургуульд орж байгаатай холбоотой.

4. Хүүхдийн өөрийн үнэлгээ харьцангуй тогтвортой, эерэг болж ирнэ. Ихэвчлэн өөрийгөө сайн гэсэн өндөр үнэлгээ зонхилох ба хааяа доогуур үнэлгээтэй байх нь бий.
5. Зан байдлыг үнэлхээсээ илүүтэйгээр ямар нэгэн бодит үйлдэл, үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, олж харах чадвар нь сайжирдаг.

Зургаан настай хүүхдийн сэтгэцийн хөгжил нь дараах онцлогтой байдаг. Үүнд:

- Харагдах дүрсийн сэтгэлгээ хадгалагдсаар байдаг ба харж, дүрсэлж байгаа зүйл дээрээ тулгуурлан сэтгэнэ.
- Зориудын бус ой зонхилсон хэвээр байна. Зорилго, чиглэлтэйгээр юмыг тогтооё гэж хүч чармайлт гаргахаасаа илүү сэтгэл татаж, нүдэнд өртөж байгаа зүйлүүдийг буюу санамсаргүйгээр юмыг тогтоох хандлага хэвээр байна.
- Анхаарал нь сургуулийн өмнөх насны хүүхдийн онцлогийг хадгалсаар байдаг. Анхаарлаа ямар нэгэн зүйлд зорилго, төлөвлөгөөтэйгээр хандуулж жолоодох чадвар сайн хөгжөөгүй байна.
- Зургаан насны үед сайн муу ба сайхан муухай гэх зэрэг ёс суртахууны чанаруудыг өөрийн сэтгэгдэлд тулгуурлан ойлгоно. Мөн түүний мөн чанарыг биш бодит тоо, хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг чухалчилдаг. Нэг аягыг уурлаад зориуд шидэж хагалсан хүүхдээс олон аягыг санамсаргүй унагаж хагалсан хүүхэд муу, учир нь тэр олон аяга хагалсан гэх мэт.
- Бусдыг болон өөрийгөө үнэлхэдээ томчуудын үнэлгээг дуурайх ба хуулбарлах хандлагатай байдаг. Тэдний үнэлгээнд эцэг эх, багш нарын үнэлгээ, хандлага их чухал байдаг.
- Танин мэдэх сэдэл нь тогтворжоогүй, цаг зуурын шинжтэй.
- Хүүхэд өөрийн нийгмийн байдал өөрчлөгдөж байгааг төдий л ухаардаггүй. Иймээс хичээл ба тоглоомын ялгаа, нийгмийн ач холбогдлыг эхний үедээ төдий л ялгаж салгаж чаддаггүй.

Зургаан настай хүүхдийн танин мэдэхүйн хүрээнд тохиолдох бэрхшээлүүд:

- Хэд хэдэн шинж тэмдгүүдийг хооронд нь харьцуулах
- Юмны мөн чанарыг ялгах
- Сэтгэхүйн өөр нөхцөлд шилжүүлэн хэрэглэхэд бэрхшээл үүснэ.

### Зургаан настай хүүхдийн хэл ярианы хөгжил

Хүүхдийн танин мэдэх үйлийн хөгжил нь тэдний хэл ярианы хөгжилтэй салшгүй холбоотой байдаг.

#### Хүснэгт 4. Хүүхдийн үгийн нөөцийн хөгжил

Нас	Үгийн тоо	Чанарын хөгжил
1 нас	10	Үгийн тоо нэмэгдэж
1.5-2 нас	20	Үгийн тоо нэмэгдэж
3 нас	1500	Хүүхэд хэлний дүрмийн бүтцийг эзэмшинэ
6 нас	4500	

Хүүхдийн хэл яриа улам хөгжиж үгүүдийг хэрэглэх чадвар сайжирна. Үг, ярианд тулгуурлан сэтгэцийн үйл явагдах боломжтой болно. Жишээлбэл «ам дөрвөлжин зураарай», «нэг дээр хоёрыг нэмээрэй», «хүүхэд зодож болохгүй, энэ бол муу хүүхдийн зан», «гол руу хамаагүй орж болохгүй живнэ» гэх зэрэг үгээр өгч байгаа заавруудыг ойлгох ба уг заавруудад тулгуурлан сэтгэх, үйлдэл хийх чадварууд сайжирна.

Хүүхдийн амьдарч буй орчин, эцэг эхийн хандлага харилцаа зэрэг олон хүчин зүйл хүүхдийн хэл ярианы хөгжилд нөлөөлнө. Иймээс хүүхдийн хэл ярианы хөгжилд хувийн ялгаа нэлээд ажиглагддаг. Зургаа орчим насын үед хэл яриаг хүртэж мэдрэх чадвар сайжирна. Хүүхэд үг авиааг сайн ялгаж сонсох бөгөөд доорх онцлогийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- 5 насын үед хүүхдэд үгийн дуудлагыг зөв эзэмшүүлэхэд 6 орчим насын үед эгшигт ба эгшигт биш гүйгүүлэгчдийн ялгааг таниулах, унших арга эзэмших зэрэгт сургахад анхаарвал илүү үр дүнтэй.

### 1.3. Зургаан настай хүүхдийн бие бялдрын хөгжлийн онцлог

5-7 насын үед буюу зургаа орчим насанд хүүхдийн бие бялдрын хөгжилд чанарын өөрчлөлтүүд гарах ба эдгээр өөрчлөлтийн үндсэн дээр хүүхэд сургуульд суралцахад бие бялдрын хувьд бэлэн болдог байна.

Зургаан настай хүүхдийн бие бялдрын хөгжлийн ерөнхий онцлог:

- Тархины хөгжил том хүнийхтэй бараг адилхан болсон байдаг
- Биеийн жин ба өндөр нэмэгдэнэ
- Хөдөлгөөний хөгжил сайн явагдсан байдаг
- Ясжилт явагдаж байгаа үе
- Нурууны яс, нугаламны мөгөөрс бэхжиж тогтоогүй үе
- Сарвууны булчингийн зохицолдлогоо явагдаж байгаа үе

### Тархины хөгжил

2-6 насанд тархи хурдацтай хөгжих ба таван насы үеэс эхлээд хүүхдийн тархи нь том хүнийхтэй бараг адилхан болдог. Тархины энэхүү эрчимтэй хөгжил нь хүүхдийн танин мэдэх үйл хөгжих боломжийг тэлж өгдөг. Үүний үндсэн дээр балчир насы үед хийх чадваргүй байсан хөдөлгөөнүүд, тухайлбал, биеийн ерөнхий хөдөлгөөн, бичил хөдөлгөөнүүд хөгжих нөхцлийг бүрдүүлдэг бөгөөд нарийн төвөгтэй олон дадал эзэмших боломж бий болно.

Тархины өмнөд хэсэгт байрлах анхаарал ба үйлдлийн ойн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг префронтал кортекс 3-6 насанд эрчимтэй хөгждөг. Энэ нь хүүхдийн танин мэдэх үйлийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй.

Хүний тархи зүүн ба баруун гэсэн хоёр хагас тал бөмбөлгөөс бүтдэг. Тал бөмбөлөг тус бүр өөр өөрийн гэсэн үүрэгтэй байдаг. Жишээ нь, 3-6 насны үед хүүхдийн хэл яриа маш эрчимтэй хөгжих ба энэ нь зүүн хагас тал бөмбөлөгийн үйл ажиллагаатай холбоотой байдаг. Өөрөөр хэлбэл, зүүн хагас бөмбөлөгийн үйл ажиллагаа сургуулийн өмнөх насанд эрчимтэй хөгжөөд аажмаар удаашрах ба 8-10 насны үеэс эхлэн баруун хагас бөмбөлөгийн үйл ажиллагаа эрчимждэг гэж үздэг.

2-6 насанд тархины зүүн хагас тал бөмбөлөг баруунаасаа илүү эрчимтэй хөгжиж байгаа нь ярих, бичих, унших шинжлэх ухааны энгийн ухагдахуун эзэмших чадвар дадал эзэмшихэд нэн тохиромжтой нөхцлийг бүрдүүлдэг байна. Ихэнх хүүхэд баруун гараараа бичиж байгаа нь тархины зүүн хагас бөмбөлөгт байгаа баруун гарын хөдөлгөөнийг удирдах төв хүчтэй давамгайлан хөгжсөнтэй холбоотой. 4-5 насны үеэс эхлэн хүүхдийн аль нэг гарын хөдөлгөөн зонхицж ирэх ба цаашдаа тогтвржиж даддаг байна. Сургуульд орсон хүүхэд зүүн гараараа бичиж, юм хийж сурсан байвал түүнийг хүчээр засах, гар руу цохиж айлгах зэрэг аргуудыг хэрэглэж болохгүй. Энэ нь хүүхдийн цаашдын хөгжилд муугаар нөлөөлж болно.

### Биеийн жин ба өндөр

Зургаан нас бол хүүхдийн өндөр ба жин хурдацтай өсөх үе юм. Эрүүл хүүхдүүд 2-6 насандаа жин нь жилд дундажаар 2 кг, өндөр 8 см нэмэгдэж байх ёстой гэж үздэг. Хүүхдийн биеийн хэсгүүдийн харьцаа нь жаахан хүүхдийнхээс ялгаатай болж ирнэ. Хөгжилтэй орнуудын зургаан настай хүүхдийн жин дундажаар 21 кг, өндөр нь 116 см болсон байдаг. Гэхдээ хүүхдийн жин ба өндөр нь тухайн улс орны хөгжлийн онцлог, удамшил, хүүхдийн амьдралын нөхцөл, хоол тэжээлийн онцлог зэрэг олон хүчин зүйлээс шалтгаална.

### Хүснэгт 5. Зургаан настай хүүхдийн биеийн жин ба өндөр

Манай улсад				Хөгжилтэй орнуудад	
Биеийн жин		Өндөр		Биеийн жин	Өндөр
эр	эм	эр	эм	21 кг	116 см
19-20кг	18-19 кг	117 см	116 см		

Үүнээс үзвэл манай орны зургаан настай хүүхдүүд бие бялдрын хөгжлийн хувьд бусад орны хүүхдүүдийн нэгэн адилаар сургуульд суралцахад бэлэн болсон байна.

### Араг ясны хөгжил

Яс хөгжихийн хэрээр бие махбодийн хүч нэмэгдэнэ. 5-6 нас бол ясжилт явагдаж байгаа үе юм. Нурууны яс, нугаламны мөгөөрс бэхжиж тогтоогүй үе учраас хүүхдийн ширээ сандал, араг ясанд гаднаас өгөх ачааллыг зөв тохишуулах хариуцлагатай үе юм. Ясжилтын үйл явц нь хүүхдийн хүйсээс хамаарах бөгөөд 2-6 насны хооронд охидын ясжилт хөвгүүдийнхээс хэд хэдэн сараар түрүүлж явагддаг. Зургаан настай хүүхдийн араг ясны хөгжил тэдний хөгжлийн хувийн онцлогоос шалтгаалан өөр өөр байдгийг судлаачид тодорхойлжээ. Зарим хүүхдийн араг ясны ясжилт наснаасаа түрүүлж байхад нөгөө хэсэг хоцорч байдаг. Энэ нь зургаан настай хүүхдийн биеийн хүчний ачаалал даах чадвар өөр өөр байна гэдгийг харуулж байгаа юм. Иймээс тэднээр биеийн хүчний дасгал даалгаврыг гүйцэтгүүлэхдээ хүүхдийн биеийн хөгжлийн ерөнхий онцлог ба явцыг зайлшгүй харгалзан үзэх хэрэгтэй юм.

### Хүүхдийн хөдөлгөөний дадал, гар хурууны бичил хөдөлгөөн

Сургуулийн өмнөх нас бол хүүхдийн хөдөлгөөний дадал эрчимтэй хөгжих үе. Хүүхдийн хөдөлгөөнийг ерөнхий том хөдөлгөөн, бичил хөдөлгөөн гэж хоёр ангилдаг. Далайц ихтэй, бүх биеийн оролцоо шаардсан хөдөлгөөнийг том хөдөлгөөн гэнэ. Далайц багатай, оновчтой ажиллагаа шаардсан хөдөлгөөнийг бичил хөдөлгөөн гэнэ. Хүүхдийн хөгжлийг хөдөлгөөний болон танин мэдэхүйн хөгжил гэх зэргээр хувааж байгаа нь харьцангуй юм.

### Хүснэгт 6. Зургаан настай хүүхдийн хөдөлгөөний хөгжил

Явж, гүйж, харайх чадвар улам сайжирна. Энгийн уяа уях, үдээсээ үдэх чадвартай болно. Зөвлөн зүйлийг хутгаар зүсэх эв дүйтэй болж ирнэ. Сайн ойлгосон, өмнө нь сайн мэддэг хөдөлгөөнийг үгэн зааврын үндсэн дээр хийх чадвартай болно.

Хүүхдийн хөдөлгөөний эвсэл сайжрахын хирээр төрөл бүрийн спорт сонирхох, томчуудын нүдээр харахад дэггүйтэх маягийн зүйлүүдийг хийдэг. Үүнд өндөр зүйл рүү авирах, юмнаас зүүгдэх, үсрэх гэх мэтээр хүүхдүүд хөдөлгөөний чадвар дадлаа сорих, хөгжүүлэх зорилгоор хийж байгаа эдгээр үйлдлийг аюулгүй байлгах, тайлбарлах талаас томчууд анхаарах нь зүйтэй.

### Хүснэгт 7. 5-7 настай хүүхдийн бие бялдрын хөгжил

- Өндөр ба жин тогтвортой нэмэгдэнэ.
- Хөвгүүд охидын биеийн хүч тогтвортой сайжирна
- Биеийн хэсгүүдийн хөдөлгөөнөө ухаарал нэмэгдэнэ
- Биеийн бүх хэсгүүдийнхээ боломжийг илүү бүрэн ашиглана
- Том, ерөнхий хөдөлгөөнүүд цаашид боловсронгуй болно
- Хөдөлгөөний чадваруудаа нэгтгэж чадахгүй

### *Гар хурууны бичил хөдөлгөөн*

Нарийн оновчтой хөдөлгөөн хийхэд зайлшгүй шаардлагатай эдгээр хөдөлгөөнүүдийн хөгжил 6-7 орчим насанд эрчимтэй явагддаг. Хүүхдийн хөдөлгөөн улам оновчтой болсоор зургаан нас гэхэд баримлын шавар мэтийн зөвлөн зүйлийг тоглоомын хутгаар зүсэх, энгийн уяа уях, халбага сэрээ зөв хэрэглэх чадвартай болно. 5-6 настай хүүхдүүдийн гар хурууны бичил хөдөлгөөнийг хөгжүүлэхэд будаг харандаагаар төрөл бүрийн зүйлүүдийг зурах, баримлын шавраар дүрс хийх, өнгийн цаасаар дүрс хайчлах, нугалах зэрэг үйлдлүүд чухал ач холбогдолтой. Үүнд зурах, бичих, наах, зохион бүтээх зэрэг хүүхдийн бүтээлч үйл ажиллагаанууд чухал үүрэгтэй. Хүүхэд эхлээд тойрог, дөрвөлжин, зурах дараа нь гурвалжин зурах зэргээр суралцдаг. 6-7 нас гэхэд бичиж сурахад зайлшгүй хэрэгтэй хөдөлгөөний дадлууд хүүхдэд бий болсон байдаг. Гэхдээ сэтгэцийн хувьд эрүүл зарим хүүхдүүд найман нас хүртлээ ромбо зурах ба зарим үсгийг бичих чадваргүй байж болно.

### **1.4. Зургаан настай хүүхдийн оюун ухаан, танин мэдэхүйн онцлог**

Швейцарын нэрт сэтгэл зүйч Жан Пиаже (1862-1980) хүүхдийн оюун ухааны хөгжлийг судалж маш өвөрмөц зүй тогтолцуудыг нээжээ. Тэрээр хүүхдийн оюун ухааны хөгжлийн онцлогийг харуулсан олон туршилт-бодлогуудыг боловсруулсан нь өнөө хир сургалтанд өргөн хэрэглэгдсээр байгаа юм. Жишээ нь, нэг бодлогыг сонгон авч үзье. Хүүхдүүдэд дөрвөн нохой, гурван муурын зураг харуулж «аль нь олон байна вэ?» гэж асуужээ. 6, 7 орчим насны хүүхдүүд энэ асуултанд зөв хариулж чаддаг. »Нохой олон байна« гэж хэлнэ. Харин тэднээс нохой олон байна уу, амьтан олон байна уу гэж асуухад ихэвчлэн дахиад л «Нохой олон байна гэж» хариулдаг. Өөрөөр хэлбэл, буруу хариулдаг. Эсвэл тохиолдлоор зөв хариулна. Харин 7-оос дээш насныхан бол зөв хариулдаг. Яагаад, гэсэн асуулт гарах нь дамжигүй. Энэ асуултанд хариулахын тулд хүүхдийн оюун ухааны хөгжлийн талаарх түүний онолыг товч тайлбарлая. «Мэдлэг бол үйлдэл юм» гэж Пиаже үзээд үйлдлийн явцад схемүүд бий болно. Хүмүүс хөгжлийнхөө явцад мэдээллийг зохион байгуулах гадны ертөнцийг ойлгохын тулд илүү нарийн схемүүдийг хэрэглэж сурдаг гэх зэргээр тайлбарлажээ. Пиаже хүүхдийн оюун ухааны хөгжлийг чанарын хувьд өөр хоорондоо ялгаа бүхий дөрвөн үе шат болгон ангилжээ.

- Хүртэх хөдөлгөөний шат (0-2 нас)
- **Үйлдэл төлөвшихөөс өмнөх шат (2-7 нас)**
- Тодорхой үйлдлийн шат (7-12 нас)
- Хийсвэр үйлдлийн шат (12-оос дээш нас)

Бид зургаан настай хүүхдийн оюун ухааны онцлогийг тодорхойлохын тулд Пиажегийн энэхүү ангиллаас хоёр дахь шатыг буюу «Үйлдэл төлөвшихөөс өмнөх» үеийн сэтгэлгээний онцлогийг товч тайлбарлая. Хүүхэд хэлд орж тэмдэг, тэмдгийн системийг хэрэглэх болсноор энэ шат эхэлнэ. Хүүхэд өдөр тутмын туршлага дээрээ тулгуурлан тодорхой мэдлэг эзэмшдэг. Юмыг ангилж бүлэглэх, ерөнхийлөн дүгнэж чаддаггүй. Тийм ч учраас «Нохой олон байна уу, амьтан олон байна уу?»

гэсэн асуултанд зөв хариулж чаддаггүй. Тэдэнд «амьтан» гэсэн ерөнхий ойлголт төлөвших болоогүй байгаа үе юм. Харин нохой ба муурын талаарх тодорхой төсөөлөл байгаа учраас тэдний тоог зөв хэлж чадаж байгаа юм. Хэл яриа эзэмших болсонтой холбоотойгоор нэг зүйлийг нөгөөгөөр орлуулан сэтгэх чадвартай болно. Цаасыг бялуу, модны өөдсийг «авдар», хүүхэлдэйгээ «ээж» гэх зэргээр орлуулан төсөөлж тоглоомынхоо явцад тэр төсөөлөл дээрээ тулгуурлан үйл ажиллагаагаа зохицуулах чадвартай болдог. Гэхдээ хүүхэд үзэгдэл юмын хоорондын ерөнхий учир шалтгааныг ойлгож логикоор сэтгэх болоогүй гэж үздэг. 2-7 насны үеийн хүүхдийн сэтгэлгээ нь доорх хязгаарлагдмал талуудтай:

1. Хүүхдийн сэтгэхүй бодит, тодорхой шинжтэй: төсөөлөхөд хялбархан бодит зүйл дээр төвлөрөн сэтгэнэ.
2. Үзэгдэл юмын хоорондын холбоо хамаарлыг өрөөсгөл нэг чиглэлд сэтгэнэ. Хоёр талын хамаарал ба уялдаа холбоог нарийн төсөөлж чаддаггүй.
3. Хүүхэд ямар нэг зүйлийг хийх ба бодохдоо өөрийн үзэл бодлын үүднээс хийнэ. Юмыг өөр бусдын байр сууринаас бодож төлөвлөх нь энэ насны хүүхдэд их хэцүү байдаг. Үүнийг эгоцентр сэтгэлгээ гэнэ (ego- это би өөр дээрээ төвлөрүүлэн сэтгэх гэсэн утгатай үг).
4. Юмын аль нэг шинж чанарыг голлон авч үзэх хандлагатай. Өөрөөр хэлбэл, аль нэг шинж чанар дээр төвлөрүүлэн сэтгэдэг. Үүнийг хүүхдийн сэтгэлгээний төвлөрөл гэнэ. Хэд хэдэн шинж чанарт анхаарлаа төвлөрүүлэн сэтгэх нь тэдэнд бэрхшээлтэй байдаг. Жишээ нь, тэдэнд modoor хийсэн улаан ба шар өнгө бүхий бөмбөгнүүдийг харуулж аль өнгө нь олон байна вэ гэж асуухад зөв хариулах боловч харин улаан нь олон байна уу, modoor хийсэн нь олон байна уу гэхэд энэ хоёр шинж тэмдгийг зэрэгцүүлэн зөв хариулж чаддаггүй.
5. Тухайн үеийн зүйлийг –«энд ба одоо» гэсэн зарчимд тулгуурлан сэтгэх ба үйл явдлын цаашдын өрнөлийг төдий л тооцоолж чаддаггүй.

Гэхдээ зургаан нас бол хүүхдийн сэтгэлгээний эдгээр онцлогоос дараагийн шатанд шилжих шилжилт ойртох байгаа үе гэдгийг манай багш сурган хүмүүжүүлэгчид анхаарах хэрэгтэй юм. Пиажегийн үзсэнээр бол сэтгэлгээний энэ онцлог нь хүүхдийн хэл ярианы хөгжлөөр тодорхой харагддаг. Эгоцентр яриа буюу хүүхдийн өөрийн хэллэг, хувийн яриа гэж байдаг. Заримдаа хүүхдүүд ганцаараа ярьж, юмыг бидний нэрлэж заншсанаас өөрөөр нэрлэдэг. Жишээ нь, чихэр гэхийг «Гоогоо, чийдээ» гэх мэт. Ийм эгоцентр яриа нь турван насны үед оргил цэгтээ хүрээд, 3-5 насны хооронд аажмаар буурсаар долоон нас гэхэд алга болдог гэж Piаже үзжээ.

### Зургаан настны гол зонхилох үйл ажиллагаа

- **Зөвхөн тухайн насны үед илрэх ёстой чанарын онцлог, өөрчлөлт гэж байдаг. Энэхүү онцлогийг илэрч гаражад нөлөөлж байгаа үйл ажиллагааг гол зонхилох үйл ажиллагаа гэнэ.**

### Тоглоомын үйл ажиллагаа

Зургаан настай хүүхдийн гүйцэтгэх үйл ажиллагааны онцлог нь сургуулийн өмнөх насны ахлах бүлгийн хүүхдийн гол үйл ажиллагаанд сэдэвт үйлийн тоглоом

хэвээр үргэлжлэн хөгжиж байдаг. Сургуулийн өмнөх насны ахлах бүлгийн насанд зурах, угсарч эвлүүлэх зэрэг үйл ажиллагааны бүтээлч хэлбэрийн үйл үргэлжлэн хөгжиж байдаг. Үйл ажиллагааны эдгээр хэлбэрүүдийг ашигласнаар хүүхдэд системтэй сургалт, хөдөлмөрийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдах чухал чанарууд төлөвшиж эхэлнэ. Гэхдээ сургуулийн өмнөх насны хүүхдийн тоглоомоос сургуулийн сурагчдын тоглоом нь тодорхой зорилготой, сурх үйл рүү чиглэсэн байдгаараа ялгаатай. Тухайлбал, бөмбөг дамжуулах тоглоом тоглоходоо мэддэг шувууны нэрийг нэрлүүлэх, таван хошуу малыг нэрлүүлэх, тоо тоолуулах гэх мэт.

Хүүхдийн тоглоомын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахын тулд насанд хүрэгчид тоглоом нь бусад төрлийн ажлаас юугаар ялгараах вэ гэдгийг бодож үзэх хэрэгтэй. Үүний зааг ялгааг салгаж чадахгүй байснаараа хүүхдийг тоглоомын үйл ажиллагаагаар дамжуулан хөгжүүлэх боломжийг ашиглаж чадахгүйд хүрнэ.

Тоглоом, үйл ажиллагаа хоёрын хооронд маш их ялгаа байдаг гэж хүмүүс боддог ба энэ нь маш том эндүүрэл юм. Сайн тоглоом нь сайн ажилтай, муу тоглоом нь муу ажилтай адил гэж үздэг. Тоглоомын явцад хариуцлага, үүрэг байдаггүй гэж насанд хүрэгчид боддог бол идэвхигүй, хүч зарцуулаагүй тоглоомын нөлөө төдийлөн сайн байхгүй нь ойлгомжтой. Жишээ нь, дэлгүүрээс хүүхдэдээ зөвлөн тоглоом авч өглөө гэж бодоход хүүхэд түүнийг хэсэг хугацаанд хараад л сонирхохоо болино. Өөрөөр хүүхдэд үзүүлэх нөлөө бага байх болно. Насанд хүрэгчдийн зүгээс хүүхдийн тоглоомыг зохион байгуулахдаа дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- Зөвхөн хүүхдийн хүсэл сонирхолд хөтлөгдөх ёсгүй, тоглоомоос болж бусад харилцаа, орчноос тасрах ёсгүй. Энэ нь хүүхдэд аажмаар өөрчлөгдөх тоглоомын орчин нь хөдөлмөрийн орчноор солигдоход чухал үүрэгтэй.
- Тоглоом нь сэтгэл зүйн болон бие махбодийн дадлыг хөгжүүлэх ёстой. Ингэснээр хүүхэд сонголт хийх хэрэгтэй зүйлийг олж харах чадварыг хөгжүүлнэ.

Насанд хүрэгчдийн зүгээс хүүхдийн тоглоомын үйл ажиллагаа удирдан зохион байгуулж байгаа гурван буруу хандлага байдаг. Үүнд:

1. Нэг хэсэг насанд хүрэгчид хүүхдүүд тоглоомоо хэрхэн яаж зохион байгуулах аргаа өөрсдөө мэддэг гэж боддог. Энэ үед хүүхдүүд өөрсдөө тоглоомоо зохион байгуулна, хэрхэн яаж тоглохоо өөрсдөө зохион байгуулна, сонголт хийнэ,
2. Нөгөө хэсэг нь хэтэрхий их анхаарал хандуулж хүүхдийн тоглоомонд саад болдог. Тэд зааварчилдаг, ярьж өгдөг, тоглоомын явцад үүсэх асуудлыг урьдчилан өөрсдөө шийдвэрлэж өгөөд түүндээ сэтгэл хангалаун байна.
3. Гэтэл дараагийн хандлага нь маш их тоглоомтой байхыг чухалчилна. Эдгээр эцэг эхчүүд маш их мөнгийг тоглоомонд зарцуулж, маш олон тооны тоглоом цуглуулахыг зорьдог.

Хүүхдийн тоглоомын үйл ажиллагаа нь хөгжлийн хэд хэдэн шатыг дамждаг ба үе шат бүхэнд хүүхдийн хөгжлийн асуудал шийдэгдэж, түүнийхээ хирээр нарийн удирдах арга барил шаардана.

- Нэгдүгээр шат. Энэ нь өрөө тасалгаанд тоглох үе юм. Энэхүү үе шат нь 5-6 нас хүртэл үргэлжилнэ. Нэгдүгээр үе шатанд хүүхэд ихэвчлэн ганцаараа

тоглохыг хүсэх ба хааяа маш ховор тохиолдолд нэг хоёр хүүхэдтэй хамтрах тохиолдол байдаг. Хүүхэд зөвхөн өөрийн тоглоомоор тоглохыг хүснэ, хүний тоглоомоор тоглохыг хүсэхгүй. Энэ үе шатанд хүүхдийн хувийн онцлог бүрэлдэн тогтдог гэж үздэг. Энэ үе шатанд хүүхэд бусадтай хамтран тоглох чадвар төлөвшөөгүй байх ба олноороо байхад бусадтай муудалцах нь элбэг байх ба бүлэг хамт олны сонирхлыг харгалзан үзэх чадваргүй хараахан төлөвшөөгүйтэй холбоотой байна. Энэ онцлогийг харгалзан үзэж хүүхэд ганцаараа тоглох боломжийг олгох ба хэн нэгэнтэй хамтруулах, санаагаа тулгах зэргээр хүүхэд хандвал хүүхдийн тоглох сонирхол буурах, муухай аашлах болно.

- Хоёрдугаар үе шатанд тэдний тоглоомыг хянах зохицуулах нь хэцүү болж ирнэ. Учир нь энэ 11-12 нас хүртэл үргэлжилдэг ба эцэг эхийн хараа хяналтнаас гарч тоглох хүрээ нь өргөсөж сургуулийн цагийг эзэлж эхэлдэг. Сургууль нь наиз нөхдийн хүрээллийг тэлдэг ба хүүхдийн тоглоом өөрийн гэсэн зохион байгуулалт, бүлэглэл, сонирхлын хүрээг тэлдэг. Энэ үе шатанд хүүхэд бүлэг хамт олны нэг гишүүн болдог ба нийгмийн даган мөрдөх хэм хэмжээнд суралцаагүй байна. Энэхүү ёс дүрэмд суралцаад сургууль маш чухал үүрэг гүйцэтгэдэг ба ингэж сургууль үүргээ гүйцэтгэснээр хүүхэд тоглоомын үйл ажиллагааны гурав дах шатанд шилжин ордог.
- Гурав дах шатанд хүүхэд аль нэг бүлгийн гишүүн байх ба тоглоом нь аажмаар спортын, бие бялдарын, физиологийн хөгжлийн үүргийг гүйцэтгэх ба хатуу дүрэм, нийтийн сонирхлыг дагах хэрэгтэй болдог.

#### Тоглоомын хэлбэрүүд нь:

- Бэлэн, механик, энгийн тоглоомууд.** Энэ нь төрөл бүрийн автомашин, усан онгоц, хүүхэлдэй, бамбарууш, нохой гэх мэт. Энэ төрлийн тоглоом нь хүүхдийг шинэ төрлийн эд зүйл, шинэ санаатай танилцуулдаг ба хүүхэд хүний амьдралын чухал зүйлүүдийг сонирхох олон асуулт тавих нөхцлийг бий болгодог. Тийм учраас энэ төрлийн тоглоом нь зохион бодохуйн үйлдлүүдийг хөгжүүлдэг гэж үздэг.
- Хагас бэлэн тоглоомууд.** Энэ нь хүүхдээс зарим нэг зүйлийг гүйцээхийг шаардсан тоглоомууд юм. Төрөл бүрийн асуулттай зураг, хайчилбар зураг, шоо, эвлүүлэх хайрцаг, угсрал тоглоомууд. Энэ төрлийн тоглоом нь хүүхдийн өмнө тодорхой зорилго тавин түүндээ хүрэхийн тулд биеэ дайчлах, анхаарлаа төвлөрүүлэх хэрэгцээ үүсгэдэг. Энэ нь хүүхдийн чөлөөт сэтгэлгээнээс гадна сэтгэхүйн эмх замбараатай нарийн үйлдлүүдийг шаардах ба дэс дараалал, зүй тогтолд баримжаалах дадал бий болгоно. Харин энэ төрлийн тоглоом хүүхэд дутагдсанаараа хүүхэд аливаа зүйлийг нэг янзаар сэтгэх хэвшмэл сэтгэлгээтэй болох үндэстэй.
- Тоглоомын материал.** Энэ нь элс, баримлын шавар, картон, цаас, савх гэх мэт. Энэ төрлийн тоглоомууд нь хүүхдийн хязгааргүй мөрөөдлийг сэдэлжүүлэн бүтээлч зохион бодохуйг хөгжүүлнэ.

Тэгвэл эдгээр тоглоомуудын аль нь илүү хүүхдэд нөлөөлөх вэ?

- Эдгээр тоглоомын хэлбэрүүдийг хослуулах хэрэгтэй. Хэрвээ хүүхдэд нэг хоёр механик тоглоом байгаа бол, дахин бүү худалдаж аваарай, энэ хангалттай. Харин үүн дээр нэмж нэг угсрах тоглоом, бусад материалыг худалдан авахад л хангалттай. Ингээд л танай хүүхдэд бүх тоглоомын ертөнц бий боллоо гэсэн үг. Хүүхэд тоглоом хэт олон байх тусам түүн дотор алийг нь сонгохоо мэдэхгүй хэрхэн яаж тоглоохоо сонгоход хэцүү байдаг. Тийм учраас хүүхдэд цөөхөн тоглоом байх, түүндээ тохирсон зохион байгуулалт хийх боломжийг бий болго. Тэгээд хүүхдээ ажиглан тоглоомын явцад хүүхэд өөрийн алдааг олж харж түүнийг засаж залруулах оролдлого хийж байвал маш сайн.

Хүүхдийн тоглоомын үйл ажиллагаанаас дараах үр дүн гарахыг эрмэлзэх:

- Хүүхэд тоглох явцдаа зохиох, эвлүүлэх, бүтээх
- Нэг зүйлийг дуусгалгүй орхиод, нөгөө рүү орохоос сэргийлэх
- Тоглоом бүхэнд ирээдүйн үнэт зүйл хандлагыг мэдэрч хайлрадаг байх, тоглоомоо замбараатай, цэвэр эдлэх, тоглоомыг эвдэрсэн тохиолдолд хүүхэдтэйгээ хамтран засах сэлбэх, хамтран засварлах

### **Хүүхдийн хөдөлмөрийн онцлог**

- Хөдөлмөр нь үйл ажиллагааны бусад хэлбэрүүдийн адилаар хүүхдийн бие бялдар, танин мэдэх хөгжлийн төвшинд тохирсон байх,
- Хөдөлмөр нь хүүхдэд баяр баясгалан төрүүлсэн, ойлгомжтой, тодорхой, эцэст нь ямар үр дүнд хүрэх нь нээлттэй байх,
- Хөдөлмөр нь хүүхдэд эерэг харилцааны дадлыг төлөвшүүлэхэд чиглэсэн байх,
- Хүүхэд хөдөлмөрийн үр дүнг өөрөө шууд мэдэрч, тааламжтай сэтгэгдэл төрөхөөр байх,
- Хүүхэд гурван наснаас эхлэн хөдөлмөрлөх дур хүсэлтэй болдог. Хүүхдийн тоглох, хөдөлмөрлөх үйл ажиллагааны хооронд төдий л ялгаагүй юм шиг боловч тоглоомын энгийн үйлдлүүдээр хөдөлмөрлөх дадлыг эзэмшдэг. Зургаан насандаа хүүхэд өөртөө үйлчлэх, хөдөлмөрт оролцох дур сонирхолтой болох ба өөрийн хийсэн зүйлийг бусдаар үнэлүүлэх хүсэл тэмүүлэлтэй байна.

### **Хүүхдийн сурх үйл ажиллагаа**

Хөдөлмөрлөх үйл ажиллагаатай салшгүй холбоотой явагдана. Учир нь хөдөлмөрлөх үйл ажиллагаа нь заавал ямар нэг зүйлд дадал эзэмшихийг шаарддаг бол сурх үйл ажиллагаа нь хүүхдээс бүтээлч үйл, хүч чармайлт, суралцах идэвхийг шаарддаг. Хүүхдийн мэдлэг эзэмших үйл ажиллагаа нь дараах тодорхой зүй тогтлоор явагдана. Үүнд:

- Сургалтын тодорхой стандарт, хөтөлбөр баримт бичигт тулгуурлана. Энэхүү баримт бичгүүдэд хүүхдийн сурх үйлийн онцлогийг логик дэс дараалалтай тусгах шаардлагатай.

- Сурах үйлийн агуулга нь хүүхэд олон янзын тусгай дадал, мэдлэг эзэмшихэд чиглэгдсэн оюуны үйлдлийг шаарддаг.
- Сурах үйл ажиллагаа нь хүүхдийн хамтын хөдөлмөрт сургаж байдаг. Хүүхэд сургалтын явцад бие биенээсээ суралцана, үерхэж нөхөрлөх боломжтой.
- Хүүхдийн сурах үйл ажиллагааны агуулга гүнзгийрэх, нийгэм өөрчлөгдхийн хирээр сургалтанд тавигдах шаардлага мөн өөрчлөгднө.

Сургуульд элсэн орсон хүүхдэд тулгардаг дараах гурван түгээмэл тулгамдсан асуудал байдаг. Үүнд:

- Сургуулийн шинэ дэг журмын онцлогийг биелүүлэхэд тулгарах бэрхшээл. Жишээ нь, өглөө эрт босож тогтсон цагт хичээлд явах, хичээл бүр дээр томоотой суун багшийн зааж буй зүйлийг тогтох хүлээн авах, гэрийн даалгавар цагт нь биелүүлэх зэрэг нь ихээхэн хүнд бэрхшээлийг хүүхдэд учруулна. Үүнээс болж хүүхэд эхэн үед амархан эцэж ядрах, сонирхол алдах, залхуурах, дэг алдах зэргээр хуучин хэвшлээ хэвээр үргэлжлүүлэхийг эрмэлзэнэ. Гэхдээ зарим хүүхдүүд сургуулийн дэг журам, хэвшил зуршлыг ямар нэг хэмжээгээр өөртөө төлөвшүүлэх сэтгэц физиологийн зохих бэлтгэлтэй болсон байна. Харин багш эцэг эхчүүдээс хүүхэд сургуульд ороод тэдний өмнө зайлшгүй тавигдах шаардлагыг хурц, тод ойлгомжтой хэлбэрээр ухааруулан мэдүүлж өгөхийн дээр түүний гүйцэтгэлийг байнга шалгаж байх нь чухал.
- Багш, ангийн хамт олон, гэр бүлийн бусад гишүүдтэй харилцааны шинж чанараас үүсэж гарах бэрхшээл юм. Багш хүүхдэд аль болох хайртай элэгсэг дотно байхын зэрэгцээгээр тэдэнд нэр хүндтэй хатуу шаардлагатай зарчмыг нарийн баримталдаг байх ёстой. Зарим хүүхэд шинэ хамт олонд дасахгүй, хүүхэдтэй үерхэхгүй ганцаардмал байдалтай байдаг. Багш бүх хүүхдэд адил шаардлага тавихын зэрэгцээ хүүхэд нэг бүр тэрхүү шаардлагыг хэрхэн биелүүлж байгааг нарийн ажиглана. Энэ нь багшид хүүхэд нэг бүрийн сэтгэл зүйн хувийн онцлогийг таних боломж олгоно. Хүүхдийн сургуульд орсон үеэс эхлэн хүүхэд гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа орчин нөхцөлд ч гэсэн өөрчлөлт орно. Жишээ нь, хүүхдэд гэртээ гэрийн даалгавар биелүүлэх цаг, байр, өдрийн дэг журамд захирагдах, өөртөө шинэ хэвшил тогтоох, шинэ зуршлыг биелүүлэх шаардлага гарч ирнэ.
- Нэгдүгээр ангийн хүүхдэд тохиолдох энэ бэрхшээл нь нэгдүгээр ангийн дунд үед илрэх ба хүүхэд шинжлэх ухааны ухагдахуунуудтай танилцах явцад оюун ухааны үйлийн арга барил, чадвар дадлыг эзэмших явцад их хүч хөдөлмөр зарцуулдаг ба зааж байгаа зүйлийг тогтоох, сэтгэх, эвлүүлэх, сэргээн санах зэрэг сэтгэхүйн үйлд бэрхшээл учирна.

## II БҮЛЭГ. «МИНИЙ ГЭР, СУРГУУЛИЙН ОРЧИН» БҮЛЭГ СЭДВИЙН АРГА ЗҮЙ

### 2.1. «Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийн киррикюлим

#### Хамрах хүрээ

ЕБС-ийн зургаан настай 1-р ангийн сурагчид

#### Хэрэгцээ

##### Суурь хэрэгцээ

- Хүрээлэн буй орчиндоо зохицон эрүүл аж төрөх
- Жилийн дөрвөн улиралд тохируулан зөв хооллох, хувцаслах
- Байгалиа хайрлах, танин мэдэх, байгалийн гоо сайхныг мэдрэх
- Ургамал, амьтныг хайрлах, хамгаалах
- Гол усаа хайрлах, усыг зөв зохистой хэрэглэх

##### Танин мэдэхүйн хэрэгцээ

- Бидний эргэн тойронд (гэр, сургуулийн орчинд) ямар ямар зүйлс байдгийг ажиглаж мэдэх
- Өөрсдийн ажиглаж мэдсэн зүйлсээ өөрийн үгээр тайлбарлах, зурах, бүтээх, наах, эвлүүлэх
- Өөрийн харсан, ажигласан, бүтээж хийсэн зүйлсээ бусдадаа хэлэх, тайлбарлах, хамтран ярилцах

**Зорилго:** ЕБС-ийн зургаан настай 1дүгээр ангийн сурагчдад хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулж, байгаль, нийгмийн ялгаатай, олон янз байдлын талаар анхны ойлголт өгнө.

Энэ бүлэг сэдвийн хүрээнд суралцагчдад дараах цогц чадамжуудыг эзэмшүүлнэ.

#### Мэдэхүйн цогц чадамж

- Өөрсдийн гэр, сургууль болон орон нутгийнхаа ойр орчинтой танилцах,
- Эргэн тойронд байгаа юмсыг харах, ажиглаж сурах,
- Тэдгээрийг таньж мэдэх, ойлгох
- Өөрийн орон нутагт байгаа соёл үйлчилгээний газруудтай танилцах, хэрхэн үйлчлүүлэх талаар энгийн ойлголттой болох

### **Хийж гүйцэтгэхийн цогц чадамж**

- Θөрсдийн харж ажигласан зүйлсээ нэрлэх, тоочих, ялгаж таних
- Θөрсдийн үзэж харсан зүйлсээ гарын доорх болон байгалийн материал ашиглан бүтээх, наах, зурах, тоглоом хийх, тоглох

### **Оршин байхын цогц чадамж**

- Амьдарч байгаа газар нутгийнхаа цаг агаар, онцлогт тохируулан зөв хооллох, хувцаслах,
- Эрүүл аж төрөх аргаас суралцах,
- Соёл үйлчилгээний газруудаар зөв боловсон үйлчлүүлэх

### **Нийгэмшихүйн цогц чадамж**

- Θөрсдийн мэдсэн зүйлийг бусаддаа тайлбарлах, үзэл бодлоо солилцох, харилцан ярилцах
- Бусдыг сонсож өөрийн бодол санаагаа чөлөөтэй илэрхийлж сурах
- Багаар ажиллах чадварт суралцах, аливаа асуудлыг хамтран шийдвэрлэх анхны арга ухаанд суралцана.

**«Миний гэр, сургуулийн орчин» бүлэг  
сэдвийн киррикюлим**

№	Хичээлийн сэдэв	Цаг	Зорилго	Зорилт	Хэрэглэгдэхүүн	Арга зүй
1	<b>Миний эргэн тойронд юу байдаг вэ?</b>	2	Суралцагчадад өөрийнх нь эргэн тойронд байдаг зүйлсийг таниулах, нэрлүүлэх, ажигласнаа тэмдэглэх суралц болон эруул аж төрөх, аюулгүй амьдрах энгийн ойлголтыг өгнө.	<ul style="list-style-type: none"> <li>Хүрээлэн буй орчноо танъж мэдэх,</li> <li>Ажиглаж мэдсэн зүйлээ өөрийн угээр илэрхийлэх</li> <li>Эрүүл аюулгүй амьдрах аргад суралцах</li> <li>Хамтран ярилцах, тоглох, зурж бүтээх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бөмбөг, Улаан ба цэнхэр дарцааг</li> <li>- Зураг</li> <li>- Модны навчис, боргоцой, чулуу, мод, элс, мөчир гэх мэт элс, мөчир гэх мэт шавар (баг бүрт 2, 2 ширхэг)</li> <li>- «Бөмбөг» дутай кассет, хөгжим</li> </ul>	Хичээлийг экскурс хэлбэрээр явуулна. Аливаа зүйлийг ажиглан танин мэдэх үйлийн аргад сургах, асуудал шийдвэрлүүлэх, ажиглалт, харьцуулалт хийгүүлэх, тоглуулах, бүтээлгэх зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ.
2	<b>Гэрээс сургууль хүрэх замд</b>	1	Сурагчадад гэрээсээ сургууль хүрэх замд тааралдсан зүйлсийг ажиглуулж, тэдгээртэй хэрхэн харьцах талаарх энгийн ойлголтыг өгнө.	<ul style="list-style-type: none"> <li>Гэр сургуулийн хооронд юу байдгийг ажиглаж мэдэх</li> <li>Тааралдсан зүйлээ нэрлэх</li> <li>Амьтан, ургамлыг хайллах, тасалж, гэмтээхгүй байх</li> <li>Тэдгээртэй зөв харьцах энгийн арга барилаас мэдэх</li> </ul>	Биет үзүүлэн, макет, багшийн бэлдсэн асуултууд	Ажиглах, жишин харьцуулах, сэдэлжүүлэх, ярилцах, бүтээх зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ.

№	Хичээлийн сэдэв	Цаг	Зорилго	Зорилт	Хэрэглэгдэхүүн	Арга зүй
3	<b>Соёл Уйлчилгээний газартай танилцья</b>	2	Өөрийн орон нутгийн соёл Уйлчилгээний газруудыг танилуулж хэрхэн биеэ зөв авч явах, яаж Уйлчлүүлэх талаар ойлгуулна.	<ul style="list-style-type: none"> <li>Өөрийн орон нутгийн соёл Уйлчилгээний газруудыг мэдэх</li> <li>Соёл Уйлчилгээний газраар зөв үйлчлүүлж сурах</li> <li>Яагаад соёл Уйлчилгээний газар гэж нэрлэсний учрыг мэдэх</li> </ul>	-Баримлын шавар, өнгийн харандаа, өнгийн цаас, хайч, цавуу, шулэгтэй кассет	Ажиглах, ярилцах, тоглох, бүтээх, соносох, дүгнэлт гаргах зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ.
4	<b>Дүгнэлт хичээл</b>	1	«Миний гэр сургуулийн орчин» булэг сэдвээр үзэж мэдсэн зүйлийг сэргээн сануулах, нэгтгэн дүгнэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Хүрээлэн буй орчин тойронд байгаа өөрсдийн ажиглаж мэдсэн зүйлийн талаар нэгдмэл ойлголттой болох</li> <li>Өөрсдийн эргэн тойронд байгаа юмс үзэгдлийг ажиглах, нэрлэх, өөрийн угээр тайлбарлах</li> <li>Эрүүл, аюулгүй орчинд амьдрахын ач холбогдлыг мэдэх, өөрийн угээр тайлбарлах</li> <li>Өөрсдийн сурч мэдсэн зүйлээ бусадтайгаа хуваалцах, харилцан санал бодлоо солилцох, өөрсдийн уран бүтээлийг бусдад таниулах</li> </ul>	Үзэсгэлэнгийн арга, харилцан ярилцах, тайлбарлан ярих, нэгтгэн дүгнэх зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ.	

**«Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийн  
сэдэвчилсэн төлөвлөгөө**

Бүлэг сэдвийн нэр	Хичээл №	Сэдэв	Цаг	Хугацаа	Тайлбар
<b>Миний гэр, сургуулийн орчин</b>	1	<b>Миний эргэн тойронд юу байдаг вэ?</b>	2	70`	<b>Экскурс, Ангид</b>
	2	<b>Гэрээс сургууль хүрэх замд</b>	1	35`	<b>Ангид</b>
	3	<b>Соёл үйлчилгээний газартай танилцъя</b>	2	70`	<b>Экскурс, Ангид</b>
	4	<b>Дүгнэлт хичээл</b>	1	35`	<b>Ангид эцэг, эхийн хамт</b>
<b>БҮГД</b>			<b>6</b>	<b>210`</b>	

## 2.2. «Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийн нэгж хичээлийн киррикюлим (6 цаг)

### Хичээл 1. Миний эргэн тойронд юу байдаг вэ? (2 цаг)

**Зорилго:** Суралцагчдад өөрийнх нь эргэн тойронд байдаг зүйлсийг таниулах, нэрлүүлэх, ажигласнаа тэмдэглэж сурх болон эрүүл аж төрөх, аюулгүй амьдрах энгийн ойлголтыг өгнө.

#### Хичээлийн зорилт:

- Хүрээлэн буй орчноо таньж мэдэх,
- Ажиглаж мэдсэн зүйлээ өөрийн үгээр илэрхийлэх
- Эрүүл аюулгүй амьдрах аргад суралцах
- Хамтран ярилцах, тоглох, зурж бүтээх

#### Агуулга:

##### Судлагдахуун

- Хүрээлэн буй орчин, тоглоомын талбай
- Сургуулийн эргэн тойронд байгаа амьд, амьгүй зүйлс

##### Ур ухаан

- Өөрсдийн эргэн тойронд байгаа зүйлсийг ажиглах,
- Ажигласан зүйлсээ нэрлэх, тоочих
- Хувийн ариун цэврийг сахих, гараа угаах, хувцсаа тохируулж өмсөх
- Бусадтай ярилцах

#### Арга зүй:

Хичээлийг экскурс хэлбэрээр зохион байгуулна. Сургуулийн тоглоомын талбай болон орчин тойронд байгаа зүйлсийг ажиглуулна. Аливаа зүйлийг ажиглан танин мэдэх үйлийн аргад сургах, асуудал шийдвэрлүүлэх, ажиглалт, харьцуулалт хийлгүүлэх, тоглуулах, бүтээлгэх зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ.

#### Хичээлийн хэрэглэгдэхүүн:


- Бөмбөг
- Улаан ба цэнхэр дарцаг (багийн тоогоор)
- Сургуулийн эргэн тойронд хүүхдүүдийн ажиглаж болох бүх зүйлийг зургаар бэлдэж ирнэ (сурагчдын өмнөх хичээл дээр хийсэн бүтээлээс ашиглаж болно)

- Модны навчис, боргоцой, чулуу, мод, элс, мөчир гэх мэт.
- Хайч, цавуу, картон цаас, баримлын шавар (баг бүрт хоёр ширхэг)
- «Бөмбөг» дуутай кассет, хөгжим (бэлтгэл хөтөлбөрт үзсэн дуу шүлгээс ашиглаж болно)

### Хичээлийн явц:

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг
1-р цаг			
Бэлтгэл үе	<p>Сурагчдад хичээлийнхээ зорилгыг танилцуулж, гадагш авч гараад бэлтгүүлнэ.</p> <p>Дараа нь багш сурагчдыг хоёр хоёроор нь гараас нь хөтлүүлэн жагсааж сургуулийн тоглоомын талбайд очно.</p>	<p>Сурагчид хувцасаа өмсөн хоёр, хоёроор хөтлөн сургуулиас гарна.</p>	<p>Багш сурагчдын малгай, ороолт бээлийг нь өмсгөж дулаан хувцаслуулна (цаг агаарын байдалд тохируулна).</p>
Сэдэлжүүлэх үе шат 15'	<p>-Сурагчдыг баруун, зүүн, хойд, урд гэсэн 4 багт хувааж баг тус бүрийг өөрсдийн зүг рүүгээ харж зогсохыг хэлнэ. Дөрвөн зүг рүү харуулан зогсоно.</p> <p>- За одоо, та нарын харж байгаа зүтг юу юу байгааг сайн хараарай. Юу юу харагдаж байна вэ?</p> <p>Харсан зүйлээ багаараа хоорондоо ярилцаарай.</p> <p>- Сурагчдыг харж, ажиглаж, ярилцаж дууссаны дараа бүх сурагчдыг тойрог болгон зогсоогоод:</p> <p>- За одоо бүгдээрээ саяын олж харсан, ажигласан зүйлүүдээ нэрлэцгээе гээд сурагчдаар нэрлүүлнэ.</p>	<p>- Хүүхдүүд гарч ирэн 4 баг болон, 4 зүг рүү харж зогсоно.</p> <p>Өөрсдийн харж байгаа зүтг юу юу байгааг сайтар ажиглана.</p> <p>Сурагчид юу юу байгааг сайн ажиглана, ярилцана. Үүнд: Хашаа (модон, төмрөн), мод, байшин, сургууль, хүн, шувуу, нохой, муур, зурагтын антенн, шонгийн мод, цонх, цонхны хөшиг, цонхон дээрх цэцэг, машин гэх мэт.</p>	<p>Сургуулийн тоглоомын талбайд байгаа тоглоомуудыг зөв нэрлэх, тайван нухацтай ажиглахыг сануулна.</p>

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг
Сэдэлжүүлэх үе шат 15'	<p>Дараа нь сурагчдаар «Нэрлээрэй» гэдэг тоглоом тоглуулна.</p> <p><i>Тоглоомын дүрэм: Багш эхэлж эргэн тойронд байгаа ямар нэг зүйлийн нэрийг хэлээд нэг сурагч руу бөмбөг шидэхэд тэр хүүхэд багшийн хэлснээс өөр нэг юмны нэрийг хэлнэ. Тэгээд цааш өөр хүүхэд дамжуулна. Тэр хүүхэд багш болон эхний хүүхдийн нэрлээгүй зүйлийг хэлнэ. Энэ маягаар тоглоомыг үргэлжлүүлнэ.</i></p> <p>Тойрог дотор багш орж голд нь зогсоод барьсан бөмбөгөө хэн нэгэн сурагч руу шидэж «Нэрлээрэй» гэнэ. Сурагчид нэрлэнэ. Багш амаар үнэлнэ. Сурагчид нэрлээд дууссаны дараа сурагчдын хамт ангидаа орж ирнэ.</p> <p><i>Цаг агаар дулаахан бол хичээлийн дараагийн үе шатыг гадаа талбай дээрээ үргэлжлүүлэн явуулж болно.</i></p>	<p>Сурагч багшийн өгсөн бөмбөгийг авч чулуу, мод, навч, боргоцой, савлуур, дээс, модон морь, дамжуурга, дүүжин даажин, хашаа байшин, сургууль, машин, хайс гэх мэтээр өөрийн харснаа хэлж тоглоно.</p>	<p>Сурагчдыг аль болох давхцуулахгүйгээр нэрлүүлэхэд анхаарна (аман үнэлгээгээр зөв хэлэх бүрт - Зөв, маш сайн, зүйтэй, болж байна, яг зөв гэх мэтээр үнэлж хүүхдийг урамшуулна.</p> <p>Сурагчид бөмбөг дамжуулахдаа нөгөө сурагчийнхаа нэрийг нь дуудаж гарт нь баригдахаар зөөлөн шидэж өгөхийг анхааруулна.</p> <p>Цагийн багтаамжаас хамаарч хэдэн хүүхдээр нэрлүүлэхээ багш зохицуулаарай.</p>

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг
Хөгжих үе шат 8'	<p>-Бидний эргэн тойронд юу юу байдгийг бүгдээрээ хамтдаа ярилцаж мэдэж авцаалаа.</p> <p>Одоо багш нь та нарт нэг нэг зураг тарааж өгнө. Энэ зурган дээр байгаа юмыг дуурайж дуугарна, эсвэл юугаар хооллодог болох, эсвэл зураг дээр байгаа зүйлсийг биеэрээ дүрсэлж үзүүлнэ гэж хэлнэ.</p> <p>Жишээ нь, байшин байвал гараа толгой дээрээ гурвалжилж дээврийг дүрслэх, шувуу бол хоёр гараараа шувуу мэт дэвэх, эсвэл жиргэж дуугарах, нохой бол хов хов дуугарах, үхэр – мөөрөх, өвс иддэг гэх мэт хялбар үзүүлж, тухайн зүйлийн талаар өөрсдийн юу мэддэгээ чөлөөтэй хэлж, ярихыг сануулна.</p> <p>Багш урьдчилан бэлтгэсэн зургуудыг сурагчдад нэг нэгээр нь тарааж өгнө. Хэрвээ зураг хүрэлцээгүй, хүүхдийн тоо олон байвал 2 юмуу 3 хүүхдийн дунд нэг зураг өгч болно.</p>	<p>Сурагчид зургийг харж биеэр дүрслэх, эсвэл дуурайж дуугарах гэх мэтээр ажиллана.</p>	<p>Зургийг хатуу, гэрэлтдэггүй цаасан дээр зурж бэлтгээрэй.</p>     

<b>Хичээлийн үе шат</b>	<b>Багшийн үйл ажиллагаа</b>	<b>Сурагчийн үйл ажиллагаа</b>	<b>Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг</b>
Алжаал тайлах үе 5'-7'	<p>«Хурдан баг» тоглоомыг тоглуулна. Тоглогчид 2-4 тэнцүү баг болон цуваагаар зогсоно.</p> <p>Өмнөх дөрвөн багаараа явуулж болно. Цувааны өмнө 2м зйтай гарааны зураас зурна. 10-20м зайд сургуулийн талбай дахь савлуур, эсвэл дүүжин ч юмуу байхаар гарааны зураасаа зурна.</p> <p>Цувааны эхний хүүхэд гараан дээр ирж зогсоно.</p> <p>Багшийн -Бэлдээрэй, анхаараарай, гүйгээрэй гэж хэлэхэд сурагчид гүйж дүүжин (савлуур, дарцаг г.м.) -г тойрон гүйж баг дээрээ ирнэ.</p> <p>Багтаа түрүүлж ирсэн нь оноо авна.</p>	<p>Сурагчид тоглоомыг тоглоход тэнцүү тоогоор 4 баг болон хуваагдаж багшийн зааврын дагуу «Бэлдээрэй, анхаар, гүйгээрэй» гэсэн командаар зэрэг гараанаас гарч дүүжин (савлуур, дарцаг) -г тойрон багтаа ирнэ.</p> <p>Хоцорвол оноо авахгүй. Их оноотой баг нь түрүүлнэ.</p>	<p>-Командыг сайн сонсох.</p> <ul style="list-style-type: none"> <li>- дүүжин (савлуур, дарцаг)-г заавал тойрч гүйхийг анхааруулна.</li> </ul>
Бататгах үе шат 5'	<p>-Одоо бүгдээрээ тойрог болон зогсоорой.</p> <p>Сургуулийн эргэн тойронд юу юу байсан бэ? Сурагчдын ажигласан зүйлсийг нэг нэгээр нь асууж харилцан ярилцана.</p>	<p>Сурагчид үзэж харсан зүйлээ ярина, нэрлэнэ.</p>	<p>Цагийн багтаамжаас хамаарч багш хэдэн сурагчаас асууж ярилцаахаа тухайн үед шийдвэрлэнэ.</p>
<b>Завсарлага 5-10`</b>	<b>Сургуулийн хонх</b>		

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг
<b>2-р цаг. Дадлага хичээл</b>			
Сэргээн сануулах үе шат 3'	<p>Сурагчдыг ангид суулгаж сургуулийн гадаа талбайд юу юу үзсэнийг сэргээн сануулж, асууж ярилцана.</p> <p>Ямар ямар тоглоомоор тоглодог вэ?</p> <p>Тэр тоглоомыг юугаар хийдэг гэж та нар бодож байна?</p> <p>Зүйтэй, та нар өөрсдөө ямар нэгэн тоглоом хийж үзсэн үү?</p>	<p>Сурагчид өмнөх цагийн хичээл дээр гадаа үзсэн зүйлсээ хэлнэ.</p> <p><b>Бодит жишээ:</b> Нарыг харсан, нар дугуй дүрснээс тогтоно, цонхон дээр цэцэг байсныг харсан г.м.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэлдэй, бамбарууш, машин, онгоц, шагай гэх мэт янз бүрийн олон тоглоомуудыг нэрлэнэ.</li> </ul> <p>Резин, даавуу, мод, төмөр г.м.-р хариулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үзсэн, эсвэл үзээгүй гэж хариулах байх</li> </ul>	<p>Сурагчдыг ангид оруулсны дараа эхлээд гарыг сайтар угаалгаарай.</p>
Бүтээх үе шат 15'	Тэгвэл одоо бүгдээрээ энэ хичээл дээр тоглоом бүтээж үзэцгээнэ. Байгаль дээр байдаг олон янзын зүйлсийг ашиглан зөндөө олон тоглоом хийж болдог. Бүгдээрээ одоо манай сургуулийн хашаанд байсан унасан навч, модны мөчир, боргоцой зэргийг ашиглан ямар нэгэн дуртай тоглоомоо бүтээцгээнэ гэж хэлнэ.		Өмнөх экскурс хичээлээр сурагчид модны унасан мөчир, навч, боргоцой, чулуу зэргийг түүж авсан байна. Хэрвээ сургуулийн талбайд навч, боргоцой, чулуу хангалттай хэмжээгээр байхгүй бол багш өөрийн урьдчилж бэлтгэсэн зүйлээ ашиглаарай.

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг
Бүтээх үе шат 15'	<p>Сурагчдыг гадаа ажиглалт хийсэн 4 багаар нь суулгана. (багуудад боргоцой, мод, чулуу, картон, баримлын шавар, хайч, цавуу зэргийг тарааж өгнө.</p> <p>Багийн гишүүд дундаа нэг тоглоом, эсвэл хэд хэдэн тоглоом хийж болно.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн талбайд эсвэл цэцэрлэгт сурагчид юу юу хийж байсныг судалж мэдэх,</li> <li>• Ширээн дээрх хэрэглэгдэхүүнүүд бүрэн хэрэглэгдэж байгаа эсэхийг анзаарах, хэрэв үгүй бол яагаад хэрэглэгдээгүй вэ гэдэгт анхаарч сануулах,</li> <li>• Юу бодож үүнийг хийсэн бэ? Яагаад үүнийг хийсэн бэ? гэж асууна, тайлбарлуулан ухааруулна.</li> </ul>	<p>Сурагчид багаар хамтарч төрөл бүрийн тоглоомыг бүтээнэ.</p> <p>Багууд зурж, баримлын шавраар бүтээж хийнэ. Зарим нь ярилцана.</p> <p>Харсан үзсэнээ дуурailгах, өөрчлөн бүтээх үйл хийнэ.</p>	<p>Багш энэ үе шатанд ажиглана, туслана, зөвлөнө, дэмжинэ. Багаар эсвэл хосоор нь ч ажиллуулж болно. Аман үнэлгээгээр урамшуулна.</p>
Алжаал тайлах үе 5'	<p>Хийж байгаа зүйлийг түр орхиулж хөгжим сонсгон дасгал хийлгэнэ.</p> <p>Жишээ нь:</p> <p>Бөмбөг бөмбөг хөөрхөндөө</p> <p>Бөмбөгөөр тоглох гоёхондоо</p> <p>Бөөр алаг бөмбөгөөр</p> <p>Харилцан тоглоё хоёулаа гэсэн дууг тавьж болно.</p>	<p>Сурагчид дуулаад дасгалыг зэрэг хийнэ.</p>	<p>Бэлтгэл хөтөлбөрт эсвэл цэцэрлэгт сурсан дуу, бүжгийг хийлгэж болно.</p>

<b>Хичээлийн үе шат</b>	<b>Багшийн үйл ажиллагаа</b>	<b>Сурагчийн үйл ажиллагаа</b>	<b>Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг</b>
Дадлага ажил 7'	Багууд хийсэн бүтээлээ бусдадаа танилцуулахад бэлтгэж байрлуулахыг сануулна.	Багууд бүтээлээ янзлан цэгцэлж бусад багт танилцуулахад бэлтгэнэ. Танилцуулна.	Хавсралтаас сурагчдын хийсэн бүтээлүүдийг үзэж танилцаарай.
Бататгах үе шат 4'	<p>-Өнөөдрийн хичээлээр юу юу мэдэж авсан бэ?</p> <p>-Яагаад модны навч боргоцой унасан байсан бэ?</p> <p>Өвс цэцэг хаачсан бэ?</p> <p>Хавар дахиад энэ хатсан өвс, цэцэг, ургамал ургах болов уу? Та нар юу гэж бодож байна? За бүгдээрээ хавар дахиад энэ хичээлээрээ ажиглах болно гэж хэлээд хичээлийг дуусгана.</p>	<p>-Өөрийнхөө эргэн тойронд юу юу байдгийг мэдэж авсан. Тэдгээрийн хооллодог хоол тэжээл, хөдөлгөөн, дуу авиааг мэдэж авсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Намрын улиралд унадаг.</li> <li>- Хатаад үхсэн</li> <li>- Шарлаж хатсан</li> <li>- Үхээгүй, харин хатсан байгаа гэх мэт хариулна.</li> </ul> <p>Намар, өвөл болоод хатчихсан гэх мэтээр хариулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ургана</li> <li>- Ургахгүй гэх мэт хариулна.</li> </ul> <p>Өөрсдийнхөөрөө тайлбарлана.</p>	Стандарт бус үнэлгээгээр үнэлнэ.
Гэрийн даалгавар 1'	Сурагчдыг хичээлдээ ирэх замдаа тааралдсан зүйлсээ ажиглаж, харсан зүйлсээ тэмдэглэж ирэх даалгавар өгнө. Энэ даалгаврыг сурагчдын эцэг эхэд давхар хэлж өгнө.		

## Хичээл 2. Гэрээс сургууль хүрэх замд (1цаг)

### Зорилго:

Сурагчдад гэрээсээ сургууль хүрэх замд тааралдсан зүйлсийг ажиглуулж, тэдгээртэй хэрхэн харьцах талаарх энгийн ойлголтыг өгнө.

### Зорилт:

- Гэр сургуулийн хооронд юу байдгийг ажиглаж мэдэх
- Тааралдсан зүйлээ нэрлэх
- Амьтан, ургамлыг хайрлах, тасалж, гэмтээхгүй байх
- Тэдгээртэй зөв харьцах энгийн арга барилаас мэдэх

### Агуулга:

#### Судлагдахуун

- Гэрээс сургууль хүрэх замд тааралддаг зүйлс

#### Ур ухаан

- Гэрээс сургууль хүрэх замд байгаа зүйлсийг ажиглах,
- Ажигласан зүйлсээ нэрлэх, тоочих
- Харсан зүйлээ бүтээх, наах, зурах
- Хувийн ариун цэврийг сахих, гарсаа угаах, хувцсаа тохируулж өмсөх
- Бусадтай ярилцах

### Арга зүй:

Ажиглах, жишин харьцуулах, сэдэлжүүлэх, ярилцах, бүтээх зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ. Хичээлийг багаар юмуу ангиар нь ажиллуулахаар зохион байгуулна.

### Хичээлийн хэрэглэгдэхүүн:

- Биет үзүүлэн, макет,
- Асуултууд
- Зурагт үзүүлэн

**Хичээлийн явц:**

<b>Хичээлийн үе шат</b>	<b>Багшийн үйл ажиллагаа</b>	<b>Сурагчийн үйл ажиллагаа</b>	<b>Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг</b>
Өмнөх хичээлийг давтах 5'	- Бидний эргэн тойронд ямар ямар зүйлс байдаг вэ?	Мод, байшин, уул, ус, шувуу, нохой, морь г.м. сурагчид ажиглаж харсан зүйлсээ хэлнэ.	Өмнө үзсэн сэдвийг сэргээн сануулна.
Сэдэлжүүлэх үе шат 3'	Манай сургуулийг тойроод зөндөө олон зүйлс байдаг юм байна. Тэгвэл та нарын гэрээс сургууль хүртэлх замд юу юу байсан бэ? Хэн хэлэх вэ? Бүгдээрээ гэрээс сургуульд хүрэх замд юу юу тааралдсанаа ярилцья.	Мод, нохой, зам, гэрлэн дохио, замын тэмдэгүүд, цагаан шугам, байшин, гудамж, дэлгүүр, ТҮЦ, хашаа, хайс гэх мэтээр хариулна.	Сурагчдыг бүгдээрээ хариулж, хичээлд оролцуулахад анхаарна.
Бүтээх үе шат 7'	За тэгвэл одоо бүгдээрээ гэрээс сургууль хүрэх замд тааралдсан зүйлсээ бүтээцгээе.  <b>Хувилбар 1.</b> Багш самбарын хоёр талд урьдчилан бэлтгэсэн гэр болон сургуулийн дүрсийг байрлуулна.	Сурагчид замдаа харсан ямар нэгэн зүйлийг дүрсэлнэ. Байгалийн материал болон баримлын шавраар бүтээнэ эсвэл зурна.  Урьдчилсан бэлтгэсэн зургууд- аас өөртөө тааралд- сныг сонгон авч сурагчид ээлжлэн гарч самбарт гэр, сургуулийн хоорондох зайд байрлуулна.	Энэ үе шатыг дараах хувилбаруудын аль нэгийг нь сонгож явуулах боломжтой.  Багш сурагчдын ирдэг чиглэлт бүрт тааралдах зүйлсийг урьдчилан харж тооцоолж зургийг бэлтгэсэн байна.
	<b>Хувилбар 2.</b> Багш ойр гэртэй сурагчдыг нэг баг болгон хуваана. Баг тус бүрт том цаас өгч гэрээсээ сургууль хүртэлх замд тааралдсан зүйлсийг хоорондоо ярилцаж зурж, бүтээх даалгавар өгнө.	Багийн гишүүд хоорондоо ярилцаж өөрсдийн харсан байшин барилга, машин, нохой, шувуу, муур, дэлгүүр, шуудан, банк, гэрлэн дохио, мал зэргийг хийж бүтээнэ.	Багш хичээлийн бэлтгэлд ашиглах хайч, цавуу, харандаа, шугам зэргийг зөв, аюулгүй хэрэглэхэд туслана.

<b>Хичээлийн үе шат</b>	<b>Багшийн үйл ажиллагаа</b>	<b>Сурагчийн үйл ажиллагаа</b>	<b>Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг</b>
Бүтээх үе шат 7'	<b>Хувилбар 3.</b> Багш зөвлөмжийн хавсралтанд өгөгдсөн зургийг сургач нэг бүрт тараан өгч ажиллуулна. Бэлэн болсон зургаа самбарт байрлуулж тайлбарлуулна.	Сурагч бүр өөрийн харснаа зурж тайлбарлан ярихад бэлдэнэ.  Сурагчид ээлжлэн хийсэн бүтээлээ самбарт нааж тайлбарлана.	Багш та цагийн багтаамжаас хамааран аль болох олон сурагчаар тайлбарлуулахыг хичээгээрэй.
Алжаал тайлах үе 5'	Бүгдээрээ 1 тоглоом тоглоцгооё -Салхинд найгаж байгаа мод болцгооё -Модны навч уналаа -Шувуу нислээ -Машин болж дуугарцааяа г.м.	Багшийн хэлсний дагуу хөдөлгөөн хийнэ.	Багш тухайн сэдэвт тохирсон алжаал тайлах дасгал хийлгэж болно.
Бататгал 9'	Гэрээс нь сургууль хүрэх замд юу юу таарсныг сурагчдын зурсан эсвэл бүтээсэн бүтээл дээр нь тайлбарлуулна.  Та нар сургуульдаа ирэхдээ машин замаар яаж гарсан бэ?, Яагаад гарцаар гарсан бэ?  Нохойтой газар, ухсан нүхтэй газар таарвал яах вэ?	Сурагчид өөрсдийн бүтээсэн зүйлсийг самбарт байрлуулна.  Нэг зүгээс ирдэг хүүхдүүд нь самбарт гарсан сурагчид тусалж болно.  Бид сургуульдаа ирэхдээ ногоон гэрлээр, цагаан шугамаар гардаг. Учир нь явган хүн гарцаар гардаг.  Нохой хуцаж дайрдаг, хаздаг. Ухсан нүхийг тойрч гардаг гэх мэт.	Багш бүтээх үе шатанд ямар хувилбар сонгосноос хамааран бататгалыг янз бүрийн хэлбэрээр хийж болно.  Сурагчдад аюулгүй байдлын талаар болон байгальтай зөв харьцах, хайрлан хамгаалахын ач холбогдлыг ойлгуулна.
Үнэлгээ 2'	Багш сайн байна, маш сайн байна гэсэн үгээр урамшуулна. Сурагчид ширээн дээр байгаа хувийн дугаартай цаасан дээрээ од наана.		

<b>Хичээлийн үе шат</b>	<b>Багшийн үйл ажиллагаа</b>	<b>Сурагчийн үйл ажиллагаа</b>	<b>Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг</b>
Дүгнэлт 4`	<p>Гэрээсээ сургуульдаа ирэхдээ юуг анхаарах вэ?</p> <p>Гэрийнхэн чинь та нарт өөр юу гэж захисан бэ?</p>	<p>- Машин замаар болгоомжтой явж, ганцаараа явж болохгүй, гэрийнхэннийгээ хүлээх,</p> <p>- Нохойноос холуур явна, чулуу шидэн уурлуулж болохгүй,</p> <p>- Гудамжны өнцгөөс гэнэт машин гарч ирдэг, иймээс анхааралтай гарах</p> <p>- Ухсан нүхэн дээгүүр харайхгүй тойрч явах зэргийг анхаарах хэрэгтэй гэх мэт.</p> <p>- Биднийг иртэл хүлээж байгаарай, болгоомжтой яваарай гэх мэт.</p>	<p>- Сургуулийн хашаан дээгүүр давж болохгүй,</p> <p>- Мод хугалж болохгүй,</p> <p>- Гэрлийн шон руу чулуу шидэж болохгүй гэрэл хагарна г.м.</p>

### Хичээл 3. Соёл үйлчилгээний газартай танилцуяа (2 цаг)

#### Хичээлийн зорилго:

Өөрийн орон нутгийн соёл үйлчилгээний газруудыг танилцуулж хэрхэн биеэ зөв авч явах, яаж үйлчлүүлэх талаар ойлгуулна.

#### Хичээлийн зорилт:

- Өөрийн орон нутгийн соёл үйлчилгээний газруудыг мэдэх
- Соёл үйлчилгээний газраар зөв үйлчлүүлж сурх
- Яагаад соёл үйлчилгээний газар гэж нэрлэсний учрыг мэдэх

#### Агуулга:

##### Судлагдахуун

- Соёл үйлчилгээний газар

##### Үр ухаан

- Соёл үйлчилгээний газар гэж юу болохыг мэдэх,
- Яагаад соёл үйлчилгээний газар гэж нэрлэсний учрыг тайлбарлах
- Соёл үйлчилгээний газруудаар хэрхэн үйлчлүүлэх талаар хэлэх,
- Өөрсдийн үзэж, харсан зүйлийг байгалийн материал болон хичээлийн хэрэгслүүдийн тусламжтай бүтээх, зурах

#### Арга зүй:

Ажиглах, ярилцах, тоглох, бүтээх, сонсох, дүгнэлт гаргах зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ. Аяллын цагийг багш өөрийн болон орон нутгийн онцлогт тохируулан сонгоно. Ангийн сурагчдыг анги хамт олноор нь ба хэсэгчилсэн хэлбэрээр зохион байгуулж болно.

##### Аяллын төлөвлөгөө:

- Соёл үйлчилгээний газрын хүмүүстэй урьдчилж уулзаж тохирсон байх
- Эцэг эхтэй уулзаж ярилцах, тохирох
- Зорилгоо танилцуулах
- Аюулгүй байдлыг хангах

#### Хичээлийн хэрэглэгдэхүүн :

- Баримлын шавар, өнгийн харандаа, өнгийн цаас, хайч, цавуу,
- Шүлэгтэй кассет
- Орон нутгийн соёл үйлчилгээний газрын маршрут (Хаанаас эхлэхээ сайтар төлөвлөх)

**Хичээлийн явц:**

<b>Хичээлийн үе шат</b>	<b>Багшийн үйл ажиллагаа</b>	<b>Сурагчийн үйл ажиллагааны төсөөлөл</b>	<b>Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг</b>	
<b>Аяллын цаг 1-р цаг</b>			Багш, эцэг эхчүүдийн төлөөллийн хамт сурагчдыг авч, өмнө төлөвлөсөн маршрутын дагуу соёл үйлчилгээний газруудаар (номын сан, музей, үсчин, шуудан холбоо, эмнэлэг, спортын төв, сургалтын төв гэх мэт) аялна. Багш, эцэг эхийн төлөөлөгчид сурагчдын аюулгүй байдлыг хангана. Мөн сурагчдын үйл ажиллагааг удирдан чиглүүлж дэмжин туслана. Аяллаар явж ирсний дараа ангид орж ирээд сурагчдын гарыг сайтар угаалгаарай.	
<b>Ангийн цаг 2-р цаг</b>				
Сэдэлжүүлэх үе 3'	Ямар ямар соёл үйлчилгээний газруудаар аялсан бэ? Яагаад соёл үйлчилгээний газар гэж нэрлэсэн юм бол?	Кино театр, үсчин, сургууль, номын сан гэх мэт. Хүмүүсийн үсийг угааж, засаж, үйлчилдэг учраас... Хүнд үйлчлэхдээ соёлтой үйлчлэх ёстой учраас...гэх мэтээр хариулна.	Багш сурагчдаар өөрсдөөр нь хэлүүлэхийг анхаараарай.	
Хөгжүүлэх үе шат 15'	<p><b>Хувилбар 1.</b> Багш сурагчдыг очсон соёл үйлчилгээний газруудын тоогоор багт хувааж баг бүрт тухайн газраа үзсэн зүйлсээ баримлын шавар, өнгийн цаас, хайч, цавуу, байгалийн материал зэргийг ашиглан бүтээх даалгавар өгнө.</p> <p><b>Хувилбар 2.</b> Дүрийн тоглолтоор соёл үйлчилгээний газрын үйл ажиллагааг харуулна.</p>	<p>Сурагчид зурах юмуу эсвэл бүтээх, хайчлах, наах, эвлүүлэх гэх мэт дуртай хэлбэрээ сонгож бүтээнэ.</p> <p>Сурагчид баг болж оногдсон соёл үйлчилгээний газрынхаа онцлогийг харуулсан дүрийн тоглолтыг бэлтгэнэ.</p>	<p>Багш сурагчдад хайч, цавуу, харандаа, шугам зэргийг зөв, аюулгүй хэрэглэхэд туслана.</p> <p>Тухайн дүрийн тоглолтонд хэрэглэгдэх хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэсэн байна.</p>	

<b>Хичээлийн үе шат</b>	<b>Багшийн үйл ажиллагаа</b>	<b>Сурагчийн үйл ажиллагааны төсөөлөл</b>	<b>Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг</b>
Хөгжүүлэх үе шат 15`	<p>Ангийн сурагчдыг 4-5 багт хувааж тус бүрт нэг, нэг соёл үйлчилгээний газрыг оноож өгч тухайн газарт хэрэглэгддэг хэрэглэгдэхүүнүүдийг өгнө.</p> <p>Багш дүр тус бүрт зааварчилгаа өгч дүр бүтээх явцад зөвлөж тусална.</p>	Жишээ нь, эмнэлэгт эмч (цагаан халаад, малгай, чагнуур, эмийн сан гэх мэт), сувилагч, үйлчлүүлэгчийн дүр бүтээнэ.	Хавсралтаас бодит хичээлийн зургийг үзээрэй.
Алжаал тайлах тоглоом 5`	-Тойрог болж зогсоно. -Багш нь үйлчилгээний газруудыг нэрлэе. Тэгэхээр та нар тэр газарт орж ирсэн хүмүүст яаж үйлчлэх вэ? Түүнийг тоглож биеэрээ үзүүлнэ гэдгийг хэлнэ.	-Хүүхдүүд этюд хийж үзүүлнэ. Ингэж тоглож байхдаа багшаас асуух зүйлүүд байвал асууж, багш түүнд нь хариулна.	Багш, эцэг эхчүүд тоглоомонд оролцож тусална.
Бататгах үе 5`	«Манай нийслэл» шүлэг сонсгоно. Шаардлагатай бол багш өөрөө уран яруу дуугаар тод уншиж өгнө.	Сурагчид зарим зүйлээ орхигдуулсан бол түүнийг гүйцээж хийнэ.	Орон нутаг, хот дүүргийнхээ онцлогийг тусгасан өөр дуу шүлгийг ашиглаж болно.
Дүгнэлт 5`	-Өнөөдрийн хичээлд ядарсан уу? -Энэ хичээл ямар санагдав? -Юу юу мэдэж авсан бэ? - Яагаад соёл үйлчилгээний газар гэж нэрлэсэн бэ?	Сурагчид өөрийн үгээр хариулна.	-Сурагчдын хариултыг нээлттэй орхиё. Тэд жаахан ядарсан. Харин их зүйлийг мэдэж авсан даа.
Даалгавар 2`	Үзсэн харсан зүйлээ байгалийн материал болон зургаар эсвэл баримлын шавраар дүрсэлж ирээрэй. Дараагийн хичээлээр та нарын өмнөх хичээлүүд дээр хийсэн зүйлээр бүтээлийн үзэсгэлэн гаргах болно. Та нар ээж, аав, ах, эгч нар болон гэр бүлийнхээ хэн нэгийг авчраарай.		

## Хичээл 4. Дүгнэлт хичээл (1 цаг)

### **Зорилго**

«Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвээр үзэж мэдсэн зүйлийг сэргээн сануулах, нэгтгэн дүгнэнэ.

### **Зорилт:**

- Хүрээлэн буй орчин тойронд байгаа өөрсдийн ажиглаж мэдсэн зүйлийн талаар нэгдмэл ойлголттой болох
- Өөрсдийн эргэн тойронд байгаа юмс үзэгдлийг ажиглах, нэрлэх, өөрийн үгээр тайлбарлах
- Эрүүл, аюулгүй орчинд амьдралын ач холбогдлыг мэдэх, өөрийн үгээр тайлбарлах
- Өөрсдийн сурч мэдсэн зүйлээ бусадтайгаа хуваалцах, харилцан санал бодлоо солилцох, өөрсдийн уран бүтээлийг бусдад таниулах

### **Анги зохион байгуулалт:**

**Хичээл явуулах арга зүй:** Үзэсгэлэнгийн арга, харилцан ярилцах, тайлбарлан ярих, нэгтгэн дүгнэх зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ. Ангийг дараах байдлаар засаж бэлдсэн байна: Ангийн ширээ сандлыг тойруулан засна. Ангийн нэг хананд сурагчдын хийсэн бүтээлийг байрлуулсан байна.

### **Хичээлийн хэрэглэгдэхүүн:**

Сурагчдын хийсэн бүтээлүүд, дүрс бичлэг, хөгжим, кассет

### **Хичээлийн явц:**

Хичээлийн үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг
Сэдэлжүүлэх үе шат 3'	Та нарт өмнөх хичээлүүдээс хамгийн гоё сонирхолтой санагдсан зүйлс нь юу байсан бэ?	Сурагчид өөрсдийн үгээр бодсоноо чөлөөтэй хэлнэ. Жишээ нь, зурсан, наасан, жүжиг тоглосон, дуу дуулсан, шүлэг уншсан, музей үзсэн, аялалаар явсан хамтран бүтээсэн гэх мэт.	Багш дэмжинэ, сайшаана

<b>Хичээлийн үе шат</b>	<b>Багшийн үйл ажиллагаа</b>	<b>Сурагчийн үйл ажиллагаа</b>	<b>Багшийн анхаарах зүйл ба дэмжлэг</b>
Хичээлийн өрнөл 5'	Багш өнөөдрийн хичээлийг эцэг эхчүүдэд нээлттэй хийх болсноо мэдэгдэж хичээлийн зорилгоо танилцуулна. Эцэг эхчүүддээ өмнөх хичээлүүддээс сурсан дуу, шүлгээ уншиж үзүүлэхийг хүснэ.	Сурагчид шинээр сурсан дуу шүлгээ эцэг эхчүүддээ уншиж сонирхуулна. Ангиараа болон багаар хамтран хийнэ.	
Бататгал 9'	Энэ бүлэг сэдвээр үзсэн, сурч мэдсэн, бүтээсэн зүйлүүдийг сурагчдаар тайлбарлуулна. -Яагаад үүнийг хийсэн бэ? - Юу гэж бодож үүнийг хийсэн бэ? гэх мэт асуултыг тавьж яриулна.	Сурагчид өмнөх хичээлүүдээр хийсэн бүтээлүүдээ байрлуулж өөрийн үгээр тайлбарлана.	Багш сурагчдын хийсэн бүтээлүүдийг баг бүрт тарааж бэлтгэсэн байна.
Үнэлгээ 2'	«Миний гэр – сургуулийн орчин» бүлэг сэдвээр үзэж мэдсэн, сурсан зүйлсийг нь яриулж, тайлбарлуулан стандарт болон стандарт бус үнэлгээгээр үнэлнэ.		
Дүгнэлт 4'	Сурагчдын өмнөх төсөөлөл болон энэ бүлэг сэдвээр сурч мэдсэн зүйлүүдийг амьдрал ахуйдаа хэрхэн хэрэглэж болох талаар сурагчидтай санал бодлоо солилцож хичээлийг дүгнэнэ. Дараагийн бүлэг сэдэв хичээлд бэлтгэнэ.		Хичээлийн эцэст эцэг эхийн төлөөлөл санал сэтгэгдлээ илэрхийлнэ.

## 2.3. Сурагчдын бие дааж хийх ажил

Сурагчдын бие даан хийх үйл ажиллагааг дэмжих зорилгоор дараах дасгал ажлуудыг орууллаа. Энэ дасгалуудаас хичээлийн болон хичээлийн бус цагаар ажиллуулах боломжтой.


### Миний дуртай тоглоом

1. Дараах зургаас өөрсдийн дуртай тоглоомыг олоорой.



**2. Өөрсдийн тоглох дуртай тоглоомуудыг зурж будаарай.  
Хэн олон тоглоом зурж чадах вэ?**

Гэрт тоглодог тоглоом




Гадаа тоглодог тоглоом



3. Дараах зургийг ажиглаад дуурайж зураад будаарай.



4. Дагаад хийгээрэй.



Үүнийг яаж хийх вэ?

-----


**5. Навчаар амьтан бүтээцгээ. Зураг дээрээс сурагчдын хийсэн бүтээлийг харж дуурайн хийгээрэй.**







**6. Хэн хамгийн олон амьтан хийх вэ? Зураг дээрээс сурагчдын хийсэн бүтээлийг хараад өөр ямар ямар амьтан хийж болох талаар бодож өөрсдөө хийгээрэй.**



7. Дараах цэцгэнд юу дутуу байна вэ? гүйцээж зураад будаарай.



8. Хэн олон жимс тарих вэ? Модны зураг дээр өөрсдийн мэдэх төрөл бүрийн жимснүүдийг өнгийн цаас болон баримлын шавар ашиглан хийж байрлуулна. Хэний мод олон жимстэй байна вэ?




### 9. Хэн олон загас барих вэ?

Бүгдээрээ өнгийн цаасаар янз бүрийн загас 3-5 ш хийнэ. Загасаа бичгийн тэмэр хавчаараар хавчиж газарт бүгдийг нийлүүлэн асгана. Сурагч бүрт жижиг соронзон тарааж өгч зурагт үзүүлсний дагуу бэлдэнэ.




## 10. Бүгдээрээ тоглоом бүтээцгээе.


Дараах зургаас навч, боргоцой, чулуугаар хийж болох зарим тоглоомуудыг хараад өөрсдөө хийж бүтээгээрэй.





**11. Удахгүй өвлийн улирал эхэлнэ. Бүгдээрээ дараах зургийг харж түүнээс өөр олон төрлийн цасан ширхэг хийгээрэй.  
Хэний цасан ширхэг хамгийн гоё болсон бэ?**



**12. Хэн олон шүр хэлхэж чадах вэ? Утсанд шүр нэмж зураад өнгийн будгаар будаарай.**




**13. Тагтаа шувуу хооллоцгооё. Хэн олон будаа зурах вэ?**




**14. Танай гэрээс сургууль хүрэх замд юу юу тааралддаг вэ?**  
Багаараа юмуу хосоороо ярилцаж зураарай.



16. Амьтад хаана амьдардаг вэ? Амьдрах орчныг олж өгч туслаарай.



**17. Дараах амьтдын амьдардаг газрыг  
олж өгч туслаарай.**



•




•



•



•



•




•

**18. Эдгээр амьтад ямар амьтны үр төл вэ?  
Эхийг нь нэрлээд өөрсдөө зурж буударай**




19. Дараах амьтдыг гүйцээж зураад будаарай.





**20. Хэн олон амьтны үр төл мэдэх вэ?**  
Түүнийгээ зурж үзүүлье.



**21. Гэрээсээ сургууль хүртэлх замд тохиолддог зүйлээ зурж ангийнхантайгаа ярилцаарай.**




**22. Зам хөндлөн гарахдаа анхаарал болгоомжтой яваарай!  
Аль нь зөв бэ? Яагаад? Хамтдаа ярилцаж тайлбарлаарай.**



### 23. Соёл үйлчилгээний газартай танилцъя

Зураг дээр ямар ямар үйлчилгээний газрууд байна вэ? Нэрлээрэй.



**24. Өөрт таалагдсан соёл үйлчилгээний газруудыг зурж,  
өнгөөр ялгаж будаарай.**



**25. Соёл үйлчилгээний газруудаар хэрхэн үйлчлүүлэх ёстой вэ?  
Өөрийн бодлоор зурж тайлбарлаарай.**

---

---





---

---

---

---

**26. Өгөгдсөн дүрсийг ашиглан байшин зураарай.**  
**Хажууд нь өөрийн дуртай зүйлсээ нэмж зураарай.**





## 27. Хэн олон дүрс бүтээх вэ?


Сурагчид ангийн гэрэлтэй хэсэгт очин ханан дээр гараараа янз бүрийн дүрс бүтээнэ. Хэн хэн ямар дүрс бүтээснээ хэлж түүнийг зургаар илэрхийлэн бусдадаа тайлбарлан хэлнэ.



**28. Дараах зүйлийг харж өнгийн цаас, цавуу, хайч, баримлын шавар, мод, боргоцой зэрэг гарын доорх материал ашиглан дуурайж хийгээрэй. Юуг яаж хийж болох вэ?**



29. Дараах зурийг өнгөөр ялгаж будаарай.





30. Дараах зургийн хэсэг тус бүрээс тохирох зүйлсийг харгалзуулан зураасаар холбож зураарай. Яагаад хоорондоо холбоотой вэ?  
Учрыг нь өөрийн үгээр тайлбарлаарай.



•



•



•



•



•



•




•



•



•



•




•



•

31. Хүнсний дэлгүүрт байдаг зүйлсийг олж өнгөөр ялгаж буударай



### III БҮЛЭГ. АРГА ЗҮЙН ТУРШИЛТ БОЛОН ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА (ЖЮГЁ КЭНКЮ-JYUGYO KENKYU)

#### 3.1. Туршилт хичээлийн явц, үр дүн

«Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил» төслийн хүрээнд «Миний гэр, сургуулийн орчин» бүлэг сэдвийг заах арга зүйн туршилт хичээлийг 2008 оны 11 сард Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дорнод аймгийн загвар 9 сургуулиудад амжилттай явуулсан.

Туршилтад хамрагдсан багш нар

№	Туршигч багш нар	Загвар сургууль
1	О.Наангэрэл	Улаанбаатар хот “Сэтгэмж” цогцолбор сургууль
2	Л.Янжинлхам	Улаанбаатар хот 45-р сургууль
3	Ц.Дуламрагчаа	Улаанбаатар хот 97-р сургууль
4	Н.Энхбаатар	Дорнод аймаг “Хан-Уул” цогцолбор сургууль
5	А.Мядагмаа	Дорнод аймаг 5-р сургууль
6	Д.Наанцэцэг	Дорнод аймаг Матад сумын сургууль
7	М.Эрдэнэбилэг	Сэлэнгэ аймаг 1-р сургууль
8	О.Буянжаргал	Сэлэнгэ аймаг 4-р сургууль
9	П.Нармандах	Сэлэнгэ аймаг Хушаат сумын сургууль

Туршилт хичээл дараах үндсэн дарааллаар явагдсан.

1. Туршилтын өмнөх сургалт
2. Туршилт хичээл
3. Туршилтын дараах хэлэлцүүлэг

1. Туршилт хичээлийн өмнө загвар 9 сургуулийн туршигч багш нар зөвлөмжийн эхний хувилбартай танилцаж, нийтийн сургалт семинаруудад хамрагдсан. Энэ явцад ажлын хэсгийнхэн болон япон зөвлөх багш нарын зүгээс санал, зөвлөгөө болон хичээлийг заах арга зүйн талаар нэмэлт тайлбаруудыг өгч байсан. Мөн хичээлд хэрэглэгдэх хэрэглэгдэхүүнийг хамтран хийх, зарим шаардлагатай зүйлсийг (цаас, цавуу, хайч, үзэг гэх мэт) өгсөн.

2. Туршилт хичээл дараах үе шаттай явсан. Үүнд:

- Бүлэг сэдвийн болон нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах – Ажлын хэсгийнхэн хариуцсан
- Туршилт хичээл явуулах, ажиглалт хийх – Туршигч багш, ажиглагч багш, ажлын хэсэг, япон зөвлөх багш, захирал менежерүүд оролцсон.
- Хичээлийн дараах хэлэлцүүлэг (жюгё кэнкю) – Хичээлд сууж ажиглалт хийсэн бүх багш нар оролцсон.

3. Хичээлийн дараах хэлэлцүүлгийг хичээлд сууж ажиглалт хийсэн бүх багш нар хамтран тухайн хичээлийн явц, үр дүн, ололттой ба дутагдалтай тал болон цаашид анхаарах зүйлийн талаар дэлгэрэнгүй ярилцаж тэмдэглэл хөтлөн дараагийн хичээлээ сайжруулах үйл ажиллагааны дарааллыг боловсруулсан.

Бидний энэ удаагийн зөвлөмж нь зургаан настай 1-р ангийн сурагчдад хүрээлэн буй орчинг хэрхэн энгийн, хялбар аргаар, ойлгомжтой, хүртээмжтэй заах арга зүйн нэгэн хувилбарыг боловсруулах зорилготой байсан. Туршилтын явцад нэлээдгүй саад бэрхшээл (багш, сурагчийн зүгээс) тулгарч байсныг дурьдах нь зүйтэй болов уу. Учир нь бидний туршилт хичээлд хамрагдсан сурагчид маань дөнгөж цэцэрлэгээс сургуульд анх орж ирсэн бөгөөд - Би, - Миний юм гэсэн үзэл давамгайлсан, аливаа зүйлийг ганцаараа хийх хүсэл тэмүүлэлтэй байdag тэдний насны онцлогтой холбоотой. Тухайлбал, эхний хичээл дээр нэгэн сургуулийн хоёр хүүхэд даалгавраа хамтарч гүйцэтгэх ёстой байтал нэг хүүхэд нь заавал ганцаараа хийнэ гээд уйлж байсан тохиолдол ч гарч байлаа. Сүүлдээ энэ байдал үгүй болж хүүхдүүд хамтаараа нэгэн зүйлийг ярилцаж хамтран хийж гүйцэтгэж байсан ба тэдний аливаа зүйлийг үзэх үзэл, хамтран ажиллах хүсэл эрмэлзэл, чадвар нэмэгдэж байсан нь ажиглагдсан.

Мөн бидний туршилт хичээл арай хожуу 11 сард эхэлсэн тул (ЕБ-ын 12 жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу энэ бүлэг сэдэв 10 сард орох ёстой байсан) гадаа ажиглалт, экспурс хийхээр төлөвлөсөн байсан нь хичээл явагдахад хүндрэлтэй байсан. Гэхдээ бид энэ үйл ажиллагаагаа ангид оруулж үргэлжлүүлэн хичээлийг тасралтгүй амжилттай явуулж чадсан.

Хичээл зааж байгаа багшийн хувьд мөн хэд хэдэн бэрхшээлүүд тохиолдож байсан. Зургаан настай бяцхан сурагчдад тохируулан харилцах, асуултаяа энгийн, ойлгомжтой, оновчтой тавих гэх мэт. Тухайн насны хүүхдэд тохирсон асуултыг хэр оновчтой тавьж, хичээлийг сэдэлжүүлэхээс тэр хичээлийн явц, үр дүн шууд хамаардаг. Зөвлөмж боловсруулсан ажлын хэсгийнхэний хувьд ч үг сонгох, асуух асуулт, хариулт зэргийг урьдчилан таамаглаж бичихэд амаргүй байсан. Хэдийгээр дээрх хүндрэл, бэрхшээлүүд байсан ч бид туршилт хичээлээ амжилттай явуулж дуусгаад түүнээс гарсан санал дүгнэлтүүдийг тусган энэхүү зөвлөмжөө боловсрууллаа.

Туршилт хичээлийн бодит үр дүнг дараах байдлаар оруулж байна. Хавсралтаас сурагчдын хийсэн бүтээлүүдийг үзэж танилцаарай.

## Багшид гарсан өөрчлөлт

- Зургаан настай сурагчдын нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг судалж түүнд тохируулан үг яриа, биеийн байрлал, хөдөлгөөн, дохио зангаа, үйл хөдлөл зэрэгт анхаарч ажиллана
- Хичээлийн төлөвлөлт, бэлтгэл үйл ажиллагааг сайтар хангаж хичээлээ явуулахын ач холбогдлыг ойлгож, үүнийгээ өөрийн ажлын гол хэсэг гэдэгтэй санал нийлж биелүүлэх хандлагатай болсон. Хичээлийн төлөвлөлтдөө хүүхдийн хариулж болох боломжит хариултыг урьдчилан таамаглаж, хэрвээ багшийн хүссэн хариулт гарагчийг тохиолдолд хэрхэн түүнийг гаргуулах талаар тодорхой хэмжээний ойлголт, мэдлэг, ур чадвар, эв дүйтэй болсон
- Хичээлийн агуулгаа аль болох сурагчдын амьдралд ойр, тэдний бодит төсөөлөлд тулгуурлан явуулахын ач холбогдлыг ухаарсан
- Сурагчдыг сэдэлжүүлэхэд илүү анхаарч ажиллах болсон
- Сурагчдаар өөрсдөөр нь хэрхэн мэдлэг бүтээлгэх, түүний ач холбогдлыг ойлгож авсан
- Сургалтын аргуудыг хослуулан хэрэглэж арга зүйг туршиж, хичээлдээ бүтээлчээр хандах болсон
- Гарын доорх материал ашиглан хичээлээ явуулах болсон
- Хүүхдийн гаргах алдааг урьдчилан таамаглаж хичээлд бэлтгэх болсон
- Багш нар хамтран шинэ арга зүйн талаар ярилцдаг болсон зэрэг давуу талууд гарсан.

## Сурагчдад гарсан өөрчлөлт

- Багаар ажиллах чадвартай болж сурч мэдэхийн төлөө мэрийх болсон
- Сурагчид багшаасаа айж эмээлгүй, дотно харилцаж, чөлөөтэй санал бодлоо илэрхийлэх болсон
- Ажиглалт хийх анхан шатны мэдлэг, чадвартай болсон
- Аливаа зүйлийг сонирхон байгалийг танин мэдэх хүсэл нь зарим сурагчдад илүү өрнөсөн
- Хичээлд хандах хандлага өөрчлөгдсөн
- Суралцах идэвх сонирхол нь дээшилсэн
- Олж авсан мэдлэгтээ дүн шинжилгээ хийж мэдлэгээ хамтран бүтээхэд суралцаж эхэлсэн
- Өөрийн бодлоо өөрийн үгээр илэрхийлэх чадвар нь сайжирсан
- Дараагийн хичээлээ хүлээх, сурах эрмэлзэлтэй болсон
- Өөрийн болон бусдын сул талыг ажиглан мэдэрч бусаддаа нөлөөлөх болсон

Сурагчдад эдгээр өөрчлөлт хэрхэн илэрснийг Сэлэнгэ аймгийн Г. Бумцэндийн нэрэмжит 12 жилийн 1-р сургуулийн туршигч багш М. Эрдэнэбилэгийн авсан

судалгаан дээрээс үзэж танилцана уу.

Үзүүлэлт	Туршилт хичээлийн өмнө (хувиар)	Туршилт хичээл явагдсаны дараа (хувиар)
Сурагчдын суралтад идэвх сонирхолт	84%	96%
Хичээлийн бэлтгэл хангальт	90%	97%
Гэрийн даалгаврын гүйцэтгэл	69%	94%
Сурагчдын хичээл таслалт	3%	1%

### Цаашид анхаарах зүйл

- Бага ангийн сурагчдыг үнэлэх үнэлгээнд анхаарах
- Хүүхэд нэг бүрийг бодитой үнэлэх аргыг боловсронгуй болгоход анхааран ажиллах
- Сурагчдын санал бодлоо илэрхийлэхэд илүү цаг төлөвлөхөд анхаарах
- Анги нийтийг хамарсан хичээл зохион байгуулахад илүү анхаарах
- Хичээлийг сурагчдын сонирхолд нийцүүлэн олон хувилбараар сонирхол татахуйц хэлбэрээр зохион байгуулж байх
- Бага ангийн хүүхдийн нас, сэтгэхүйн түвшинд тохирсон үзүүлэн бэлтгэхэд анхаарах
- Тухайн хичээлд тохирсон тоглоомын илүү олон хувилбарыг тусгах
- Сургуулийн тоглоомын талбайг сайжруулахад сургуулийн удирдлага, багш нар анхаарах
- Суралцаагчдын суралцахуйг дэмжих энэхүү шинэ арга зүйг бусдад түгээн дэлгэрүүлэхэд анхаарах


## 3.2. Японы хичээлийн туршлага

### 3.2.1. Японы бага боловсролын Байгалийн ухааны хичээлийн онцлогоос

Япон улсад бага боловсролын байгалийн ухааны хичээл нь «Амьдрах ухаан» нэртэйгээр анх 1992 оноос орж эхэлжээ. Энэ хичээл нь хүүхэд төвтэй, дадлага олгохыг голчилдог хичээл гэдэг утгаараа бага ангиин хүүхдүүдэд байгалийн ухаан, нийгэмшихүйг амьдрал дээр нь хөрвүүлэн, сургууль болгонд амьдрах ухааны хичээлийг «камилуулах» туршлага хуримтлуулж ирсэн. Мөн 10 жил өнгөрсөн сурган хүмүүжүүлэх үйл явцыг сайжруулах үүднээс бага сургуулийн гуравдугаар ангиас «Нэгдсэн сургалтын цаг» –ийг бий болгосон нь бага анgid үзсэнийг нэгтгэх «Амьдрах ухаан»-ы хичээлийн шинж чанарыг улам бүр сайжруулсан зүйл болсон. Гэхдээ, нэг талаас цэцэрлэгтэй холбогдох байдал (хүүхдийн өсөлт хөгжилтийг бодож үзвэл) ба гуравдугаар ангиас эхлэх байгалийн ухаан, нийгэмшихүйн хичээл рүү шилжихэд нь нэг их анхаарал тавиагүй, битүү хичээл болон хувирах хандлага ажиглагдан, үүнийг шүүмжлэх нь нэмэгдсэн. Тиймээс 2002 онд сайжруулахдаа «мэдлэгтэйгээр анзаарах» гэдэг түлхүүр үгийг нэмсэн.

«Амьдрах ухаан» бол хүүхдийн «өөрөө» гэсэн сэтгэлийг тулгуур болгон байгаль, нийгэмтэй хэрхэн холбогдож байгааг биеэр нь мэдрүүлэн ойлгуулахаар (тоглох үйл ажиллагаагаар) эзэмшүүлэхийг зорьдог.

Цэцэрлэг,  
тал, цөөрөм,



НИЙГЭМ

Гэр орон, сургууль,  
хороо хорин, (дэлгүүр,  
үйлчил гээний газрууд)

Японд яагаад «Амьдрах ухаан» хичээл бий болсон бэ гэвэл оршин сууж байгаа орчинд байгалийн гэх зүйл цөөрч, хүүхдүүд ч тэнд тоглох нь багасан байгалийг анхаарахгүй болсон. Гэртээ тоглох нь их болж гадаа тоглодоггүй хүүхдүүд ихэссэн. Тохиромжтой багаж хэрэгсэл их болж юмыг засаж хэрэглэх арга зам байхгүй болсон. Гэр доторх байдлыг авч үзвэл, хөгшин хүмүүстэй ойртохoo больж, эртний тоглоом наадгай уламжлагдан ирэхгүй болж ирсэн. Гэр бүл ба орон нутгийн нөхцөл байдлын өөрчлөлт нь хүүхдийн өсөлт хөгжилтөд саад болох нөлөө үзүүлж эхэлсэн. Эдгээрээс сэтгэл зовон Германд эртнээс явуулж байсан жишээнээс санаа авсан. Мөн Японд Нагано аймагт Тайшо-гийн үеэс хэрэглэгдэж байсан сургалтыг загвар болгон эхэлсэн юм. Шинано сурган хүмүүжүүлэх арга нь дээр үеэс амьд амьтан тэжээж амьдрах шимийг хүртэх ухааныг бага наснаас эхлүүлэн мэдрүүлэн нэгдмэл сургалтыг явуулж байсан түүхтэй (Fukuchi Akiteru).

Японд байгалийн ухааны хичээлийг бага ангиас нь эхлэн бодит байдалд ажиглалт, туршилт хийлгэн, гарын доорх материалуудыг ашиглан бодит зүйлийг хийж хичээлдээ ашигладаг. Жишээ нь, «Хорхой шавж тэжээцгээ» сэдэвт хичээлээр сурагчид сургуулийн ойр газраар аялал хийж хорхой шавжийг байгаль дээр нь ажиглаж, ямар орчинд амьдардаг, юу иддэг, хэрхэн хөдөлдөг зэргийг тэмдэглэж авна. Дараа нь хүүхэд тус бүр царцаа, шавж зэрэг жижиг амьтдыг

гэртээ авч очин тэдгээрийн амьдардаг орчинг бүрдүүлэн шилэн хорго юмуу цаасан хайрцганд тэжээж өдөр тутам ажиглан тэдний үйл хөдлөл, биеийн бүтэц, өнгө, хэлбэр дүрсийг нарийн сайн ажиглаж тэмдэглэл хөтөлнө. Энэ туршилтыг долоо хоног юмуу хэсэг хугацаанд үргэлжлүүлэн дараа нь ангидаа авчирч ажиглаж мэдсэн зүйлсээ ярилцана. Мөн түүнчлэн «Үр тарьж ургуулья» хичээлээр сургуулийн гадаа талбайд ургаж байгаа мод, цэцгийн үрийг түүж ангидаа багшийн зааврын дагуу тарьж ургуулан, ургамлын өсөлт хөгжилтийг бодитоор харж ажиглан мэдлэгийг өөртөө бүтээж хичээлээ явуулдаг. Японы нэг онцлог нь манай оронтой харьцуулвал дулааны улирал нь удаан үргэлжилдэг, сургуулийн гадаах цэцэрлэг, талбай зэрэг сургалтын орчинг сайн бүрдүүлж өгсөн байдаг нь энэ хичээлийг явуулахад нэн тохиromжтой. Гэсэн ч манай орны хувьд өөрийн орон нутгийн онцлогтоо тохируулан сургалтын энэ аргаар хичээлээ явуулах боломж байгааг бид энэхүү төслийн хүрээнд туршиж мэдсэн нь бидний ажлын ололт амжилт болов уу. Аль болох сурагчдаар өөрсдөөр нь яриулж, биеэр хийлгэж, таниулж мэдүүлэх, мэдлэг бүтээлгэх нь сургалтын бодит үр дүнд хувь нэмрээ оруулна. Энэ талаар дараах зургуудаас харвал илүү ойлгомжтой байх болно.




Японы нэгэн сургуулийн сурагчид хичээлийн цагаараа  
сургуулийн гадаа талбайд ургаж байгаа мод,  
цэцгийн үрийг түүж «Үр тарьж ургуулцгаая» сэдэвт  
хичээлд хэрэглэнэ.

Сурагчид хамтарч ажиллах явцдаа  
бие биенээсээ харилцан суралцдаг.

Японы Токио хотын Коганей бага сургуулийн  
«Амьдрах ухаан» хичээлийн явцаас:



Сургуулийн гадаа талбайд ажиглалт хийж байгаа нь



«Амьтан тэжээцгээ» сэдэвт хичээлээр сурагчид туулай зэрэг  
жижиг амьтдыг тэжээж хичээлээ явуулна.



Ангид орж ирэн гадаа ажигласан зүйлээрээ бүтээл хийнэ.



Сурагчид өөрсдийн сурч мэдсэн зүйлээ  
өөрийн бодлоор зурж бичиж тайлбарлана.



Сурагчдын зурсан зураг



Сурагчдын хийсэн бүтээл



Алжаал тайлах үе



Сурагчид өөрсдийн хийсэн бүтээлээр тоглоом тоглодог.

### 3.2.2. Японы сурх бичгийн онцлог

Бага ангид байгалийн ухааны хичээл нь «Хөгжилтэй амьдрал», «Амьдрах ухаан» зэрэг нэртэйгээр ордог. Энэ хичээлийн сурх бичиг нь хүүхдүүдийн бие дааж хийх дасгал ажил, даалгавар ихтэй байх бөгөөд сурагчдын хичээл хийх дурсонирхлыг төрүүлэхүйцээр хийгдсэн байдаг нь японы боловсролын нэгэн чухал хэсэг гэж ойлгогдоно. Сурх бичиг хийдэг хэвлэлийн газрууд нь сургалтын үр дүнд гол анхаарлаа хандуулан ажилладаг болох нь үнэхээр бахархууштай. Жишээ нь, нэгдүгээр ангийн нэгэн сурх бичигтэй танилцъя.

Сурх бичиг нь дараах бүтэцтэй. Үүнд:

1. Миний сургууль
2. Цэцэрлэг рүү явцгаая
3. Амьд бие ба найз нөхөд
4. Намрыг эрж олцгооё
5. Миний гэр бүл
6. Тоглоом бүтээцгээе
7. Удахгүй 2-р ангид орлоо шүү



Хичээлийн сэдвүүдийг нэрлэсэн байдлаас харвал японы сургалт маш энгийн, хүүхдүүдэд ойр, ойлгоход хялбар байдлаар хийгдсэн байдаг. Японд хүүхдүүд сурх бичгийг хичээл дээрээ бараг хэрэглэхгүй харин гэртээ нэмэлт даалгавар хийх байдлаар ашигладаг. Үүний тулд сурх бичиг, дасгал ажлын дэвтрүүд энгийн ойлгомжтой, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон хялбар байдлаар хийгдсэн байна. Жишээ нь, дараах зурагт сурагчид цэцэрлэгээр зугаалах явцдаа тэнд байгаа амьтан, ургамалтай танилцаж байгааг харуулсан байна.



7

Сурагчид гадаа цэцэрлэг, талбайд ажиглалт хийн  
хамтдаа ярилцаж байгаа нь.

3



4



Сурагчид гадаа цэцэрлэгт ажигласан зүйлээ навч,  
бороогой зэргийг ашиглан бүтээл хийсэн байна.

### 3.3. Хичээлийн судалгаа (Жюгё кэнкю-Jyugyo kenkyu)

Хичээлийн судалгаа буюу жюгё кэнкю гэдэг нь энгийнээр тайлбарлавал, тухайн сэдэвт хичээл явагдаж дууссаны дараа хичээл заасан багш болон ажиглалт хийсэн багш нар хичээлийн ололттой сайн тал, цаашид анхаарах зүйл, сайжруулах арга зам зэргийг хамтран ярилцаж албан тэмдэглэл хөтлөн баримтжуулж үлдээхийг хэлнэ. Энэхүү хичээлийн судалгааг зохион байгуулах талаар япон улс асар их туршлагатай бөгөөд үүнийг их чухалчилж үздэг байна. Тухайлбал, японд энэ хэлэлцүүлгийг хэд хэдэн түвшинд хийдэг: нэг сургууль, ойролцоо байрлалтай сургууль, нэг дүүрэг, нэг муж, улсын хэмжээнд ч зохион явуулна. Хичээлийн хэлэлцүүлгийн гол ач холбогдол нь хичээл заах аргазүйг сайжруулах, цаашид хүүхдийн хөгжлийг дэмжих, боловсролтой, соёлтой иргэн төлөвшүүлэхэд оршино.

#### Хичээлийн хэлэлцүүлгийг хэрхэн хийх вэ?

Ээлжит хичээл бүрийн дараа хичээлийн хэлэлцүүлгийг явуулах нь тухайн хичээлийн үр дүнг хэлэлцэх сайн талтай бөгөөд дараагийн хичээлийн бэлтгэл болдогоороо онцлогтой.

Хичээлийн хэлэлцүүлгийг хэрхэн явуулах вэ?

##### 1. Хичээл бүрийн өмнө хийгдэх зүйл

- 1) Хичээлийг ажиглах сэдвээ тогтох
- 2) Сэдвийг нийтэд мэдэгдэх

##### 2. Хичээлийн үед хийгдэх зүйл

- 1) Хичээлийн ажиглалт
- 2) Мониторингийн Б1, Д хуудсыг бөглөх

##### 3. Хичээлийн дараа хийгдэх зүйл

- 1) Мониторингийн А1 ба Д1 хуудсыг бөглөх
- 2) Хичээлийн дараах хэлэлцүүлгийг явуулах

Тухайн хичээлийн хэлэлцүүлгийг удирдах багш хичээл явуулах багштай хамтран ярилцаж хичээлийн ямар хэсгийг ажиглахаа тогтоно. Тухайлбал,

1. Сэдэлжүүлэх хэсгийг явуулж болж байна уу,
2. Хүүхдэд тавих асуулт оновчтой байна уу,
3. Хүүхдэд ойлгомжтойгоор самбарыг хэрэглэж байна уу гэх мэт.

##### 1. Хичээлийн ажиглалт

1. Ажиглагч багш ажиглах зүйлийнхээ дагуу анхааралтайгаар ажиглана.
2. Мониторингийн D хуудсыг бөглөнө.
3. Ажиглагч хичээлийн протоколыг хөтөлнө (Мониторингийн D хуудас).

##### 3.Хичээлийн дараа хийх зүйл

- 1) А1 хуудас Д1 хуудсыг бөглөнө.

- ◆ Хичээл явуулсан багш А1 хуудас
- ◆ Ажиглагч багш В1 хуудсыг бөглөнө.

2) Хичээлийн дараах хэлэлцүүлэг явуулах

1. Хэлэлцүүлэгт оролцогчдыг зурагт үзүүлснээр суулгавал тохиромжтой.



Энэ нь хэлэлцүүлгийн явцад гарах асуудлыг туршигч багш ба удирдагч хоёр хоорондоо ярилцах бололцоог бүрдүүлнэ.

2. Зорилго болон хичээлд ажиглах байсан зүйлийг сануулах.

Хэлэлцүүлгийн удирдагч хичээлийн зорилго болон хэлэлцүүлгийн үед ярилцах сэдвийг оролцогчдод сануулна.

3. Бөглөсөн А хуудас ба Б хуудсуудыг үзэж бүрэн хөтөлсөн эсэхийг шалгана (5 минутад багтаана)

Бөглөсөн А ба Б хуудсыг бүх гишүүд өрөнхийлөн харна. Заавал удаан унших албагүй, юуны тухай бичсэн байгаа тухай их цаг зарцуулалгүйгээр уншихад болно. Энэ нь тухайн хичээлийн талаар бусад ажиглагч багш нарын саналыг харахад хэрэгтэй. Гол нь хуудас дээрх тайлбарын хэсгийг сайтар харах хэрэгтэй (Мониторингийн хуудас хэрхэн хөтлөх талаар «ЕБС-ийн хичээлд мониторинг хийх өрөнхий зөвлөмж» номноос дэлгэрэнгүй үзээрэй).

#### Хэлэлцүүлгийг дараах дарааллаар явуулбал зохистой. Үүнд:

- Анх ярилцаж тогтсон 3 хэсгийнхээ талаар анхаарсан зүйлээ бусдад хэлэх
- Зөвхөн асуудалтай байгаа зүйл бус сайн талыг нь тодруулах
- Ажиглагч багш хичээл явуулсан багшийн арга зүйг сайжруулах үүднээс зөвлөгөө өгнө Өөрөө оронд нь заасан бол яах байсан бэ гэдэг үүднээс бодож хэлэх)

- Хичээл явуулсан багш ажиглагч багш нарын зөвлөгөөг сонсоод дараагийн удаад хичээлээ явуулахдаа юуг ямар аргаар сайжруулах талаар хэлнэ
- Хэлэлцүүлгийн албан тэмдэглэлийг хөтөлж буй багш ажиглагч багш нарын хэлсэн саналуудыг нэгд нэгэнгүй сайн тэмдэглэж авч түүнийг баримтжуулан хадгална. Энэ нь тухайн хичээлийг цаашид сайжруулах чухал баримт бичиг болох учиртай.
- Удирдагч багш хэлэлцүүлгийн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж хаалтын үг хэлнэ.

**Анхаарах зүйл:** Хичээлийн судалгаа нь өмнө өгүүлсэн (хуудас 10) хичээлийн зөвхөн 10%-г ажиглах бөгөөд үүнийг л ажигласнаар тэр хичээлийг сайн, муу гэж үнэлэх боломжгүй. Иймээс тухайн багшийн хичээлийн хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, хичээл төлөвлөлт зэргийг урьдчилан сайтар үзэж танилцсан байх хэрэгтэй. Мөн, багш хичээлээ хэчнээн сайн төлөвлөсөн ч тухайн өдөр сурагчдаас гарах санаа, үг, хариулт, идэвх оролцоо хэр байсан зэргээс хамаарч өөрчлөгдж болдог. Энэ тохиолдолд багш яах ёстой вэ?

Нэгдүгээрт, өөрийн хичээлд сайн дүн шинжилгээ хийх,

Хоёрдугаарт, бусад багш нарын хичээлд сууж дүн шинжилгээ хийх явдал чухал. Өөрийн болон бусдын алдаан дээрээс суралцах, түүнийг дахин давтахгүй байх нь арга зүйн хөгжил явагдахын нэгэн үндэс болов уу.

### **Загвар сургууль дээр хийгдсэн хичээлийн хэлэлцүүлгийн бодит тэмдэглээс**

**Огноо:** 2008.11.17

**Загвар сургууль:** «Сэтгэмж» цогцолбор сургууль

**Туршигч багшийн нэр:** О.Нарангэрэл

**Анги:** 1д

**Хичээлийн сэдэв:** Миний эргэн тойронд юу байдаг вэ?

**Хэлэлцүүлэгт оролцсон ажиглагчид:**

**Удирдагч** Г.Нэргүй

**Ажиглагч** Зөвлөх багш проф. А.Фүкүчи

Э.Мөнгөнтулга

Б.Баярчимэг

Л.Янжинлхам (45-р сургуулийн)

Д.Цэрэнпүрэв (1д анги)

**Хэлэлцүүлгийн явцын тэмдэглэл:**

Хэлэлцүүлгийг нээж Г.Нэргүй үг хэлсэн. Эхлээд туршигч багш өөрийн хичээлийн зорилго, зорилтыг танилцуулж, зорилгодоо хүрсэн эсэх талаар хэлнэ.

Дараа нь ажиглагч багш нар өөрсдийн ажиглаж тэмдэглэсэн зүйлсээ хэлнэ гэдгийг анхааруулна.

Туршигч багш О.Нарангэрэл:

Миний эргэн тойронд юу байдаг вэ? сэдэвт хичээлийг заалаа. Энэ хичээлийг Бага боловсролын байгалийн ухааны Хүн-Орчин багийн ажлын хэсгийн боловсруулсан «Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй» зөвлөмжийн дагуу хичээлээ заахаар төлөвлөсөн. Хичээлийн явц боломжийн сайн байлаа. Өнөөдөр цаг агаарын хувьд бага зэрэг хүйтэн байсан. Эхний цагийн хичээл зөвлөмжийн дагуу сургуулийн гадаа талбайд, хоёрдугаар цагийн хичээл анги танхимд үргэлжлэн явагдаж, байгалийн материалаар бүтээл хийлгэсэн. Сурагчид урьдчилан төсөөлж байснаас илүү сайн бүтээл хийдэг юм байна гэдгийг мэдэж авлаа. Жишээ нь: Боргоцой, навч, мөчир ашиглан шувуу, хүүхэд, цох зэргийг хийсэн. Сурагчид навч ашиглан юм хийж, бүтээх болов уу гэж өмнө нь бодогдож байсан. Гэвч үнэхээр санаанд оромгүй зүйлсийг хийдэг, бүтээдэг юм байна. Хичээл маань урьдчилан төлөвлөсний дагуу явагдлаа.

Туршигч багш Л.Янжинлхам (45-р сургууль)

-Сурагчдад бэлэн материал өгөөд мөн сэдэлжүүлэх зураг үзүүлэх эсвэл дөхүүлэх асуулт тавих хэрэгтэй юм байна гэж надад бодогдоо. Энэхүү туршилт хичээлийг өөрийн ангийн сурагчиддаа энэ сэдвээр хэрхэн заах вэ гэдэг талаас нь ажиглаж, бодож, эргэцүүлж байлаа. О.Нарангэрэл багшийн хичээл сайн заагдлаа.

Анги даасан багш Д.Цэрэнпүрэв («Сэтгэмж» цогцолбор сургууль)

-Би энэ хичээлийн жилийн эхнээс 1д ангийг даан авч ажиллаж байна. Мөн туршилт хичээлийн явцад ажиглагч багшаар ажиллана. Хүн-Орчин хичээлийн «Миний эргэн тойронд юу байдаг вэ?» сэдэвт хичээл сурагчдын сонирхлыг татсан, хөгжилтэй сайхан явагдлаа гэж бодож байна.

Ажлын хэсгийн гишүүн Г.Нэргүй:

-Гурав дахь жилийн туршилт хичээлийн салхийг хагалж эхний хичээлээ заасан О.Нарангэрэл багшдаа баярлалаа. Хичээлээ зөв, оновчтой зохион байгуулсан байна. Хоёрдугаар цагийн хичээл анги танхимд заагдах байсан. Зөвлөмжийн дагуу заагдлаа. Сурагчдаас навч, боргоцойг юу гэдэг вэ гэж асуухад байгалийн бүтээл гэж хариулж байна. Сурагчид өөрийн дуртай зүйлсээ багшийн урьдчилан бэлтгэсэн материалыг ашиглан хийлээ. Ангийн сурагчдын төсөөлөн бodoхуй сайн байна. Сурагчид өөрсдийн өмнөх мэдлэг чадвар дээрээ тулгуурлан хийсэн зүйлээ сайн тайлбарлаж байлаа. Дараах санаа бодол төрж байсан. Үүнд:

Эхний цагийн хичээл дээр сурагч руу бөмбөг шидэхээс өмнө нэрийг нь дуудаж анхааруулах хэрэгтэй байсан. Сайн хичээл боллоо.

Ажлын хэсгийн гишүүн Б.Баярчимэг:

-Анх сургуульд орсон зургаан настай сурагчид хэдий ч анги хамт олон болж төлөвших хандлага сайн тавигдаж байгаа нь ажиглагдлаа. Туршигч багшийн хичээлийн эхэнд тавьсан асуулт хичээлийн дараа дараагийн үе шатанд оновчтой холбогдож байна. Цаашид байгалийн бэлэн материал дээр тулгуурлан сурагчдаар бүтээл хийлгэхэд илүү анхаараарай. Сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан заасан.

Ажлын хэсгийн ахлагч Э.Мөнгөнтулга:

-Анги даасан Д.Цэрэнпүрэв багшдаа баярлалаа. Анги хамт олноо сайн төлөвшүүлсэн байна. Сурагчид гярхай сайн ажигладаг юм байна. Нарангэрэл багш хичээлийн бэлтгэлийг сайн хангасан ба сурагчдын нас, сэтгэхүйн онцлогийг сайн тооцоолж хичээлээ удирдан явууллаа. Сурагчдаар бие даалган хийлгэх тал дээр илүү анхаарвал зохиостой. Багш энэ үед хажуугаар нь явж зөвлөж, туслах л үүргийг гүйцэтгэнэ. Эхний хоёр цагийн хичээл сайн явагдлаа.

Зөвлөх багш проф. А.Фүкүчи:

-Мониторингийн хуудасны (хичээлийн явцын) үзүүлэлтийн дагуу хичээлийг ажиглалаа. Хүүхдийн анхаарлыг хэрхэн төвлөрүүлэх, тэдгээрийн өсөлт хөгжлийг тооцох, мэдлэгийг хэрхэн бүтээж байгааг анхаарах нь зүйтэй. Мөн сургуулийн өмнөх боловсролд юу хийж бүтээж байсныг мэддэг байх хэрэгтэй. Хүүхэд өөрөө өөрийгөө хөгжүүлэх чадвартай болдог. Жишээ нь: Өнөөдөр навч хараад яг юу хийх вэ гэдэг нь шууд толгойд нь орж ирэхгүй байснаа өнгийн цаас тарааж өгөхөд бүтээж эхэлсэн. Сурагчид хичээл дээр бүтээл хийхдээ юуг хэрэглэж, юуг нь хэрэглэсэнгүй вэ, дараа нь явал илүү хийлгэж болох вэ гэдгийг тунгаах хэрэгтэй болдог. Хичээлийн явцад сурагчдаар алжаал тайлах дасгал хийлгэсэн нь оновчтой байсан.



# **ХАВСРАЛТ**



**Хавсралт 1.**

«Соёл үйлчилгээний газартай танилцъя» сэдэвт хичээлд ашиглаж болох зургууд:



Хүүхдийн парк



Номын их дэлгүүр



Байгалийн түүхийн музей



Хүнсний их дэлгүүр



Сүхбаатарын талбай



Туул голын эрэг

## Хавсралт 2.

Туршилт хичээлийн явцаас:



«Миний эргэн тойронд юу байдаг вэ?» сэдэвт хичээлээр сургуулийн  
гадаа талбайд ажиглалт хийж, ярилцаж байгаа нь  
(Улаанбаатар, 45-р сургууль)



«Миний эргэн тойронд юу байдаг вэ?» сэдэвт хичээлээр сурагчид  
гарын доорх материал ашиглан бүтээл хийж байгаа нь  
(Сэлэнгэ аймаг, 1-р сургууль)



Миний эргэн тойронд юу байдаг вэ? сэдэвт хичээл дээр  
(Сэлэнгэ аймаг, 4-р сургууль)



«Гэрээс сургууль хүрэх замд» хичээлээр сурагчид өөрсдийн  
ажиглаж тэмдэглэсэн зүйлээ зурж, тайлбарлаж байгаа нь  
(Улаанбаатар, 45-р сургууль)



«Гэрээс сургуульд хүрэх замд» сэдэвт хичээлээр сурагчид зурж,  
бүтээж байгаа нь  
(Улаанбаатар, Сэтгэмж цогцолбор сургууль)



«Гэрээс сургуульд хүрэх замд» сэдэвт хичээлээр сурагчид өөрсдийн хийсэн  
бүтээлээ самбарт гарч тайлбарлаж байгаа нь  
(Улаанбаатар, Сэтгэмж цогцолбор сургууль)



«Гэрээс сургууль хүрэх замд» сэдэвт хичээл  
(Дорнод аймаг, Матад сумын сургууль)



«Соёл үйлчилгээний газартай танилцъя» сэдэвт хичээл  
(Дорнод аймаг, «Хан-Уул» цогцолбор сургууль)



«Соёл үйлчилгээний газартай танилцъя» сэдэвт хичээлээр  
музейтэй танилцаж байгаа нь  
(Улаанбаатар, 97-р сургууль)



«Соёл үйлчилгээний газартай танилцъя» сэдэвт хичээлээр сурагчид ажиглаж  
мэдсэн зүйлээрээ дүрийн тоглолт хийж байгаа нь  
(Улаанбаатар, 97-р сургууль)



«Гэрээс сургууль хүрэх замд» сэдэвт хичээл  
(Сэлэнгэ аймаг, Хушаат сумын сургууль)



Сурагчдаар үнэлгээ хийлгэж байгаа нь  
(Дорнод аймаг, 5-р сургууль)



«Дүгнэлт» хичээлээр сурагчдын эцэг, эх нар ирж хүүхдүүдийнхээ хийсэн  
бүтээлүүдтэй танилцаж, харилцан ярилцсан  
(Улаанбаатар, Сэтгэмж цогцолбор сургууль)

**Хавсралт 3**

Сурагчдын хийсэн бүтээлүүд:



Сурагчид гарын доорх материал ашиглан олон зүйлийг хийж бүтээдэг.  
(Улаанбаатар, «Сэтгэмж» цогцолбор сургуулийн сурагч)



Сурагчид багаар болон хосоор хамтарч олон зүйлийг хийж чаддаг  
(Улаанбаатар, 45-р сургуулийн сурагчид)



«Миний гэр сургуулийн орчин» сэдэвт хичээлээр сурагчдын хийсэн бүтээл  
(Сэлэнгэ аймаг, 4-р сургууль)



«Миний гэр сургуулийн орчин» сэдэвт хичээлээр сурагчдын хийсэн бүтээл  
(Сэлэнгэ аймаг, 4-р сургууль)



«Гэрээс сургууль хүрэх замд» сэдэвт хичээлээр сурагчдын хийсэн бүтээл  
(Улаанбаатар, «Сэтгэмж» цогцолбор сургууль)



Улаанбаатар, «Сэтгэмж» цогцолбор сургууль

**Байгалийн материал ашиглан сурагчдын хийсэн бүтээл**



Сурагчийн зурсан зураг  
Дорнод аймаг, Хан – уул цогцолбор сургууль

**Хавсралт 4****Алжаал тайлах дасгал**

Дараах алжаал тайлах дасгалуудаас ээлжит хичээлийн сэдэв болон хичээлийн тухайн үе шатанд тохируулан сонгон хэрэглээрэй. Дасгалын давталтын тоог тухайн нөхцөлд тохируулан тогтоож болно.

**1. «Эрвээхий»** алжаал тайлах дасгалын бэлтгэх байдал: Сурагчид ширээнийхээ хажууд эгнээ үүсгэн үндсэн зогсолтоор зогсоно (1-5 удаа давтана.)

Алжаал тайлах дасгалын заавар	Сурагчдын дасгал хөдөлгөөн
Эрвээхий эрвээхий	Хоёр гараараа дэвэх хөдөлгөөн хийнэ.
Эргэн эргэн нисээрэй	Дэвэх хөдөлгөөн хийхийн хамт зогсож буй байрандаа тойрон эргэнэ.
Эрвээхий эрвээхий	Хоёр гараараа дэвэх хөдөлгөөнийг давтан хийнэ.
Цэцгэн дээрээ суугаарай	Гараа өвдөг дээрээ авч байрандаа явган сууна.
Сурагчид багштайгаа хамтдаа дуулж тухайн дасгалыг гүйцэтгэж болно.	

**2. «Үүр цайлаа, нар жаргалаа»** алжаал тайлах дасгалын бэлтгэх байдал: Сурагчид сууж мөн үндсэн зогсолтоор зогсож болно. (1-5 удаа давтана.)

Алжаал тайлах дасгалын заавар	Сурагчдын дасгал хөдөлгөөн
Үүр цайлаа	Хоёр гараа дээш өргөж хоёр тийш тал тойрог хөдөлгөөн хийнэ.
Нар жаргалаа (30 сек-3 мин)	Хоёр гараа урдаа авч зөрүүлэн толгойгоо бөхийлгөнө.
Энэхүү алжаал тайлах дасгалыг сурагчдын хөдөлгөөн ихэссэн үед эсвэл сүүлийн цагуудын хичээлд хэрэглэвэл тохиромжтой.	

**3. «Миний гар цэвэрхэн» алжаал тайлах дасгалын бэлтгэх байдал: Сурагчид сууж мөн үндсэн зогсолтоор зогсож болно (1-2 удаа давтан хийж болно).**

Алжаал тайлах дасгалын заавар	Сурагчдын дасгал хөдөлгөөн
Ханцуйгаа сайн шамлаарай Крантаа тохируулан нээгээрэй Гараа сайн норгоорой Усаа түр хаагаарай Гараа савандаж хөөсрүүлээрэй Гарын араа үрээрэй Хуруу бүрийг угаагаарай Крантаа нээж норгоорой Гараа цэвэрхэн болгоё Савандаж дахин хөөсрүүлээрэй Цэвэр усаар зайлаарай Одоо бүгдээрээ усаа хаагаад Алчуур авч зөөлөн дарж арчаарай	Багшийн эсвэл ангийн нэг сурагчийн зааврын дагуу тухайн дасгал хөдөлгөөнийг агаарт хийж гүйцэтгэнэ. Дараа нь «Миний гар цэвэрхэн» гэж сурагч бүр хэлж ойролцоох найздаа гараа эргүүлэн харуулна.
Өдөр бүр гарын ариун цэвэр сахих дадал хэвшил болгох давхар зорилгоор хийлгэж болно. Мөн гарын ариун цэвэр сахисны ач холбогдолын талаар мэддэг, бусдад тайлбарладаг болно.	

**4. «Бороо орлоо» алжаал тайлах дасгалын бэлтгэх байдал: Сурагчид сууж өвдөг дээр гараа байрлуулна (1-3 удаа давтан хийж болно).**

Алжаал тайлах дасгалын заавар	Сурагчдын дасгал хөдөлгөөн
Бороо орлоо	Хоёр гараараа өвдөг дээр ээлжлэн зөөлөн цохино.
Бороо шивэрлээ	Хөдөлгөөнөө хурдасгана.
Бороо ширүүслээ	Илүү хурдан цохино.
Бороо намдлаа	Хөдөлгөөнөө багасгана.

**5. «Амьтдыг дуурайцгаая» алжаал тайлах дасгалын бэлтгэх байдал: Сурагчид үндсэн зогсолтоор зогсоно. (1-3 удаа давтан хийж болно.)**

Алжаал тайлах дасгалын заавар	Сурагчдын дасгал хөдөлгөөн
Хурга, Ишиг, Ботго, Унага, Тугал	Амьтдын хөдөлгөөн, дуу авиааг дуурайна.
Муур, хулгана, нохой, тахиа, гахай	Амьтдын хөдөлгөөн, дуу авиааг дуурайна.
Сурагчдын сонирхол хэрэгцээнд нийцүүлэн амьтдын нэрийг сонгон нэрлэж болно.	

**6. «Дөрвөн улирал» алжаал тайлах дасгалын бэлтгэх байдал: Сурагчид сууж мөн үндсэн зогсолтоор зогсож болно. (1-3 удаа давтан хийж болно.)**

Алжаал тайлах дасгалын заавар	Сурагчдын дасгал хөдөлгөөн
Ангийн бүх эрэгтэй сурагч зэрэг хэлнэ.	Ангийн бүх эмэгтэй сурагч дараах шүлгийгүншиж, өөрийнхүссэн тохиорх хөдөлгөөнийг хийж гүйцэтгэнэ.
<i>Намар</i>	Алтан навч хийслээ хийслээ Аяны шувуу буцлаа буцлаа
<i>Өвөл</i>	Мөнгөлөг цас орлоо орлоо Өвлийн өвгөн ирлээ ирлээ
<i>Хавар</i>	Урьхан салхи сэвшлээ сэвшлээ Ургамал навч дэлгэрлээ дэлгэрлээ
<i>Зун</i>	Зун цаг зун цаг боллоо Зугаатай цэнгэлтэй гоёхон доо
<b>Дараа нь ангийн эмэгтэй эрэгтэй сурагчид сольж гүйцэтгэнэ.</b>	

### Ашигласан ном

1. Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй. Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил төсөл. Зөвлөмж I. УБ., 2007
2. Бага, дунд боловсролын стандарт. Газарзүйн боловсрол УБ., 2004
3. Бага, дунд боловсролын стандарт. Түүх, Нийгмийн ухааны боловсрол УБ., 2004
4. Бага, дунд боловсролын стандарт. Эрүүл мэндийн боловсрол УБ., 2004
5. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн нэгдүгээр ангийн сургалтын хөтөлбөр. БСШУЯ, БХХ. УБ., 2008 он
6. Зургаан настай хүүхдийн сурах, сургах арга зүй. Рөд. Д.Алтанцэцэг. УБ., 2008 он
7. Монгол орны бус нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй. Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил төсөл. Зөвлөмж II. УБ., 2008
8. О.Мягмар нар. Зургаан настай хүүхэдтэй ажиллах арга зүй. УБ., 2008
9. О.Мягмар. Сургуулийн өмнөх насны хүүхдийн сэтгэцийн хөгжлийн зарим асуудал. УБ., 2007
10. О.Мягмар. Бага ангийн сурагчдыг судлах арга зүй. УБ., 2006
11. Н.Нэргүй, Н.Оюунцэцэг нар. Стандартад суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах нь. УБ., 2007 он
12. «Сургалтын менежмент» сургалтын материал, гарын авлага УБ., 1999
13. «Сургалтын технологийн шинэчлэл» илтгэл сургалтын материал, гарын авлага УБ., 1999
14. «Танхим дахь мэдлэг бүтээх үйл явц» Хөдөөгийн сургуулийн хөгжил төсөл УБ., 2003
15. Японы 6 настай 1-р ангийн сурагчийн дасгал ажлын дэвтэр
16. Akiteru Fukuchi. Presentation. 2009